

*Их Монгол улсын 800 жилийн Чингис хааны
мэндэлсний 840 жилийн ойд*

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ ТАЙЛБАР

Оюут овогтой Дамдинбазарын Пүрэвдорж

Улаанбаатар 2001

Д.Нацагдорж

Түүхийн шүлэг

Манай монгол улс маш эртний улс аа
 Монголын яруу түүх магад их гэрэлтэй
 Гэгээн наран мандсаар хангай.govийг гийгүүлсэн
 Хэдэн мянган жилээс бид энд оршишоор
 Хэдийнээс балар цаг таван мянган жилийн өмнө^{*}
 Хойд газар оршиж хол ойрыг хувьсгасан
 Хүннүгийн үе хүрээд хүчирхэг улсыг мандуулсан
 Хянган уулын тэндээс Тэнгэр уулыг тулсан
 Энэхүү хүннүгийн улс хоёр мянган жилийн тэртээ
 Өмнө нанхиадыг сүрдүүлж, урт хэрмийг цогцлуулсан
 Ромын улсыг хүрч, европ дахынг сандруулсан
 Өврийн дурсгалт зүйлээ монгол орондоон хоцроосон
 Сияньби Тубагийн монгол шастир түүхийг залгамжилсан
 Түрк, Уйгартай нийлж төрөлх орноо сахисан
 Харь хязгаарт, Хятан улсыг байгуулсан
 Гадаадын дайсан алинд хэзээд эрэлхэг явсан
 Хаан Чингисийн үед хамаг улсын тэргүүнд
 Хөх монголын үрс хуяг дуулгаан засацгаасан
 Хоромсого, саадаг агсаж хулэг морио ташуурдсан
 Холхи ойрыг нэгтгээж хүний түүхэнд манлайлсан
 Мянган голыг гаталсан морин түурайн гавьяа
 Найман зүгт мандсан эцэг, өвгийн гавьяа
 Нармай төрийг байгуулсан дэлхий дахинд гавьяа
 Манай өнгөрүүлсэн түрх хүн төрөлхтөнд гавьяа
 Монгол хэмээх нэгэн нэр ертөнцийн чихнээ дуурsgalтай
 Монголын тул хэмээх сэтгэл манай зүрхэнд холбоотой
 Өсөхөөс сурсан үндсэн хэл оршиж болижүй соёл мөн
 Үхтлээ орших төрөлх нутаг салж болижүй орон мөн.
 Хангай дэлхий хэвээрээ аталь хүний явдал их хувирсан
 Хойших мөрийг харж урагших замыг давшилтай
 Харийн хөнөөл хэтрэхэд үндэсний хувьсгал гарсан шуу
 Түмэн оны энхийг ийнхүү тэмцэн бутээнэ.

1936

Д.Нацагдорж. Зохиолууд. УБ.1936. №191. 192-193 тал, *эгтээ* гэдэг үгийг *үхтлээ* гэж үзлээ.
 Б Н М А У
 УЛСЫН НҮҮЧИИН
 НОМЫН САН
 163694/95 X

Б.Ренчин

Монгол хэл

Чихину чимэг болсон аялгуу сайхан монгол хэл
 Чин зоригт өвгөд дээдсийн минь өв их эрдэнэ
 Сонсох бур яруу баялгийг гайхан баясаж
 Сод их билэгт түмэн юугэн бишрэн магтмуу би!
 Урьдын бэрх цагт улс монголынхoo хэт заяаг
 Уйтгарлан бодоход урам зоригий мину сэргээсэн,
 Өөдлөн дэгжихийн төгс хувьтайд нь итгүүлсэн
 Өрнөн мандахын шинж бүрдсэн өвгөдийн минь хэл!
 Мөрөн гол цутгалант, ширгэшгүй их далай мэт
 Мөнхөд үр ач нарын залгамжаар бадранхан дэлгэрч
 Хөндий цээжиннд орогч бүгдийг нэвтрүүлэх чадалт
 Хөгжим мэт яруу баясгалант монгол хэл минь!
 Өсөх наснаас өтлөх насан хүртэл чам юугаан судлан
 Өдөр бүр үгсийн эрдэний чинь баярлан түүнээ
 Түмэн түмэн үеийн оюун билгийн үлэмжс сангийн үүдий чинь
 Түүхэх бүр сэтгэл сэргэж, магнайн үрчлээ тэнийнэм!
 Түгшүүрт бэрхийг даван туулсан баатар түмний минь
 Түвшнээ соёл эрдэнэ югээн мандуулахын гэгээн улирал нээгдсэнд
 Сэлбэлгүй сэцэн оюутан, хэл югээн энхрийлэн хөгжүүлжүү хэмээн
 Сэтгэл урмас бадран баходмуу, үсэн буураал өтгөс би!
 Хутаг өлзий бүрдсэн, хувь их заяат түмний минь
 Хуриц авьяаст хөвгүүд дүү нар, халуун элэгтэн хотлоор
 Эгшигт сайхан монгол хэл югээн нэн хайрлан дээдлэж,
 Энхрийлэн бадруулахын бат зориг төгс юутай сайхан!
 Чихину чимэг болсон аялгуу сайхан монгол хэл
 Чин зоригт өвгөд дээдсийн минь өв их эрдэнэ
 Сонсох бур яруу баялгийг гайхан баясаж
 Сод их билэгт түмэн юугэн бишрэн магтмуу би!

Оршил

Энэ бяцхан номыг түүх, ялангуяа монголын нууц төвчоо, Чингис хааныг сонирхогч хүн бүхэн, юуны өмнө сурагч, оюутан, багш наар сонирхон уншина гээж итгэж байна.

Их зохиолч, түүхч Боржигин овогтой Д.Нацагдорж гуай маань "Миний нутаг" гэдэг алдарт шулэгтээ эх орныхоо уул ус, ургамал амьтан, уурхай баялаг, хөх тэнгэр, хөрст этүгэн (газар), хүн ард, аж амьдралыг нь магтан дуулжс, баадан баясажс, элэнц хуланцын минь хадгалж ирсэн, хүнүү, сүннүүгээс төр улстай, хэн ч халдашигүй хэзээний бидний нутаг гэдгийг нотлон өгүүлжс:

“.. Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон”

гээж баархан шулэглэсэн төдийгүй бас нас бараахынхаа урьд жил 1936 онд

“Манай монгол улс маш эртний улсаа

Монголын яруу түүх магад их гэрэлтэй”

гээж гэрэлтэй сайхан үзээр эхэлжс, итгэлтэй сайхан өгүүлжс, баттай сайхан хэлжс, урамтай сайхан шулэглэжс, “таван мянган жилийн өмнө” оршижс, “Хүннүүгийн үе хүрээд хүчирхэг улсыг мандуулсан” гээж анх төр улсаа байгуулсан төдийгүй мандан бадарч, цэцэглэн хөгжсикс, хөрш “Нанхиадыг” сурдүүлжс, урт хэрмийг цогцлуулжс, бур “Ромын улс хурч” Европ дахиниыг сандарган явжс, Чингис хааны үед мөн мандан бадарч, “Холхи ойрыг нэгтгээж, хүний түүхэнд манлайлсан” гээж бичээд, цааш нь:

“Мянган голыг гаталсан морин туурайн гавьяа

Найман зүгт мандсан эцэг, өвгийн гавьяа

Нармай төрийг байгуулсан дэлхий дахинд гавьяа

Манай өнгөрүүлсэн түүх хүн төрөлхтөнд гавьяа

Гарчиг

1. Оршил	5
2. Бөрт чоно, Гоо марал хоёр түүхэн хүн болох нь	10
3. Чингис хааны төрсөн он, сар, өдрийг батлан өгүүлэх нь буюу Чингис хааны түрүүн чухал он	29
4. Монголын нууц төвчоо ба бусад түүхэн сурвалжисын Чингис хааны төрсөн жил зэрэг чухал он, үйл явдлын төвчоон	46
5. Есүхэй баатар хан болох нь	51
6. Тэмүжин Хамаг монгол аймаг ба Их Монгол улсын хан болсон нь	57
7. Чингис хааны язгуур буюу угийн бичиг(мод)	84
8. Чингис хааны вөд болсон нь	99
9. Монголын нууц төвчоог бичиж дууссан оны тухай	103
Иш татсан номын жагсаалт	109

Монгол хэмээх нэгэн нэр өртөнцийн чихнээ дуурсгалтай
Монголын тул хэмээх сэтгэл манай зүрхэнд холбоотой
Өсвөөс сурсан үндэсний хэл орхиж болижүй соёл мөн
Үхтэлээ орших төрөлх нутаг салж болижүй орон мөн” гэж уран яруу, үнэн зөв, сэтгэл баясан, итгэл төрүүлэн, урам сэргээн, ухаан бадруулан тархинд үлдэж, зүрхэнд шингэтэл өгүүлсэн байна.

Нацагдорж гуай маань бараг хүүхэд наснаасаа эхлэн хувьсгалт төр, засаг, түмэн олондоо бие сэтгэлээ дайчлан, хүч чадлаа шавхан үйлчилж ирсэн хэдий ч бусад олон гэмгүй эрдэмтэдийн адил хилс хэрэгт гүтгэгдэж широнд сууж, широон дээр хэвтээж, эхнэр хүүх дээсээ хол, сэтгэл санаа нь шаналж, итгэл алдрам байдалд байсан хэдий ч эх орныхоо эх түүх, эх нутаг, эрдэмт дээдсээрээ бахдан бахархах сэтгэл нь хэвээрээ, хойч ирээдүйд нь итгэх, зовох хоёр нь хосолж байсан юмуудаа гэлтэй. Тиймээ төр засаг, түмэн олондоо “хойших мөрийг харж урагших замыг давшилтай” гэж гэрээс, захиаагаа захьсан мэт.

Ийнхүү хүн төрөлхтөнд гавьяа болсон гайхамшигт түүхтэй ард түмэн тийм ч олон бус буй заа. Монгол улсын төр ёсны тухай хамгийн бүрэн дүүрэн, үнэн зөвөөр өгүүлсэн нь “Монголын нууц товчоо” билээ.

“Монголын нууц товчооны тайлбар” хэмээх ерөнхий нэртэй 8 өгүүллийг унших уншигч танаа баярлаж байгаагаа илэрхийлье.

Монголын нууц товчоо бол монголын ард түмний оюуны бүтээл, хүн төрөлхтөний оюуны санд оруулсан хувь нэмэр гэдгийг албан ёсоор хүлээн зөвшөөрч НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын асуудал эрхэлсэн байгууллага (ЮНЕСКО)-ийн 1989 оны VI/13-ны өдрийн Парист хуралдсан 131-р хуралдааны тогтоолд “уран сайхан, гол зүй, яруу найргийн шинж чанар, хэлний баялаг, өвөрмөц онцлог нь уг зохиолыг дэлхийн аман зохиолын алтан сан” болгосныг тэмдэглэж “Монголын нууц товчоо”-г дорно дахини түүх,

утга зохиолын агуу их дурсгал хэмээн нандигнан үзэж, 750 жилийн турийн Монгол болон төв азийн бусад орны түүхийн чухал эх сурвалж болгон ашигласаар ирснийг хүлээн зөвшөөрч, “Монголын нууц товчооны 750 жилийн ойг 1990 онд өргөн тэмдэглэхийг ... (ЮНЕСКО)-ийн гишүүн орнуудад уриалсугай”, Mongolia, vol 1(22) 1990 номын 344-р тал гэсэн билээ.

Манай нэрт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн гуайн орчуулга кирилл үсгийн хэвлэлийг малчин авга ахынд байхад (1962 оноос өмнө) анх харж сонирхожж билээ.

Нууц товчооны өгүүлбэр бүр монгол түүх, монгол зан заншлын чухал баримт болно.

Эхний өгүүлэлд, 1-р зуйлийн ердөө 3 өгүүлбэрд өгүүлснийг л хэрэг дээрээ тайлбарласан юм. Монголын нууц товчооны жинхэнэ монгол эх дэвтэр (бичиг) байхгүй, харин монгол хэлээр бичсэн эх бичгийг хятаад дурс үсгээр галиглан бичсэн 3 зүйл эх бичиг байдаг. Энэ гурвуын аль нэгээс уйгаржсан монгол, шинэ бичиг, латин бичгээр буулгасан эх (сийрүүлэл), одоогийн монгол хэлний орчуулгын 11 номоос иши татан өгүүлсөн. Бас 3 номын 15-ийг дам иши татлаа. Үнэндээ бол 15-ийг унисан хэнд ч Бөрт чоно, Гоо марал нь хүний нэр гэдэг нь ойлгомжтой боловч анх нийтэд дэлгэрсэн хятаад орчуулгад чоно, буга гэж хүн бус адгуус болгож “залгалдаж” гэх маягаар өгүүлснээс үүдэн, тэрхүү товч орчуулгыг И.Кафаров гуай оросоор орчуулан 1866 онд хэвлүүлснээр орос болон өрнө дахини эрдэмтэд түүгээр монголын нууц товчоотой эхэлж танилцаж, Кафаров “Бөрт чоно” “Гоо марал” гэхгүйгээр нэрийг бас орчуулж “Бурый волк и Сивая лань” гэснээс Бөрт чоно, Гоо марал хоёрыг адгуус гээж ойлгох болсон. Монголын нууц товчооны 11 номын сийрүүлэг, орчуулга бас Бөрт чоно, Гоо маралыг дурдсан түүхийн 10 гаруй сурвалжийн алинд ч Бөрт чоно, Гоо марал хоёрыг адгуус гэсэн санаа огт байхгүйг “Бөрт чоно, Гоо марал хоёрын хүн” болохын гэрч баримт болгон өгүүлсэн. 13 ишилэлээс

сийрүүлэг, орчуулгын ялгааг ойлгож, сийрүүлгээс үндсэн эхийн онцлогийг мэдэрч, ганц угний илүү дутуу ямар нөвлөвтэйг ухаарч аваасай гэж өрөөс эхлэн үзэгч сурагч, оюутан, жинхэнэ эх бичигтэй ажиллааж сурхад тань тус дэм үзүүлэхийг гол болгож, иш татахдаа аль болохоор уг эхийг баримтлахыг хичээсэн бөгөөд зарим хунд, ойлгомжгүй үгийн ард эрдэмтдийн тайлбарыг хаалтанд хийсэн юм. Ийм ч учраас нууц товчооны I-р зүйлийн 13 ишлэл, монголын түүхэн арван хэдэн сурвалжаас эхний хоёрыг арай дэлгэрэнгүй, бусдыг хураангуйлан иш татан өгүүлсэн юм. Энд тэмдэглэхэд Өвөр Монголын олон эрдэмтэн (миний олж унисанаар нэгээс бусад нь) Бөрт чоно, Гоо марал хоёрыг түүхэн хүн гэдэгт огт эргэлзэлгүй төдийгүй зарим нь бур адгуус гэдгийг доромжсол гэж үзэж байна.

Хоёрдахь “Чингис хааны төрсөн оныг магадлан өгүүлэх нь..” өгүүлэлд мөн 18 түүхийн сурвалжийг баримт болгон “усан морин жил (1162 он)” гэдгийг иш татсанаараа нотлон өгүүлжс байгаа минь тэр юм. Энд Чингис хааны төрсөн жил, сар, өдөр, цагийг өгүүлсэн Лу Алтантовчийн мэдээлийг би Чингис хааны амьд ахуйд Елий Чу Цай магадлан тогтоосон мэдээлэл байх гэж бодож байгаа билээ.

Ер нь Чингис хаан насаа мэдээж байсан нь тодорхой. Учир нь Нууц товчоонд 9 настай бух үйд гэх мэт дурьдсан ба төрсөн нь түүхэн чухал үйл явдал татарыг байлдан дагуулж ирсэнтэй холбоотой тул, түүнийг олон хүн мэдээж байсан байж таарна. Нөгөө талаар бас “нөхж атган төрсөн” онцлогтой, “Монголын нууц товчоог” лав тахиа жил-1201 оноос өмнө бичиж эхэлсэн байж таарна. 1201 оноос эхлэн үйл явдлыг жил жилээр өгүүлэх болсон нь түүхээн нарийн тодорхой өгүүлжс байгаа хэрэг, түүхийн маш чухал ухагдахуун болох “цаг хугацааг” сайнаар ухаарч ашиглах байгаа хэрэг. Иймд Чингис хааны төрсөн жил, сар, өдөр тодорхой байсан гэдэгт эргэлзэх аргагүй байна. Гэхдээ үүнийг хүн бухэнд зарлаачихсан гэсэн үг бус харин ч

нууц, үөөн тодорхой хүн мэдэх, магадгүй бусдыг төөрөгдүүлэх худал нас, жил тархаасан байж ч мэднэ.

Чингис хааны төрсөн жил зэрэг чухал он, үйл явдлын товчоонд төрсөн жил, сүй тавьсан, Бөрт үжинтэй гэрлэсэн жил, Хамаг монгол ба Их Монголын хан болсон он, нас барсан он жилийг түүхийн 21 сурвалжс иш татан мэдээлэв. (тальян дугаар заав.)

“Есүхэй баатар хан болох нь” өгүүлэлд Нууц товчоо, Судрын чуулган, Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл, Лу Алтан товчийг иш татан Есүхэй баатар сонгогдоогүй хаан байсныг батлан өгүүлсэн.

“Тэмүжин Хамаг монгол аймаг ба Их Монгол улсын хан болсон нь” өгүүлэлд Хамаг Монголын хан болсон оныг 1189 (шаргачин тахиа) жил гэдгийн оронд усан барс 1182 он дэвшүүлэв.

Чингис хааны язгуур буюу угийн бичигт (бас угийн мод, гэрийн үеийн түүх ч гэдэг байна) Л.Алтан товч зэрэг бийн сурвалж бичгийг харьцуулжс үзээд Монголын нууц товчоонд Чингис хааны дээд 22 үеийг тоочсоныг энд 23 үе болгож, Хабич баатарын дараа Бэгир баатрыг нэмэв.

Монголын нууц товчоо, Хураангуй алтан товч, Лу Алтан товч, Эрдэнийн товч, Судрын чуулган, Юан улсын түүх дэх Чингис хааны дээдсийн үе залгамжийг гурав гурваар зэрэгцүүлэн бичив. Гоо бусгүйн шинжс бичив.

“Чингис хаан өөд болсон нь” өгүүлэлд хамгийн үнэн, зөв мэдээлэл болох нууц товчооны мэдээлийг өгүүлсэний гадна манай зарим сурвалжийн гүйвуулсан “нууц орныг гэмтээсэн” зэргийг шуумжлэн өгүүлэв.

1996. VI сар.

2001. VII-VIII сар

Бөрт чоно, Гоо марал хоёр түүхэн хүн болох нь

1. Бөрт чоно, Гоо марал хоёрын анх өгүүлсэн нь
2. Бөрт хуа үгийн утгыг өгүүлэх нь
3. Бөрт чоно, Гоо маралыг чоно, буга гэж үзсэнийг эсэргүүцсэн нь
4. Бөрт чоно, Гоо маралыг адгуус болгох сэжүүр нь
5. Бөрт чоно, Гоо маралыг хүн гэж ойлгож байсан гадаад баримт
6. Монголын 13 түүхэн сурвалж Бөрт чоно, Гоо маралыг хүн гэж үздэгийн баримт болох нь
7. Өөр үзэл бодол
8. Хүннүгийн Модун шанью хаан ба боржигид овогтон хиад ястны сүлдэр буюу сүлд шонхор шувуу болох нь

Монголын ард түмний бахархал, манай ууган бөгөөд хамгийн эртний (1240 оны) түүхэн сурвалж болох "Монголын нууц товчооны" 1 дүгээр зүйлд Бөрт чоно, Гоо марал хоёрыг анх өгүүлсэн байдаг. Монголын нууц товчооны жинхэнэ эх дэвтэр өнөө хүртэл бидэнд олдсонгүй ээ. Харин Даймин (Их мин) улсын анхны хаан Хүн ү-гийн хаанчлалын (1368-1398 оны) үед монгол уг бүрийг хятад дүрс үсгээр галиглан буулгасан дэвтэрд (хятад үсгийн галиг буюу авианы орчуулга гэдэг) бараг уг бүрийн хажууд хятад хадмал орчуулга (хажуугийн орчуулга гэдэг) хийж, зүйл бүрийн эцэст утгын товч орчуулга (ерөнхий орчуулга гэдэг) хийсэн модон барын хэвлэлийн 3 зүйлийн дам хуулга үлджээ.

Монголын нууц товчооны сийрүүлэг, орчуулгын 15 номоос (3 номынхыг дам иш татна) 1-р зүйлийг сийрүүлж бичье.

Монгол бичгээр бичсэнийг одоогийн дуудлагаар буюу одоогийн дуудлагад ойртуулсхийн буулгав. Хаалтанд зарим онцлог үгийн тайлбар хийв.

1.Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөрт чоно ажгуу. Гэргий нь Гоо марал аж. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрнөө тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж төрсөн Батачахан ажгуу. (Элдэндэй, Ардажав сийрүүлэн тайлбарлав. Монголын нууц товчоон-сийрүүлэл тайлбар.

Халдунаа нутаглаж төрсөн Батцагаан ажгуу. (Цэндийн Хандсүрэн. Цэнд гүн ба монголын нууц товчоо. УХГ. УБ.1997 номын 53-р тал. Цэнд гуай 1917 онд сийрүүлж хятад товч орчуулгын нь монголоор орчуулжээ. "Юан улсын нууц түүх. Тэргүүн дэвтэр" гэж эхэлдэг. (53-р тал))

2. Өвөрモンголын хорчинаи Бөх-Хишигийн 1932-1936 онд монголчилон бичиж Хайлу дор 1940 онд " Монголын нууц товчоон" нэрээр хэвлүүлсэн номондоо "Дээр тэнгэрээс заяат төрсөн Бөрт чоно ажгуу. Гэргий нь Гояи (Гойай) марал ажихуй. Тэнгисийг гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж төрсөн Батачахан ажгуу". (Элдэндэй, Ардажав сийрүүлэн тайлбарлав. Монголын нууц товчоон-сийрүүлэл тайлбар. Өвөр монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1986. номын 12,13-р тал)

3. Өвөрモンголын Хөлөн бойрын шинэ баргын Хуасай Дугаржав. Чингис хааны ожагур (язгуур) дээр тэнгэрээс заяат төрсөн Бөрт чоно ажгуу. Гэргий Гоаи (Гоо) марал ажигтай (ажгуу). Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж төрсөн Батачихан ажгуу. (Өмнө дурдсан Элдэндэй, Ардажав гуай номын 9-р тал.Хуасай Дугаржав гуай, Японы Хаттори Широтой хамт "монголын нууц товчооны" I бүлгийг 1939 онд хэвлүүлжээ; түүний 1§).

4. "Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ - чино, гэргий Гуа маралын хамт тэнгис далай гэтэлж ирээд Онон мөрний эх Бурхан халдун ууланд нутаглаж Батцагаан гэдэг нэгэн хөвгүүнийг төрүүлжээ." (Монголын нууц товчоо. Дөрөв дэх хэвлэл. (хуучин монгол хэлнээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав.)УБ. 1990. номын 25-р тал. "Шинжлэх ухаан" сэтгүүлийн 1941 оны 1-рт оршил, I-III бүлэг нь анх хэвлэгджээ).

5. Ордосын Хишигбат (Монголын нууц товчоон) 1941. Чуулалт хаалга

(орчуулга). "Дээд тэнгэр Бөрт чоно хэмээх хүнийг төрүүлсэн хойно Гоо марал хэмээх охиныг гэргий болгон авч тэнгис нэрт далайг гэтлэж Онон нэрт голын эхэнд бүхий Бурхан халдуна нэрт уулын еверт хүрч нутаглан суувай. Нэгэн хөвүүн төрснийг Батцагаан хэмээбэй" (2-т өгүүлсэн Элдэндэй гуайн номын 16-р тал)

6. Харчин баруун хошууны Алтан- Очир. Монголын нууц товчоо.1941. Чуулалт хаалга." Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөрт чоно ажгуу. Гэргий нь Гоо марал ажухуй. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүн Бурхан Халдунаа нутаглаж төрсөн Батцагаан ажгуу." (өмнө дурдсан Элдэндэй гуайн номын 18-р тал).

7. "Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хохай марал ажихай. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж төрсөн Батачи хан ажгуу". (Б.Сумъяабаатар. Монголын нууц товчоон. үсгийн галиг. УБ. 1990 номын 7,8 дугаар тал. (Широтари Куракичийн 1942 оны сийрүүлэг)).

8. "Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хохай марал ажихай. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нунтаглаж (нутаглаж) төрсөн. Бадачи хан ажгуу." (Монголын нууц товчоон. Тэргүүн. Баяр галиглэв. Хоёрдахь хэвлэл. Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо. 1998. Анх 1981 онд 3 дэвтэр болгон хэвлэжээ)

9. "Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөрт чоно, гэргий нь Гоо марал гэж байжээ. Тэд тэнгисийг гэтлэн нүүж ирээд Онон голын эх Бурхан халдун ууланд нутаглаж Бадачи хан гэх нэгэн хүйтэй болов.

"монголын нууц товчооны харгуулан хянасан дэвтэр. Хуасай Дугаржав. Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо. 1984" орчуулга номын оршлын дараах 1-р тал).

10. Чингис хааны *hujaug* (язгуур) дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажуу. Гэргий нь Хоай марал ажи ай. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж төрсөн Батачиган ажуу. (монголын нууц товчоо. Латин галиг. Т. Дащцэдэн.УБ. 1985 номын 10 дугаар тал)

11. "Чингис хааны язгуур нь дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно гэргий Хоо марал ажи. Тэнгис гэтлэн ирж Онон мөрний эх Бурхан халдунд нутаглаж хөвгүүн Батачи ханыг төрөв." (Шинээр орчуулан тайлбарласан. Монголын нууц товчоо.Мансан. Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо. 1985 номын гарчгийн дараах 3 дугаар тал).

12."Чингис хааны ожагур (язгуур) дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хухай марал ажи ай. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нунтаглаж төрсөн Бадачи хан ажгуу." ("Монголын нууц товчоон сийрүүлэл-тайлбар. Элдэндэй, Ардажав сийрүүлж тайлбарлав. Өвөрモンголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1986" номын удиртгалын дараах 1 дүгээр тал)

13. "Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хухай марал ажи ай . Тэнгэс гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нунтаглаж төрсөн Батачи хан ажгуу." (Монголын нууц товчоон. Ихэмянгудай Иринчиний сэргээлт. Өвөрモンголын Их сургуулийн хэвлэлийн хороо. 1978. Хөхэ хот. номын "монголын нууц товчоон" хэсгийн 1 дүгээр тал)

14."Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ Чинба ажгуу. Гэргий нь Хубай марал ажихай. Тэнгэс гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нунтаглаж төрсөн Бадачи хан ажгуу." (Монголын нууц товчоон. Худам монгол бичгээр сийрүүлсэн Ш.Гаадамба. УБ. 1990. номын 7 дугаар тал. 222-р тал дахь, 9-р тайлбартай "Хубай Марал гэдэг нь Ухаа Марал (эм буга) гэсэн")

15. "Чингис хааны язгуур дээр тэнгэрээс занат тэрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хоо марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний эхин Бурхан халдуунд нутаглаж тэрсөн Бадачи хан ажгуу." (Монголын нууц товчооны орчуулга, тайлбар. Далантайн Цэрэнсодном. УБ. 2000. номын 31-р тал. Энэ номыг анх 1993 онд Бээжиннд Монгол бичгээр хэвлүүлжээ.)

Энд дурдан байгаа Бөртэ чоно Гоо (Гояй, Гоай, Гуа, Гохай, Хоай, Хоо, Хухай, Хубай) марал хоёр нь хүний нэр гэдэг нь ойлгомжтой юм. Бөрт нэрийг Цэнд гүн "Бөртэ" гэж бусад нь "Бөртэ" гэж галигласан.

Харин бөртэ, гоо (гуя,....., хуа) хоёр үгийн утгыг авч үзье.

1. "Аливаа цоохор юмыг цэм бөртэ хэмээмой" ("Хорин нэгтийн тайлбар толь. Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо. 1979." номын 278 дугаар тал)

2. "Бөрт цагаан, цайвар өнгө зүсэнд оролцсон хар бор толбо; бөрттэй цагаан, бөрттэй халиун. (Монгол хэлний товч тайлбар толь. Я.Цэвэл. УБ. 1966" номын 100 дугаар тал)

3. Адууны зүсэм буурал цоохор эрээн сэвхтэй холимогийг бөрттэй хэмээмой. (Хорин наймтын тайлбар толь. Намжилма эмхилэбэ. Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо. 1994. номын 749 дүгээр тал) Энэ толийн 750 дугаар талд "Муухан үзэгдэх юмыг бөртийж хэмээмой." гэсэн.

"...Дундад эртний монгол хэлний гэрч баримтын зүйл анхаарбаас коя гэж байсан... Ордос аялгуунаа одоо коя гэдэг нь хоо болж, ойрад бүх аялгуунаа хоо, Ага буриад аялгуунаа хуа... зарим буриад аялгуунаа хуа... халхад тэр нь үе тонгорч ухаа болсон байна." (Б. Ринчэн. Монгол бичгийн хэлний зүй. Дэд дэвтэр. Авианзүй. ШУАХ. УБ. 1966. номын 216 дугаар тал) "Бөртэ гэж түркээр чоно, хуа марал гэж ухаа буга гэсэн уг." ("Ц.Дамдинсүрэн. Монголын уран зохиолын тойм. УБ.1957" номын 71 дүгээр тал). Энэ бүгдээс үзвэл гоо, гуа, гохай, хоай, хоо, хухай, хубай,

хуа үгийг ухаа гэж ойлгох нь зүйтэй байна. "Гоо сайхны" гоо гэж ойлгож байгаагүй харин өнгө зүсний ухаа гэж мөн бөртэ үгийг ч бас зүс гэж хятадууд ойлгож байсан байна. Энэ талаар хойно өгүүлнэ.

Бөртэ үгийг чоно гэж ойлгож болмооргүй байгаа нь өмнө дурдсан толийн тайлбараас тодорхой байна. Хэрэв чоно гэж ойлговол "Бөрт үжин" нь чоно үжин болоход хүрнэ. Негөө талаар бөрт гэсэн түрэг үгийн хоёрдахь утга нь " цагаан, саарал өнгө зүсэнд оролцсон хар бор толбо; Улаан нүдэн бөрт улаан морио унав (Гэс). ("О. Сүхбаатар. Монгол хэлний харь үгийн толь. УБ. 1999 хоёр дахь хэвлэл" номын 52 дугаар тал) хар бор толбо, тодруулж хэлбэл, сэвх байна. "Нүүр дор өчүүхэн төдүй ургасан мэнгэний адил харавтарыг нь сэвхэ хэмээмой" гэж өмнө дурдсан "Хорин нэгтийн тайлбар толь" номын 540 дүгээр талд бичжээ. Иймд бөрт гэдэг нь сэвхтэй гэсэн утгатай байна. Бөрт үжин маань сэвхтэй үжин, Бөртгөлжин гэдэг нь бага зэрэг, ялимгүй сэвхтэй гэсэн үг байна. "Бөрт чоно" нь эрмэг зоригтой ов тов цоохор (сэвхтэй) эр хүн гэсэн утгатай. Хуа үгийн "Х" үсгийг монгол бичигт "Г" гэж уншиж болох тул " хуа "ыг "гуа" гэж ойлгохоор "гоо" гэж дуудна. Ийнхүү "Хуа марал" нь Гоо марал болжээ.

3. БНМАУ-ын ерөнхий сайд, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийндарга асан А.Амар гуай "Монголын товч түүхдээ" " Бөрт чоно нь нэгэнт монгол хүн тул..... төдий л олныг өгүүлэх явдалгүй мэт санагдмой. Тийн атал зарим нэг түүхчин монголчууд нь өөрсдийн гарлыг чоно ба марал хэмээх адгуус амьтнаас гарав хэмээдэг хэмээн Бөрт чоно, Гоо марал хэмээхийг харин адгуус мэтээр өгүүлдэг баймой. Энэ нь Чоно, Марал хэмээх нэрээс ийнхүү сэжигдсэн хэрэг мэт бололтой. Монголчуудын заншлаар эдгээр болбоос хүнд Чоно ба Марал хэмээх нэр цол өгөх нь тэр үед байтугай одоо ч байх амой" гэжээ. (Монгол бичгийн 1934 оны хэвлэлийн 144,145 дугаар тал)

Байшонхор нас нэхцсөний дараа дүү нь гэргийтэй нь сууж гарсан хоёр хүүхэд нь Гэнд чоно, Өлөгчин чоно гэдэг. Энэ хоёрын удмынхан чонос овогтой байсан гэж Рашид-ад дин "Сурын чуулгандаа" бичсэн.

Хуасай Дугаржав гуай "ХХ эзуны гуцаад оны дунд ба сүүлчээр би..... Токио хотод суралцаж байхдаан гадаадын түүхчдийн зохиосон Монголын түүхийн тухай хэд хэдэн дэвтрүйг үзэхэд бараг монгол үндэстэн бол..."хөх чоно","саарал буга" хоёроос үүссэн юм гэж бичиж байв. Үүнийг үзээд чоно, буга хоёроос хүн төрж үржих ёсон хaa байх вэ? Энэ бол монгол үндэстэнийг доромжилож байгаа хэрэг гэсэн санал төрөөд зарим хүмүүсээс асуухад "энэ бол эртний домог болно. Ямар ч үндэстэнд байдаг юм гэж хэлнэ. Гэвч энэ нь миний саналыг хангаж чадсангүй.

... Монголын нууц товчоо эхлэнгүүтээ "Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно, гэргий нь Гоо марал" гэж бичиж байна. Энэ нь даруй ямар чоно, буга биш хүний нэр болохыг тов тодорхой үзүүлж байна. Хажуугийн хадмал орчуулга бол өөр учир болно" гэж өмнө дурдсан Хуасай Дугаржавын 2 дахь номын 2,3 дугаар талд бичжээ.

"Монголын нууц товчооны" хятад галигийн уг дэвтэрд "Бөрт чоно" гэсний хажууд ... хөх өнгөт чоно,"Гоо марал" гэсний хажууд ... хуа өнгөт буга "гэж тэрчилэн ерөнхий орчуулгад нь" Тэнгэрээс төрүүлсэн нэгэн хөх өнгөт чоно, нэгэн хуа өнгөт буга лугаа залгалдаж ..." гэж бичиж байна. Энэ бол түүхийг гажуудуулж монгол хүнийг зориуд доромжилсон явдал болно. Учир нь зөвхөн монголын дээд болсон Бөрт чоно, Гоо марал хоёрхон нэрийг л утгачилан орчуулаад бус хэдэн зуун нэрийг огт орчуулсангүй бээр "хүний нэр" ... гэсэн тэмдэг зүүлт хийжээ. Харин нууц товчоонд адгуус амьтана нэрээр нэрлэдэг нь зэндөөн буй." (Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр. Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо. Хоёр дахь хэвлэл. 1991. номын 34 дүгээр талд Сайшаал гуай бичжээ. Энэ ном анх 1987 онд

хэвлэгдсэн)

4."Бас улаан шугам буйг хоёр шугам татаж ялгаварлан тэмдэглэжүүй. Улаан шугам нь хүний нэр" гэж өмнө 1 дүгээрт дурдсан Цэнд гүний номын 45 дугаар талд бичжээ. Гэтэл "Бөртэ чоно", "Ухаа марал" хоёрын ард хүний нэрийн тэмдэг давхар зураас тавиагүй ерөнхий орчуулгад нэрийг нь оруулсан ажээ. Чухам ийм учраас эрдэмтэд Бөртэ чоно, Ухаа марал хоёрыг хүн бус адгуус амьтан мэтээр ойлгох болжээ. Улмаар "чоно, бугыг" онгон шүтээн (тотем) болгожээ. Өмнө дурдсан Баяр гуайн хэвлүүлсэн хятад галиг бүхий номын "Чингис хааны язгуур" гэдгийн "Чингис"ийн ард хүний нэрийн тэмдэг, давхар зураас хийгээгүй байна. Оросын Бээжин дэх шашны төлөөлөгчдийн тэргүүн П.И. Кафаров Монголын нууц товчооны хятад товч орчуулгыг оросоор орчуулаж 1866 онд "Старинное монгольское сказание о Чингис-хане" нэрээр хэвлүүлсэнээр өрнө дахины эрдэмтэд монголын нууц товчоотой танилцаж эхэлжээ. Уг номонд 1 дүгээр зүйлийг оросоор орчуулсныг мөхөс би монголоос орчуулбал "Хөх чоно, Хувай марал хоёр цуг... Тэнгэс гэдэг ус гаталж Онон гэдэг голын оргилд хүрч Бурхан нэрт ууланд нийлж эвцэлдэж өртөнцөд Батачи хан нэрт хүн төрүүлэв". П.Б.Балданжапав. Altan tobci Монгольская летопись XVIII в. Улан-Үдэ. 1970. номоос орчуулав. Энд Бөрт чоно, Ухаа марал хоёрыг хүн гэж үзээгүй нь илэрхий байна. Судрын чуулганыг орос дээр орчуулсан Берэзин тайлбартай "Палладиний орчуулгад Бөртэ чоно Гоо марал гэхийн оронд "Бурый волк и Сивая лань" гэжээ.

5. Ираны нэрт эрдэмтэн перс Рашид-ад-дин 1307-1311 онд Монолын Болд чинсан тэргүүтэй 6 монгол түүхчдийн хамт монголоор "судрын чуулган" гэдэг түүхийн алдарт бүтээл туурвижээ. Рашид-ад-дин түргүүдийг чононоорс гаралтай гэсэн домог дурдсан боловч чухам монголчуудын гарлыг дурдаа ~~Бада Мондо~~ орос гаралтай талаар огт дурдаагүй төдийгүй "...

Бүх монгол овог Эргэнэ-хунд очсон хоёр хүнээс гаралтай. Эргэнэ-хунаас гарсан хүмүүсийн дунд Бөрт чоно нэртэй зарим овгийн тэргүүн, удирдагч бэхι байжээ. ... Бөрт чоно олон гэргий, хүүхэдтэй байжээ. Авааль гэргий Гоо маралын хүү нь Битеджи-Каан /Бадачи хан/ нь бүх хүүхдээс нь хамгийн азтай хаан ширээнд суужээ." "Записки Императорского археологического общества XVI. СПб. 1858" номын 4 дүгээр тал. Бэхиж нь ноён гэсэн утгатай түрэг үг. Авааль гэргий нь анхны гэргий гэсэн үг.)

Мин улсын Лин Ди Хе 1579 онд бичсэн "Бүх үеийн хааны удам угсааны товчоон" номондоо "Монголын хаадын үе залгамж болон Чингис хааны товч намтыг тоочсон бөгөөд Юан улсын дээдэс бол дээд тэнгэрээс занаят төрсөн Бөрт зүст хүн .. хуа өнгөт охиноос үүсэв гэж хэлсэн .. Ван Чи 1607 онд зохиосон номынхоо түүхэн хүмүүс бүлгийн Юан улсын хаадын үе залгамжийн зураг дор "Бөрт чоно, Хуа марал гэж хэлж байх .. Үүний хамт Ван чигийн 1608 онд зохиогдсон .. бичигт "Хүннүг таван төрөлтөнд хуваагаад нууц товчоонд гарах Бөрт чоно, Хуа марал, жич түүний хөвгүүн Батачи ханыг Хүннүгийн нэгэн төрөлтөн гэж тэмдэглэв". ("Монголын нууц товчооны судалгаа. Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо. 1991" номын 557 дугаар талд Булаг гуай "Дундад улсын "Монголын нууц товчооны" судалгааны түүхчилсэн төлөв" өгүүлэлдээ бичжээ. Эндээс үзвэл: XVI, XVII зууны хятадын хоёр эрдэмтэн Бөрт чоно, Ухаа марал хоёрыг чоно буга гэж ойлгосонгүй харин хүн гэж ойлгосон нь тодорхой байна.

"Доссоны монголын түүх. Нэг. Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо. 1988" номын /1824-1852 онд / армяны Д.Оссон бичсэн) 65-р талд "Онон, Хэрлэн, Туул зэрэг гол мөрний сав газраар нүүдэллэж сууж байсан хэдэн аймгийн түрүү нь Бөрт чоно гэдэг" гэсэн.

6. Манай элэнц хуланцын дээдэс юу гэж үзэж байсныг сонирхъё. Энд тэмдэглэхэд 1330-ны "Арван буянт номын цагаан түүх" хэмээн номоос

/V-XV зууны ганц түүхэн сурвалж/, эхлээд бараг бүх түүхэн сурвалжид Монголын хаадын язгуурыг энэтхэг, түвдийн хаадтай зохиомлоор холбон бичсэн байdag нь манайд Бурхан багш Шигамунийн /Шагжамуны/ сургааль, улмаар төвдийн Зонхов богдын шарын шашин ихэд дэлгэрч монгол түмний оюуныг эзэмдэж байсантай холбоотой. Хубилай хааны номын багш, улсын багш цолтой Пагва лам /Лодойжалцан. 1235-1286/ бурханы шашныг төрийн шашин болгосныг бататган батлах, хаад ноёдын сэтгэлийг татах, улмаар монголчуудын оюун сэтгэлийг эзэмдэх үүднээс монголын хаадын язгуурыг энэтхэг, төвдөөс гаралтай гэж Хубилай хааны хүү хунтайж Чингимиийн дурдатгаснаар бичсэн "маш тодорхой ухагдахуун" номондоо анх бичсэн нь хожим ихэд дэлгэрч түүх бичлэгийн нэг ёсны загвар болсон ажээ. /Ш.Бира. БНМАУ-ын түүх соёл, түүх бичлэгийн асуудалд ... ШУАХ. УБ.1997/ номын "Монголын хуучны түүх бичлэгийн зарим нэг асуудал" /44-76 дугаар тал өгүүлэл/. Гэвч монголын зарим түүхч энэхүү гүйвуулгыг эргэлзэж байжээ.

Энэ нь манай улсад дөчөөд оноос хойш түүх, нийгмийн ухаан түүгээр ч барахгүй байгалийн ухааныг марксизмаар үндэслэж, марксизм-ленинизмгүй, МАХН-ын программ, их бүгд хурлаас иш татаагүй ном төдийгүй өгүүлэл ч ховор байсантай зүйрлэвэл нэг их гайхмаар буруутгамаар зүйл биш. Монголын хаадыг энэтхэг, төвдийн хаадтай холбоходо төвдийн анхны хаан Хүзүүн сандалтыг энэтхэгийн анхны хаан Махасамадийн удам болгоод, Хүзүүн сандалт хааны удам Алтан сандалт хааны отгон хүү Бөрт чоныг монгол оронд "ирүүлж". Бадачи хан (Батцагааныг) төрүүлсэн гэдэг.

Ихэнх түүхэн сурвалжид Бөрт чоныг төвдийн Алтан ширээт хааны отгон хүү бөгөөд ах нартайгаа муудалцаад эсвэл эцэг хааныг нь түшмэл нь хороож хаан ширээнд сууснаас болж, задын газар /тэдний хувьд харь

газар болох монгол оронд/ зугатан очиж суурьшин, монгол омогтон болсон гэдэг. Энд дэлгэрэнгүй иш татаад цаашид арай товч иш татья.

1.Зохиогчийн нэр үгүй “Хураангуй алтан товчид /1604-1634/” “Далай Сүбин алтан сандалт хаан түүний хөвгүүн ах нь Борочи, дэд нь Шибагучи, отгон нь Бөрт чоно буюу. Өөр зуур баан муулалдаж Бөрт чоно умар зүг .. тэнгис далай гэтэлж задын газраа ирээд эр үгүй Гоо марал нэрт охиныг авч задын газраа нутаглан сууж монгол омогтон болов.” Түүний хөвгүүн Бадай цагаан гэсэн. /Хадын хураангуй алтан товч. Булаг харгуулж тайлбарлав. Өвөрモンголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1989 номын 6, 7 дугаар тал/

Хааны отгон хүү Бөрт чоно нь “Гоо марал нэрт охиныг авч” гэсэн болохоор Бөрт чоно, Гоо марал хоёр хүн гэдэг нь тов тодорхой байна.

Энд иш татсан хэсгийг нууц товchoоны 1 дүгээр зүйлийн харгуулж үзье. Нууц товчоонд “Тэнгис гэтэлж” гэсэн хоёр үг бий. Тэнгис гэдэг нь чухам юу болох нь тодорхойгүй байна. Хятад эх дээр нь хүний нэр, газрын нэрийн таних тэмдэг байдаг гэсэн. Харин голын нэрд таних тэмдэг хийсэн эсэхийг мэдэхгүй. Цэнд гүн хятад ерөнхий орчуулгын орчуулгад “тэнгис усныг” гэсэн. П.И.Кафаров гуай бас “тэнгис усныг” гэсэн “ус” нь эрт цагт “гол” гэсэн утгатай байжээ. Нууц товчооны 8§-д гардаг “Ариг усан” нь одоогийн “Ариг гол” ажээ. Х.Пэрлээ гуай “Хөвсгөл нуурын баруун хойт нутгаас Тэнгис голыг гаталж Бурхан халдуун уулнаа нүүж ирсэн” гэжээ. /Асрагч нэртийн түүх. УБ.1960/ номын тайлбар /96 дугаар тал/. Нууц товчоог бичих үед Бурхан халдуныг уул гэх шаардлагагүй байсантай адил Тэнгис гэдгийг гол /ус/ гэх шаардлагагүй байсан ч байж мэднэ. Негөө талаар “Тэнгис”, “гэтэлжээ” хоёрын хоорондох “гол буюу /ус/” үг гээгдсэн ч байж магадгүй. Гэтэл “Хураангуй алтан товчид” “тэнгис далай гэтэлж” болгожээ. Энэ нь тэнгис үгийг тайлбарлаж далай үг нэмсэн бололтой.

Хэрэв “илүү үгсийг” хасвал “Бөрт чоно умар зүг ... тэнгэстэтэлж ... түүний хөвгүүн Бадай цагаан” болж байна. Энэ нь нууц товчооны 1 дүгээр зүйлийн зохих хэсэгтэй үндсэндээ тохирч байна.

2.Лувсанданзаны “Алтан товчид”/Лу.Алтан товч/ төвдийн Алтан сандалт хааны хөвгүүн нь ... отгон нь Бөрт чоно ... умар зүг тэнгэс далай гэтэлж задын газар ирээд эр үгүй Гоо марал нэрт охиныг авч задын газраа нутаглаж монгол омогтон болов. Дээр тэнгэрийн заяагаар тэнгэс далайг гэтэлж ирсэн Бөрт чоно, Гоо марал хоёр Бурхан халдунаа нутаглаж асан ажгуу. Тэр хоёроос Бата цагаан төрөв (Алтан товч. Эртний хадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой. УХГ. УБ.1990/ номын 4 дүгээр хуудас.)

“Дээр тэнгэрийн ... төрөв” гэсэн сүүлчийн хоёр өгүүлбэр нууц товчооны 1 дүгээр зүйлийн “дээр тэнгэрээс” гэдгээс эхэлсэн хэсэгт хэрэв “далай” үгийг хасвал бараг ижил байгаа нь сонирхолтой. Ер нь Лу.Алтан товч бол нууц товчооны Чингис хааны хэсгийг хамгийн их агуулсан ном. Гэхдээ зарим газрын утга нь эрс өөр байдаг.

3.Шар туужид “төвдийн ... Алтан сандалт хааны отгон хөвгүүн Бөрт чоно .. Гоо марал нэрт гэргий бээн аван, дорно зүг тэнгис далай гутулж /гаталж/ Бурхан халдуна уулнаа хүрч Бидэ хэмээх улсад золгож .. тэр Бидэ улс хэлэлцэж ноён болговой. Монголын эн тэргүүн ноён Бөрт чоно буюу” (Шар туджи. Монгольская летопись. XVII века. Сводный текст, перевод, введение и примечания К.П.Шастиной. Москва.Ленинград. 1957 номын 21 дүгээр тал). Энд “Бөрт чоно .. Гоо марал .. гэргий бээн аван .. тэнгэс гаталж Бурхан халдунаа уулнаа ..” нь нууц товчооны 1 дүгээр зүйлийн зохих хэсэгтэй тохирч байна. Энд өмнөх хоёр номонд байгаагүй шинэ мэдээлэл: “Бидэ улсад золгож”, “Бидэ улс хэлэлцэж ноён болговой” гэж байна. “Монголын ноён Бөрт чоно ..” гэсэн нь Рашид-Ад-дины бэхி /ноён/ гэсэнтэй

‘тохирч байна. Бас өмнөх хоёр номонд “умар зүг” гэж байхад энд харин дорно зүг гэж байгаа нь хачирхалтай. Төвдөөс монголд ирсэн гэсэн юм чинь умар зүг байх нь зөв баймаар юм.

4. Саган сэцэний “Эрдэнийн товч”-д /1662 он/ “Алтан ширээт хааны отгон .. Бөрт чоно .. Гоо марал хэмээх гэргий юүгээн авч тэнгис нэрт далайг гэтлэн дорно зүйт зорчин Байгал хэмээх мөрний хязгаарт Бурхан халдун нэрт ууланд хүрч ирээд Бэдэ хэмээх улсад золгон бүхийе .. түүнийг ноён болгон .. түүнийх ... Батсанаа, Батцагаан хэмээх хоёр хөвгүүн буюу” /Саган сэцэн, Эрдэнийн товч. УБ.1961/ номын 72 дугаар тал. Энд шар тужийнхаас илүү мэдээлэл байна. Бүр Бөрт чонын хоёр хүүхэд дурджээ. Цааших өгүүлэл нь нууц товчооныхтой үндсэндээ адил: “Тэнгис нэрт далайг” гэсэн байна. Далай гэдэг нь одоогийн ойлголтын далай биш, “их ус” гэсэн үг. Тэнгис гэдэг нь гол баймаар байна.

5. Бямба. Асрагч нэртийн түүх. 1677 он. Оршил бичиж хэвлэлд бэлтгэж тайлбар хийсэн Пэрэнлэй. УБ.1960 гэсэн номын 8 дугаар талд “.. Бөрт чоно задын газар ирж эр үгүй Гоо марал нэрт охиныг авч монгол омогтон болов гэх”. Хөх дэвтэрт эн тэргүүн тэнгэрийн хөвгүүн Бөрт чоно, түүний хөвгүүн Батцаг гэсэн. Энд дурдсан “Хөх дэвтэр”-ийн зохиогч нь төвдийн Шонну бал гэдэг хүн бөгөөд 1476-1478 онд уг номыг бичсэн ажээ.

6. “Поми. Монголын боржигид овгийн түүх. 1735 он Нагусайнхүү, Ардажав тулган харьцуулж тайлбарлав. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. Хоёрдахь хэвлэл. 2000” номын 31-р талд “.. Алтан сандалт хаанаас тэрсэн .. гутгаар хөвгүүн Бөрт чоно .. тэнгэсийн хойд далайг гэтэлж зад газарт ирээд.. Хуа /Гоо/ марал нэртэй охиныг аваад хөвгүүн Бади /Бату/ цагааныг төрөв” гэсэн.

7. “Дарма. Алтан хүрдэн мянган хэгээст” /1739/ Чойжи тулган харьцуулж тайлбарлав. “Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1987” номын 17 дугаар

талд “Алтан сандалт хааны .. отгон өөрт чоно .. умар зүгийн тэнгис далайг гэтэлж .. задын газар ирээд Гоо марал нэрт охиныг авч Бурхан халдунд нутаглаж Бита улсад учирч .. ноён болгон өрөгвэй. Тэрбээр .. Монгол улсын боржигин омогтон хиад яст болой. “Бөрт чоноос Батцагаан, Бади цагаан хоёр хөвгүүн” гэсэн.

8. Лувсандамбийжалсан/Мэргэн гэгээн/ “Алтан товч” /1765 он/ номондоо Бөрт чоныг .. алтан сандалт хааны отгон хүү гэдгийг няцаагаад “Манзуширийн нэгэн хувилгаан тэнгэрийн хөвгүүн Бөрт чоно нь монгол Видийн газар хүрч ирснийг Монгол байgal мөрний захын Бурхан халдун ууланд ... Марал хатун үзээд ... гэрийн эзэн болгосныг Видийн улс зөвшөөн эзэн болговой. Бөрт чонын 29-ний хөвгүүн Бадачи хаан нь Тан улсын Дацунгийн жан юаны хоёрдугаар он, улаан барс жил төрвэй” гэсэн /Лувсандамбийжалсан. Мэргэн гэгээн. Алтан товч. Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо. 1998. Номын 41 дүгээр тал./ X.Пэрлээ гуайн гаргаснаар Бөрт чоно 758 онд, Батачи хан 786 онд төржээ. /Х.Пэрлээ. Монголын түүхийн урьд мэдэгдээгүй зарим он цагийн мэдээ. ШУАХ.УБ.1956/. Вида/ Бидэ/

9. Рашипунцаг. Болор эрих. 1775 он. Хөх-Өндөр харгуулан тулгав. Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо. 1985 номын 12,13 дугаар талд “Төвдийн болор сандалт хааны гуравдугаар хөвгүүн Бөрт чоно ... умар зүг тэнгис далайг гэтэлж монгол улс дор ирээд Гоо марал нэрт охиныг гэргий болгон авч ... хаан болов. Бөрт чоно хааны хүү Бадай цагаан гэсэн.”

10. Ната. Алтан эрих. 1817 он. Чойжи тулган харьцуулж тайлбарлав. Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо. 1991 он. “Тэнгэрийн хөвгүүн Бөрт чоно түүний хөвгүүн Батцагаан” (12 дугаар тал) гээд Мэргэн гэгээний үгийг иш татсан.

11. “Хөх түүх” (1820) Булаг тулган харгуулж тайлбарлав.

Өвөр mongolын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1996 номын 42, 43 дугаар талд “Рэгүмэцэн .. хэмээх хааныг нь түшмэл нь хороосон цагт ахмад ууган /отгон/ нь монголын хэлээр Бөрт чоно хэмээх бээр ... улсад суун Гоо мандал /марал/ хэмээх гэргий юүгээн дагуулан монголын газарт ирж Бидэ .. Бурхан халдун ууланд хүрч .. ноён өргөмжлөөд .. Батсанаа хийгээд Батацаагаан хэмээх хоёр хөвгүүн буй” гэж бичжээ.

12. Галдан. Эрдэнийн эрих. 1841 он. Ч.Насанбалжир хэвлэлд бэлдэв. УБ.1960 номын 38 дугаар талд “Хүзүүн саналт хааны VIII хаан ... хэмээхийг түшмэл нь хороон .. хүү Мекри нь Гувангувагийн оронд ирж тэнд суугаад Гоо Марал охиныг авч дорно зүгийн тэнгис далайг гэтэлж .. Бидэхэмээх улсаар ноён болгон өргөмжилж Бөрт чоно хэмээн алдаршвай” гэсэн.

13. Жамбадорж. Болор толь. (1846-1849 он) Лю Жин со хянааж тайлбарлав. Үндэстний хэвлэлийн хороо хэвлүүлэв. Бээжин.1984 номын 381 дүгээр талд “Төвдийн ... отгон Негри.. монгол” вэдийн газар хүрч ирсэнийг Байгал мөрний захын Бурхан халдун нэрт уулнаа суугч ... Марал хатан гэрийн эзэн болгосон... Вэд улс зөвлөлдөж ноён болгох өргөсөн..түүнийг Бөрт чоно хэмээн нэрийдмой. Хөвгүүн Бандий цагаан хан” гэсэн.

XVII-XIX зууны 13 түүхэн сурвалжид Бөрт чоныг Түвдийн хааны хүү, Гоо маралыг охин, гэргий гэснээс бус, чоно буга гэсэн санаа огт алга байна. Ийнхүү монголын нууц товчоо болон түүнийг ашиглаж бичсан монголын 13 түүхэн сурвалж, Рашид аддин (перс), Шонну-бал(төвд), Линди хе, Ван Чи (Хятад), Доссон (Армян), Бөрт чоно, Ухаа (Гоо) маралыг хүн гэж үзсэнээс бус адгуус амьтан гэж өгүүлсэнгүй ээ.

«Түүхийн судлал. УБ. 1969». Номын 129 дүгээр талд Х. Пэрлээ гуай “Дээр тоочин гаргасан зүйлээс үзвэл 1. Бөрт чоно нь олон аймаг тэргүүлсэн ноён байжээ. 2. Бөрт чоныг ирэхэд Бурхан-Халдун уул хавьд нутгийн монгол омогтын аймгууд байжээ” гэж батлан өгүүлсэн.

Д.Гонгор гуай 1970 онд хэвлэсэн «Халх товчоон. I дэвтрийн 68 дугаар талд Рашид-ад –дины “судрын чуулганаас иш татан «Бөрт чоныг ... ноён» гэж өгүүлсэн.

Ц.Элдэндэй, Э.Ардажав гуай өмнө дурдсан “Монголын нууц товчоон-сийрүүлэл” тайлбартаа «Бөрт чоно, Хухай марал нь Монголын тотем шүтээн биш юм» (номын II хэсгийн 4 дүгээр тал) гэсэн.

Цойжи гуай «Алтан товч. Цойжи. Тулган харьцуулж тайлбарлав. “Өвөр монголын Ардын Хэвлэлийн хороо. 1983” номын 18 дугаар талд “Монгол сурвалж бичигт Бөрт чоно болвоос Чингис хааны дээдэс болох хүний нэр хэмээн тэмдэглэсэн зүйл байхаас бус харин хээрийн араатан «чоно» хэмээсэн тэмдэглэл огт үгүй юм. Нэн ялангуяа «чоно», ба «буга» харьцсаны улмаас үүссэн хэмээх домог үлгэр нэг ч үгүй юм.” гэсэн.

«Манай үед үлдэж ирсэн араатан амьтанд холбогдох маш арвин хадан зургийн дотор “буга” буюу “герөөсний” зураг нэн олон тоог эзэлсэн байдаг юм. Эдгээр хадан зургаас үзэхэд эртний нүүдэл үндэстэн монголчууд “буга” буюу “марал” гөрөөс амьтаны эзэд гэж үзэж шүтэж байсан байна. Харин зарим хүмүүсийн судалсан мэт «буга» буюу «марал» нь өөрийн үндэстнийхээ өвгөд онгод гэж шүтэж байсан үгүй юм» (Л.Хурцбаатар Ч.Үзэм Монголын бөө мөргөлийн тайлга, тахилгын соёл. Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо 1991» номын 166-р тал) гэжээ.

Гэр дотор тайх тахих хувилгааныг онгод хэмээмой. (Хорин нэгтийн тайлбар толь. 102-р нүүр) Дээдсийн «сүнс сүлд» шингэсэн жижиг юмыг өвс, мод жич эсгий унгас мэтийн зүйлд эртний зохих ёс дүрмээр ороож боогоод дээдсийн хэлбэр байдалтай хүн дүртэй юмыг бүтээж үүнээн «өвгөдийн онгод» гэж шүтэж байваа. (өмнө дурдсан «Монголын бөө мөргөлийн тайлга, тахилгын соёл» номын 118-р нүүр) Чингис хааны шарилыг тээж явсан тэрэг шигдэхэд Гилигүдэй баатрын хэлсэн шүлгийн

дараа «хамгийн Мөнх Гүр тэнд үүсгэж ... хамгийн шүтээн болгоод... найман цагаан гэр болбой. Өмссөн цамц, өргөө гэр, өрөөсөн оймыг тэнд онголов. Үнэн хүүрийг заримууд Бурхан халдуунд онголваа гэх » (Лу.Алтан товч. УБ. 127-р хуудас 2 дахь нүүр). “Чингисийн найман цагаан... ордыг” ордост үе улиран монголчууд тахих болжээ.(Өмнө дурдсан Монголын бөө мөргөлийн... 123-р тал)

7. “П.Поуха. Монголын нууц товчоо бол түүх уран зохиолын дурсгалт бичиг мөн. ШУАХ.1957” номын 6 дугаар талд “Сүүлийн түүхч нар Берт Чину, Гоо марал хоёрыг хүн гэж бичжээ. Гэтэл энэ хоёр чухамдаа хүн биш овог угсааны онгон сахиус болсон араатан амьтан байгаа юм” гэсэн.

Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын тойм.УБ.1957” номынхоо 71 дүгээр талд “Чингисийн уг гарал болох Берт чоно, Хуа марал хоёр бол хаан, хатан хоёр биш харин онгон шүтээн (totem) болсон араатан амьтны нэр юм” гэсэн.

Ш.Гаадамба гуай “Энэ бол (Берт чоно) бидний бодлоор домог үлгэрийн онгон амьтны нэр байсан байж магадгүй. Гэвч түүхэн хүн байсан байж болохыг эрс үгүйсгэх аргагүй” (Ш.Гаадамба.“Монголын нууц товчоон. УБ.1990” номын 222 дугаар тал) гэсэн. Д.Цэрэнсодном гуай “Монголын нууц товчооны орчуулга. 1993.Бээжин” номондоо “Эртний монголчуудын буга гөрөөс онголон шүтэх зан үйл, домог үлгэрийн ойлголттой холбоотой гэж бид үзэж байгаа билээ” (272-273 дугаар тал) гэсэн.

Г.Сүхбаатар, Ш.Бира гуай нар “Берт чоно, Гоо марал хоёрыг онгон шүтээн” гэсэн.

8.Монголын нууц товчоонд “Бодончар чонын гуунд хоргоосон гөрөөсөн мярайж харваж алж идэлдээд чонын идсэнийг тэмгүүлдэж (түүж) идээд...” (Өмнө дурдсан “Т.Дашцэдэн. Монголын нууц товчоо” номын 15 дугаар тал) гэж байна. Энд Бодончар чонын хоолыг хэрэг дээрээ булаасан буюу

хороосон байна. Хураангуй алтан товчид (Өвөрモンголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.1989) Бодончарыг “Чоно гоо маралыг хадны хонгилд хоргодуулж байхыг үзэж түүнийг мярайж харваж алаад түүний махыг хүнс хийж суухуй” (33-р тал) гэсэн энд бүр гоо маралын мах иджээ. Иймд чоно, гоо марал хоёрыг өөрийн элэнц хуланц дээдэс “эцэг”, “эх” гэж шүтсэн гэх аргагүй байна. Гэтэл Лу.Алтан товчид “чоныг” бүр “бөрт чоно” болгоод “бөрт чонын гуунд хоргоосон гөрөөсийг мярайж харваж алаад өөрөө идээд явдагаас үзэхэд “бугыг” шүтээн гэмээргүй байна. Лу.Алтан товчийн 123-р хуудасны эхний нүүрт “Чингис хаан ав хийхэд “бөрт чоно, гоо марал хоёр орох буй түүнийг бүү ал” хөх бор морьт Бужгар үст хар хүн орох буй амьд барь гэж зарлиг болов” Берт чоно, гоо марал хоёр орж эс алж гаргавай. Хөх бор морьт хар хүнийг хүн барьж чи хэнийх вэ гэж асуув. Дуу эс гарав. Агад хүн орно гэж байгааг огт үнэмших арга алга. Дөрвен таваг (тавхай) хувирхуяа болов гэсэн. Энэ талаар “Чингис хааны язгуур буюу угийн бичиг (мод) өгүүлэлд тодорхой өгүүлсэн. Түүнийг уншина уу. Ер нь энэ хэсгийн цааших өгүүлэл шашины нөлөө ихтэй өгүүлэл юм.Персийн түүхч Жувэйнийн “Дэлхийн байлдан дагуулагчидын түүх. Дээд. Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо.1989” номын 46-р талд ав хоморгын төгсгөлийн талаар өгүүлэхдээ “өвгөд... амьд үлдсэн араатаныг алалгүй орхиж... явуулья” гэж Чингис хаанаас гүйдаг. Чингис хаан бяцхан уулын орой дээр гарч агнах амьтадыг харжээ. Гэтэл “... элдэв зүйлийн араатан амьтан ... хаан өөд хандацаан эмгэнэлтэй бээр урхирч, гашуудалтай баар улилдав. Хаан зарлиг буулгаж тэдгээр араатаныг нэг ч шархдуулалгүй бүхэнээр нь талбин гаргав.” гэж 47-р талд өгүүлсэн санааг гүйвуулсанд мэт. Харин энд зөвхөн “бөрт чоно, гоо марал хоёрыг бүү ал”, “... хүн орох буй түүнийг барь” гэдэг нь илт зохиомол үг байна. Учир нь нэгэнт л авласан бол чоно, буга хоёрыг яхин үлдээх билээ. Агад хүн

орох гэж ерөөс байж болохгүй.

Өзлүн эх Тэмүжин Хасар хоёрыг Бэгтэрийг харваж алаад орж ирэхэд ихэд уурлан “барагсад” гэж хэлээд цааш хэлэхдээ “бороонд шахах чоно мэт” гэдэг. “Хураангуй алтан товчид” бүр “бороон өдөр довтлох бөрт чоно мэт” гэсэн. Энд чоно, бөрт чоныг бүр харгис хэрцгий жишээ болгосон. Ер нь Монголын нууц товчоо болон арав гаруй түүхэн сурвалжид чоно, бугаас үүсэлтэй гэж шууд хэлсэн өгүүлбэр огт байхгүй. Харин нууц товчоонд шүтээн гэмээр зүйл ганц удаа гардаг. Дэй сэцэн л боржигид овгийн сүлд “цагаан шонхор” гэсэн санаа хэлдэг. Есүхэй баатард “цагаан шонхор наран, сар хоёрыг атган нисэж ирж гар дээр минь туув (буув)... хиад иргэний сүлдэр ирж заасан ажгуу” (дурдсан номын 24-р тал 63§) гэдэг. “Рашид-ад-дин. Судрын чуулган. УБ. 1994” номын 8 дугаар талд “энэ шударга ээний сүнс-хаанчиллын шонхор шувуу” гэсэн. Энд дурдан буй эзэн нь Чингис хааны уdam Газан (Хасаан) хаан юм. “Зууны мэдээ” сонини хавсралт “24 цагийн” 70 дугаард (2000 оны 3 дугаар сар) Д.Энхдаваа “Модун хааны алтан титэм өвөрмонголоос олдлоо” (сурвалжлагч Н.Энхбаатар) сурвалжлагад “Хүннүгийн их хааны алтан титэм оюу толгойтой харцага шонхор дурслэгдсэн байдаг” (оросын түүхийн нэг номонд). Өвөрмонголоос олдсон хүннүгийн Модун хааны титэм “орой дээрээ оюу толгойтой алтан шонхор, түүний дор 4 аргаль барьж буй чонын дүртэй” гэсэн. Энэ бүгдээс үзвэл хүннү болон хүннүгийн уdam болох боржигид овогтон хиад ястаны сүлдэр буюу сүлд нь цагаан шонхор шувуу байсан байна. Харин энэ нь боржигид овогтон хиад ястан цагаан шонхороос үссэн гэсэн уг биш юм. “Бөрт чоно болбоос монгол үндэстэн бухний уг гарал нь хараахан бус гагцхүү Чингисийн өвгэдийн үеийн залгалын аль нэг түүхэнд тэмдэглэгдэх болсон үе нь мөн хэмээлтэй. Тийн атал зарим түүхчинээс Бөрт чонын анх үүсгэлийн бүх Монголын уг гарал мөн хэмээх мэтээр өгүүлдэг” гэж Амар

гүй өмнө дурдсан номын 146-р талд бичсэн. Монголын нууц товчоонд Дува сохорыг 4 хүүхэдтэй “дөрвөн овогтон болж” (11§) гэсэн. “Бэлгүнүдэй бэлгүнүд овогтон боловаа. Бүгүнүдэй бүгүнүд овогтон боловаа” (42§) гэснээс өөр ахиж ганц ч удаа гардаггүй. Бас бусад түүхэн сурвалжид ч хараагддаггүй. Чингис хааны хамгийн ойрын шадар туслах улсын ван Го Мухулайн уг удмын, тодруулж хэлбэл жалайрын тухай, Зэлмийн уг удмын тухай, татаруудын уг удмын тухай огт байдаггүй. Бас хэрэйд, найман, мэргэд зэрэг Монгол олон аймгийн уг удмын талаар дурдаагүй. Жамухаас Жажирдай хүртэл ердөө таван үеийн тухай дурдсан. Гэтэл Чингис хаанаас Хабич баатар хүртэл 9 үе байна.

(Эл өгүүллийг Их монгол улсын 790 жилийн ойд зориулан 1996 оны VII/22-нд бичиж дуусаад арай хураангуй байдлаар “Засгийн газрын мэдээ” сонини хавсралт “Нямваригийн” 1996 оны VII/14-ний №28 хэвлүүлсэн. Энэ удаа бага зэрэг засаж найруулав. 2001 VII/25.)

Чингис хааны төрсөн он, сар, өдрийг батлан өгүүлэх нь буюу Чингис хааны гурван чухал он

1. Чингис хааны төрсөн оны талаар өнөөгийн дотоод гадаадын эрдэмтэдийн өгүүлсэн зүйлс.
2. Монголын өтгөс буурлуудын түүхэн зарим сурвалж бичгүүдэд (XVII-XIX) зууны өгүүлсэн зүйлс.
3. Тэмүжин Хамаг Монголын болон Их Монголын хан (хаан) болсон он.
4. Рашид Ад-дины “Судрын чуулганы” Чингис хааны төрсөн, хаан суусан онууд зөрчилтэй болох, Доссон ганц төрсөн оныг буруу, бусад оныг зөв өгүүлсэн зүйлс.
5. “Юан улсын судар”, түүний орчуулгад өгүүлсэн нь Монгол сурвалж бичигтэй тохирдог зүйлс.

1.Чингис хааны төрсөн оныг эрдэмтэд янз бүрээр бичсээр байна. 1932-1936 онд БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн дарга асан Амар гуай “Европын 1162 он бөгөөд 3-р жарны усан морин жилийн зуны тэргүүн сарын 15-ны өдөрөө Онон голын хөвөө Дэлүүн болдог толгойн газараа Чингис хаан төрөв ... Зарим түүхэнд Тэмүүжинийг Европын 1155 онд төрсөн хэмээн бичсэн байх бөгөөд ... үйл явдалыг энэхүү он лугаа зохицуулан тааруулж бичсэн байх амуй” гэж 1934 онд анх хэвлэгдсэн “Монголын товч түүх” номондоо (166-167-р тал) бичжээ.

“БНМАУ-ын түүх. УБ. 1966 он (анх 1954 онд хэвлэгдсэн) гэсэн зөвлөлт, монголын эрдэмтэдийн хамтын бүтээл болох эл номын 112 дугаар талд “Тэмүүжин ... 1262 онд төржээ” гэсэн. 113-р талд “1166 онд Есүхэй баатар татар аймагт хорлогдон нас баржээ” гэжээ. Энд дурдсан “1262” нь хэвлэлийн алдаа болов уу? “1162” гэж байх ёстой байх. Гэтэл 1162 он Есүхэй баатрын нас барсан он 1166 онтой зөрчилдэж байна. Учир нь Есүхэй баатар Тэүүжиний 9 настай (хий нас оруулсан) байхад нас барсан тул Тэмүүжиний төрсөн он 1166-8=1158 гарч байна, Уг бүтээлийн 1984 оны 3 дахь хэвлэлийн 147 дугаар талд “Тэмүүжин 1162 оны 5-р сарын 31-нд төржээ... 1170 онд Есүхэй баатар.. нас баржээ.” гэсэн байна.

“БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ.1966” гэсэн манай эрдэмтэдийн бүтээл болох номын 203-р талд “Тэмүүжин 1162 оны зун төржээ” гэж бичээд зүүлтийн тайлбарт “Чингис хааны төрсөн оныг 1155 (Рашид-ад-дин), 1262 (Юан улсын судар), 1167 (Мөн Хун) гэж янз бүр бичсэн” гэсэн байна. “Монгол татарууд Ази-Европод. УБ. 1984 он” номын (Анх 1970 онд Москвад хэвлэгдсэн номын орчуулга) хариуцлагатай редактор академич С.Л.Тихвинский гуай уг номын 5-р талд “Тэмүүжин 1155 онд төрсөн” гээд 25-р тал дахь 28-р зүүлтийн тайлбарт “ихэнх эрдэмтэд, түүний дотор хятадынх, 1155 оныг Чингис хааны төрсөн он гэж үздэг” гэж өгүүлжээ.

Энэ номын 550-р талд эрдэмтэн Л.Н.Гумилев гуай “түүний төрсөн он нь 1155 болж байна... Тэмүүжин есөн настайдаа эцгээ алдах хүртэл (1171)...” гэжээ. 1171-9=1162 он гарч 1155 онд төрсөн гэсэнтэй нь зөрчилдэж байна. Мөн номын 31-р талд доктор Ш.Сандаг гуай “...Чингис хаан, нэг мэдээ сэлтээр, 1162 он, нөгөөгөөр 1155 онд төржээ.” гэсэн.“Большая советская энциклопедия” номын 29-р ботийн 604-р талд “Чингисхан...ок.1155-25.8.1227” гэсэн байна (1978 оны 3 дахь хэвлэл). “Советский энциклопедический словарь. Москва.1985” номын 1488-р талд “Чингис хан (Тэмүүжин) ок.1155-1227” гэсэн байна. 1993 онд Оксфордод хэвлэгдсэн нэвтрэхий толь бичгийн 3-р ботийн 1999 онд хэвлэгдсэн орос номын 376-р талд Чингис хан (Genghis han) ок. 1162-1227 (“Оксфордская иллюстративная энциклопедия. Том 3.”Весь мир”1999”) гэсэн байна. “Я познаю мир. Иллюстрированная история с древнейших времени до XVIII Века. Энциклопедия. АСТ. 1999” номын 271-р талд Чингис хааныг 1167 онд төрснөөр бичжээ.

Академич Ш.Нацагдорж гуай “Чингис хааны цадиг. Улаанбаатар.1991 он” номынхоо 24-р талд “Тэмүүжин III жарны усан морин жилийн зуны тэргүүн сарын 16-ны тэргэл өдөр европын 1162 оны 4- сарын 16-ны өдөр... төржээ” гэж бичсэн байна. “4-р сарын 16” нь европын (аргын тооллын) тооллын сар, өдөр бус болов уу. Чулууны далай. Монголын түүх. Их монгол улс. 1206-1260. Дэд дэвтэр. УБ. 1994 он” номын 39-р талд Ш.Нацагдорж гуайтай адил өгүүлээд “академич Ишкамц “1162 оны 5-р сарын 31-нд төрсөн...” гээд 68-р тал дахь тайлбарт “Хун Цзюнь, Юй Баян, Бартольд, Владимирцов, Греков, Якубовский нар 1155 онд төрсөн гэж андуурч бичжээ” гэсэн байна. Бас “Пеллио 1167 онд төрсөн гэснээс хойш Францад хэвлэгдсэн хэд хэдэн номонд, Японд 1957 онд хэвлэгдсэн “Дэлхийн нэвтрэхий түүх”-эд, 1960 онд англиар хэвлэгдсэн “Исламын нэвтрэхий толь”-д бүгд 1167 онд төрсөн

гэж бичжээ. (өмнө дурдсан номын 69-р тал)

Г.Е.Грумм-гржимайло. "Западная Монголия и урянхайский край. Том. II.1926.Ленинград" номын 401 дүгээр талд Чингис хааныг 1155 оны 2-р сард төрсөн гэсэн. "Хүүхэд залуучуудын нэвтэрхий тольд"-д Чингис хааны төрсөн он, газрын тухай байхгүй боловч "Хамгийн харгис, хэрцгий" гэсэн байна. Арын нэrsийн жагсаалтанд нэр нь ч байхгүй.

Өвермонголын эрдэмтэн Т.Мансан гуай "Шинээр орчуулж тайлбарласан Монголын нууц товчоо. Өвермонголын Ардын хэвлэлийн хороо.1985" номынхоо 39-р талын тайлбарт Чингис хааны төрсөн оныг 1155 он гэж боддогоо бичсэн байна. Мөн Америкийн монголч эрдэмтэн монгол Загчидсэцэн гуай бас 1155 он гэдэг гэжээ. Чингис хааны төрсөн оныг Японы эрдэмтэн "Накая Мичиё бол 1162 он" гэсэн гэж Японы эрдэмтэн Кацуфужи Такайши "Чингис хаан" номондоо дурдсан ("Чингис. Хубилай хаан. Өвермонгол.1987 он" номын 60-р тал) Мөн Кацуфужи Такайши 1162 он гэж үзэж байгаагаа бичсэн.(60-р тал). Нака Мичиё энэ үгээ 1907 онд монголоор "Чингис хааны магад тэмдэглэл" гэдэг Монголын нууц товчооны япон орчуулгын тайлбартaa бичсэн болов уу.

1962 онд "...Манай түүхчид, гандан хийдийн зүрхайч нар монгол, хятад, түvd түүхийн сурвалж баримтыг шүүрдэн тунгааж, магадлан тооцоолсноор Чингис хааны төрсөн он, сар, өдөр аргын 1162 оны V/31-ний өглөөний 6 цаг орчим тохиожээ.(Ж.Болдбаатар. Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэсэн паян. УБ. 1994 номын 10-р тал) гэж манай түүхч Ж.Болдбаатар гуай бичжээ."

<<Дундад улсын тэмдэглэлд олонхи нь бүр 1162 оныг баримталдаг байна.>> гэж Өвермонголын эрдэмтэн Сайшаал гуай анх 1987 онд хэвлэгдсэн <<Чингис хааны товчоон>> номондоо өгүүлсэн (<<Сайшаал.Чингис хааны товчоон. Дээд дэвтэр.Өвермонголын Ардын

хэвлэлийн хороо.1991>> номын 24-р тал).

Энд би Чингис хааны төрсөн оныг ихэнх хүмүүсийн баримталдаг 1162 онг гэдгийг монголын арав гаруй түүхэн сурвалж, гадаадын "Судрын чуулган", "Доссоны түүх" "Юан улсын судар" ашиглан нотлон өгүүлэхийг хичээе.

2.Чингис хааны төрсөн оныг тогтоож болох уу? Монголчууд наасаа мэддэг байсан уу? Гэсэн асуулт гарч ирнэ. Өмнөд Сүн улсын элч Чжао Хуны (1221 онд Их монгол улсад элчин болж ирсэн) "Монгол татарын тухай бүрэн тэмдэглэлд" (Болгбаатар биеэр дайлсан тэмдэглэл. Өвермонголын соёлын хэвлэлийн хороо.1985 он номын 184-р тал) "насыг нь асуувал хэдий чинээ удаа ногооруулав" гэдэг гэсэн. "Ногооруулав" гэдэг нь хавар болохыг хэлжээ. Нуудэлчин малчин хүний хамгийн чухал цаг үе нь хавар болж ногоо ургах явдал байх нь аргагүй бизээ. Иймд ямар ч байсан наасаа мэддэг байжээ. Гэхдээ наасаа нуудаг байсан байж магадгүй. Одоо ч гэсэн зарим хүн наасаа хамаагүй хүнд хэлж болохгүй гэдэг. Нууц товчоонд Чингис хаан, Өгөдэй хааны төрсөн жил, насыг бичээгүй.Гэвч хожмын сурвалжуудад тодорхой бичсэн. Чан Чунь бумба Чингис хаанд наасаа худал хэлсэн гэсэн.

Монголын нууц товчоонд "Тэмүжиний 9 наст бүхийд Зоч Хасар 7 наст ...Хачиун элч 5 наст, Тэмүгэ отчигин гунан наст бөлгөө." (60§) Берте үжинийг "Тэмүжинээс нэг нас их, арвантай ажгуу" (66§) гэсэн. "Тэмүжин 11 наст бүхий дор ... (11, 6§)"

Лу.Алтан товч номонд "Сод бодг Чингис хаан Цагаадай хөвгүүнээсээ <<хуримын дээд хурим аль буй>> хэмээн асуугаад өөрөө эцгээс үүдэж, эхээс төрсөн өдрөө олж хүндэл" гэснээс үзэхэд Чингис хаан төрсөн өдрөө мэдэж байсан бизээ. Монголын ууган гайхамшигт түүхэн сурвалж болох "Монголын нууц товчоо"-нд Чингис хааны дээд 22 үеийг нэр, ус, цол, хочоор нь өгүүлсэн ба <<тахиа жил>> аргын тооллын 1201 оноос хойшхи явдлын

оныг арван хоёр жилийн нэрээр өгүүлсэн байна.

"Монголын нууц товчоо"-нд Тэмүжиний төрсөн оныг шууд бичээгүй боловч төрсөн онтой нь холбоотой чухал үйл явдал тэмдэглэжээ. "Тэнд Есүхэй баатар татарын Тэмүжин - Үгэ, Хорь Буха тэргүүтэн татарыг дайлж ирвээс...Өзлүн үжин... Ононы Дэлиун болдогт... Чингис хааныг... төржээ. Төрөхдөө баруун гартаа шагайн төдүй нүдүн (нэж) атган төржээ. Татаарын Тэмүжин - Үгийг авчирсанд төрөв хэмээн Тэмүжин нэр өгев..." ("Т.Дашцэдэн. Монголын нууц товчоо. (Латин галиг) УБ.1985 он" номын 23-р талын 275-278 дугаар мөр. Энэ номыг [1] гэж тэмдэглэн иш татна. Энд ганц нэг үгийг одоогийн хэллэг, бичлэгээр бичив.)

Чингис хааны төрсөнтэй холбоотой Есүхэй баатрыг Татаартай байлдаж, тэргүүн Тэмүжинийг барьж авчирахад Тэмүжин төрсөн гэдгийг Монголын 10 гаруй сурвалж бичиг, Рашид-ад-дины "Судрын чуулган", (1301-1310) "Дай Юан улсын түүх (1368-1370)" номуудад мөн адил өгүүлсэн байна. (Юан улсын түүхээс" 1644 онд Монголчилж орчуулсаныг өвөрモンголд 1987 онд хэвлэсэн "Дай Юан улсын түүх" номын 11-р талд үз.)

Монголын нууц товчоонд "Есүхэй баатар Тэмүжнийг есөн нас бүхүйд... охин гүйсүү гэж Тэмүжинийг авч ёрчов (яавав) [1] (23-24-р тал 286-288-р мөр). Есүхэй баатар зуур... татар хуримлан бүхүйд...буув. Хор хольж өгев. Гурав хоног явж гэртээ ирээд...нөхцөв" ([1].331,335,345-р мөр) гэсэн байна. Өвөрモンголын эрдэмтэн Сайшаалгуй "Чингис хааны товчоон" номын дээд дэвтрүүрийн 25-р тал дахь тайлбарт Есүхэй баатрын нас барсан оныг <<Сүн улсын Сияазун хааны VI он (1170) гэж Ли Вен Диян нууц товчооны тайлбарт тэмдэглэжээ>> гэсэн. Иймд $1170-(9-1)=1970-8=1162$ он гарна. "Лувсандамбийжалсан Алтан товч. Altan tobci. Хөх хот. 1998" номын 50-р талд, "цагаан барс (1170 он) жилд Есүхэй баатар нөхцөөд" гэж бичсэн байна."Алтан товчоо" 1765 онд бичжээ. Жамбадорж "Болор тольд" мөн

ингэж өгүүлсэн.

Монголын нууц товчооны дараа орох бараг нууц товчооны орчуулга гэж үзэж байсан "Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл" (1266-1273 оны ном; монгол эх нь олдоогүй харин хятад орчуулгаар үлдсэнийг өвөр монголд Монголчилон хэвлэсэн) номын 36-р талд <<Чингис хаан Ван хааныг сөнөөсөн өвөл (1203)...42 сүүдэртэй бөлгөө, 53-р талд "Улаан нохой жилийн хавар Тангад улсад хүрсэн, тэр үед Чингис хаан 65 сүүдэртэй" гэснээс бодвол мөн 1162 онд төрсөн>> гэж гарна.

Монголын нууц товчоонд "Тэдүй эсгий туургат улсыг шударгатхаж барс жил Ононы тэргүүн хурах, есөн хөлт цагаан туг байгуулаад Чингис хаанаа хан нэр тэнд олгов".([1] номын 146-147-р тал; "шударгадхаж" нь нэг гар, нэг жолоонд орууллаа гэсэн үг. Энд шударга, шулуун нь нэг чиг (зүг) гэсэнтэй төстэй, муруй гэсэнтэй эсрэг угтатай хэрэглэсэн). Энэ барс жил нь "улаан (бин) барс" буюу аргын 1206 он. $1206-1162=44$ буюу хий нас оруулан 45 насандаа хаан болсон.

"Хураангуй алтан товч", "Лу. Алтан товч", "Гангийн урсгал", "Монголын боржигид овгийн түүх", "Болор эрих", "Алтан эрих", "Хөх судар" зэрэгт "улаан барс жил 45 насандаа" Чингис хааныг хаан их ор суув гэсэн. "Богд баатар биеэр дайлсан түүх (1266-1273)", "Асралгч нэртийн түүх", "Алтан хүрдэн мянган хигээст", "Мэргэн гэгээний алтан товч"-ид улаан барс хан (1206 он) хаан болов гэсэн.

"Чингис хаан... тангад иргэнийг моходхаж ирэж, гахай жил тэнгэрт гарав" ([1], 201-р тал) гэсэн. Энэ дурдсан гахай жил нь улаагчин гахай буюу аргын 1227 он ажээ.

1624 онд сийлсэн Дуутын бичигт хадны Цогтын бага бичигт "Чингис хааны төрсөн усан морин жилээс...(Ч.Хишигтогтох. Монголын эртний утга зохиолын судлал. Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо.1988" номын

436-р тал) усан морин жилүүдээс байж болох 3 он 1102, 1162, 1222 болно. Эндээс ганц 1162 он тохирох нь мэдээж хэрэг. Учир нь Тэмүжин 1206 онд Их монгол улсын хаан (уг нь хан гэдэг байжээ. Хожим хаан болсон. "Ван хаан" ч "Ван хан" байжээ.) болсон, 1227 онд нас барсан гэдэг нь маргаангуй ажээ.

Чингис хааны төрсөн оныг тодорхой бичсэн анхны түүхэн чухал сурвалж болох Лувсандаанзын Алтан товч (товчоор Лу. Алтан товч) нь "Монголын нууц товчооны" Чингис хааны хэсгийг бараг тэр хэвээр нь агуулсан байдаг. Энэ номын 1990 оны УБ хотын хэвлэлийн (1628-1634, 1667 онд бичигдсэн гэдэг) 12-р хуудсанд "... хар морин жилийн зуны тэргүүн сарын 16-ны улаан тэрэгэл өдөр дөл цагт Чингис хаан төрөө" гэжээ.

Хар морин жил нь аргын 1162 он. Чингис хааны төрсөнтэй холбоотой үйл явдал, Чингис хааны есөн настай, Бүрт үжинийг арван настай байхад сүй тавьсан, Есүхэй баатрын нас барсан зэрэг нь нууц товчоо, Бямбын "Асрагч нэртийн түүхтэй" яг адил байна. "Дөчин таван насандаа бин (гал) барс жилд Онон мөрний тэргүүнээ ... хаан ор суувай" (13,33-р хуудас а.тал), "22-р он улаагчин гахай жилд 66 насандаа VII/12 тэнгэр болов" (126-гийн б. тал) гэж өгүүлснээс тооцоолбол бас л 1162 он гарна. Нууц товчооны 94-р зүйлд <<Тэмүжин... Бөрт үжинийг 9 наст бүхүй дор үзэж>> гэж байдаг. <<дор>> үгийн дараа "ийн үг орхисон байж магадгүй. "Наст" үгийг нууц товчоонд эрэгтэй хүнд хэрэглэдэг тул ийнхүү дүгнэж байна. Эмэгтэй бол настай гэдэг. Энэ өгүүлбэрээс андууран "Хураангуй алтан товч", "Эрдэнийн товч", "Хөх судар" Бертийг 9 настай гэж бичсэн болов уу.

Зохиогчийн нэргүй "Хураангуй алтан товчид (1604-1634 онд зохиогдсон) гэдэг "Чингис хаан хар мөгий жилт буюу 45 насандаа "бин барс жил хаан их ор суув". Өвөр mongolын 1988 оны Булаг гуайн харгуулж тайлбарласан, "Хадын үндэсний хураангуй алтан товч" номын 32-р тал

("Хад нь "хан"-ын олон тоо, хаад) Бин (гал) барс жил 1206 онд 45 настай байсан гэдгээс тооцоолбол 1162 он гарна. Могой жил нь эм жил ёнгө нь <<гчин>>ээр тэгсөх тул харагчин байх ёстой. Гэтэл энд <<хар>> гэсэн тул жил нь эр, тухайлбал <<морин>> байхад тохирч байна. Харагчин мөгий жилүүдээс арай ойр нь 1113, 1173 хоёр огт тохирохгүй нь илэрхий. Цагаагчин мөгий нь 1161. Энд "морин жил" гэхийг мөгий жил гэж андуураад "морины" ёмнө мөгий байдаг тул "67" настай гэсэн бололтой.

Шар туужид (1604-1634) "...гал морин жилд хувилгаан Чингис хаан төрж, 28 насандаа Хэрлэнийн Хөдөө аралд хаан болов" (Шар туджи. Монгольская летопись XVII века, 1957 номын 22-р тал) гэсэн. Энд жилийн махбодийг эндүүрсэн нь илэрхий байна. Гал (улаан) морин жилүүдээс арай дөхүү 1126, 1186 тохирохгүй нь илэрхий. "Гал гахай жилийн хаврын адаг сарын 16-наа 66 насандаа... нөхчивэй" (39-р тал). Эндээс гал гахай жил нь аргын 1227 он тул 1227-65=1162 нь төрсөн он болно.

Тэнгэрээс заяат Тэмүжин III жарны хар морин жил өвлүйн тэргүүн сарын шинийн нэгний үүр цайх цагт мэндэлвэй. <<Хөх түүх. (1796-1820) Өвөр mongol 1999 он>> номын 45, 47-р тал гэснээс тооцоолбол бас 1162 он гарна.

"Сагансэцэн. Эрдэнийн товч. 1162 он", "Бямба. Асрагч нэртийн түүх. 1666 он", "Гомбожав. Гантын урсгал. 1725 он", "Ломи. Монголын боржигид овгийн түүх. 1735" Дармаа. Алтан хүрдэн мянган хигээст. 1739. Лувсандамбийжалсан (мэргэн гэгэн). Алтан товч. 1765, "Рашипунцаг. Болор эрих. 1774-1775", "Ната (Гомбо) Алтан эрих. (1817)", "Хөх түүх 1796-1820", "Галдан. Эрдэнийн эрих. 1841", "Жамбадорж. Болор толь. 1846-1849" зэрэг түүхэн сурвалжуудад (арав гаруй) Тэмүжинийг усан морин жил төрсөн гэжээ. Зарим нь бүр "элдэв" хэмээх буюу сайтар гарсан туулай жилийн III буюу бүр III жаран гэж жарны нэр, дугаарыг ч тодорхой заажээ. Бямба.

Асрагч нэртийн түүх номын 11-р тал, Ломи. Монголын боржигид овгийн түүх номын 55-р тал, Мэргэн гэгээн. Алтан товч номын 39-р талд Хасарыг модон буюу хөх бичтэй гэсэн нь 1164 он болно. «**Тэмүжин есөн наст бүхүйд Зочи Хасар долоон наст бөлгөө»** ([1], 23-р тал. 60.283-284-р мөр) гэсэн. Эндээс үзвэл Тэмүжин, Хасараас 2 насаар ах байгаатай тохирч байна. (1164-1162=2)

1825 онд бичсэн “Монголын уг эхийн түүх” эд Чингис хаан цагаан морин жил төрсөн. (Ойрад түүхэн сурвалж бичиг. Хөх хот. 1985 номын 306-р тал) гэсэн нь жилийг зөв өгүүлэн махбодийг (өнгийг) цагаан гэж буруу өгүүлжээ.

Монголын анхны адал явдлын түүхэн романы зохиогч боржигид овогтой В.Инжиннаш /1837-1891/ гуй “Хөх судар” (товч нэр нь) гэдэг алдарт бүтээлдээ олон түүхэн (хятад, монгол, төвд хэлний) сурвалж харгуулан үзэж хянан шалгаад “Сүн улсын Х дугаар хаан Гоо эунгийн шоу шин” хэмээхийн 32-р он, Алтан улсын V дугаар хаан Шизунгийн да дин хэмээхийн II он хар морин жил тэнгэрийн бошгоор улирлыг нээсэн бодг баатар Хуанди **Чингис тайзу хаан хар морин жилийн 4 дүгээр сарын 16-ны морин цагт... мэндэлвээ**. Энэ нь олон зүйлийн бичиг судар бүгдийг нийлүүлж барьж, бодож гаргасан тоо товчоо тул өчүүхэн ч эндүүрэл үгүй хэрэг. Бодг Чингис хаан 45 насан сүүдэр дор... улаан барс жил... хаан суусан... гэж бичжээ. (С.Инжиннаш. “Хөх судар. Тэргүүн дэвтэр. Хөх хот. 1991 он” номын 8,96-р талд). Морин цагийг 11-13 буюу 11 цаг 40 мин-13 цаг 40 мин гэж үздэг байна. Лу.Алтан товчид дурдсан “өдөр дөл” нь морин цаг ажээ. Иймд Лувсанданзан, Инжиннаш гуй хоёрын өгүүлсэн жил, сар, өдөр, цаг нь ч тохирч байна. “Улаагчин гахай жилийн 12 сарын 12-ны шарагчин үхэр өдрийн морин цагт тэнгэр болвой. (1766 дугаар тал). Чингис хаан өвөг 66 сүүдэртэй. Их хааны сууринд 22 жил суув.” (Хөх судар, III дэвтэр, 1767 дугаар тал) гэжээ.

Чингис хаан элдэв хэмээх усан морин жил /1162 он/ төрөөд улаагчин гахай жил /1227 онд/ нас барж хий нас оруулснаар 66 нас насалжээ.(Энд “элдэв” гэдэг нь жарны нэр). Чингис хаан нас барсан оныг ганц Ломи Монголын “Боржигид овгийн түүх. Хөх хот” номын 55-р талд “Чингис хаан улаан барс жил 45 насандаа... сууринд суусан... 24 жил сууринд сууж 68 настай үхэр жил нөхцөв” гэсэн. Үхэр жил нь 1229 он болно. 2 нас хэтрүүлсэн. Гэтэл гутгаар он үхэр жил Өгөдэй хаан суусан гэдгээс нь болвол 1227 онд өөд болсон гэж гарна. Үхэр жил нас барсан гэдэг нь эндүүрэл байна.

Чингис хааны төрсөн газар Онон мөрний Дэлүүн болдог нь одоогийн Хэнтий аймгийн Дадал сумын “Гурван нуур” гэдэг газар төржээ. (БНМАУ-ын түүх тэргүүн боть. УБ.1966 номын 203-р тал)

Эрдэмтэн Д.Базаргүр. “МНТ-нд гардаг газар зүйн нэр ийг тодотгох арга зүйн асуудалд” өгүүлэхдээ “Дэлүүн болдог нь одоогийн Биндэр сумын төвийн өмнөх памын ухаа.(Энд Чингис хаан төржээ) гэжээ. (Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал. I.УБ.1995 номын 244-р тал)” гэжээ.

3. Саган сэцэн. Эрдэнийн товчийн 84-р тал, Рашипунцаг. Болор эрихийн 34-р тал, Хөх түүхийн 47-р тал, Галдан Эрдэнийн эрихийн 132-р тал, Инжиннаш. Хөх судар. Тэргүүн ботийн 129-р талд Тэмүжин 17 настай байхдаа Бөрт үжинтэй гэрлэсэн нь шар нохой жил аргын 1178 он тул тооцоолбол $1162+(17-1)=1162+16=1178$ он болно. Нууц товчооноос үзэхэд Тэмүжин нар Ван хаанд 1178 онд булган дах бэлэглэсэн. Мэргэдэд Бөрт үжинийг булаалгаад, Ван хаанаас тусlamж гүйхаар очиход Ван хан нь «**«ноднин»** гэж хэлснээс үзэхэд Бөрт үжин нь 1178 онд баригдаад 1179 онд чөлөөлөгджээ. (Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр. 150-р тал). Жамухтай жил хагас болсон тул Сайшаал гуайн бичсэнээр 1181 IV/

16 (дурдсан номын 158-р тал) Чингис хаан, Жамуха хоёр салж нүүжээ. (IV/16 билгийн тооллын сар өдөр) ийм учраас Асралч нэртийн түүх, Дармаа. Алтан хүрдэн мянган хигээстэд Тэмүжинийг Хамаг монголын хаан болсон жилийг **хар барс жил** (1182) гэсэн нь монголын нууц товчоо Лу. Алтан товчийн өгүүллээс үзэхэд илүү үнэмшилтэй байна. Нууц товчоонд “Хар зүрхний Хөх нуур буув. Алтан, Хучир, Сача бэхи эедэлдэж Тэмүжинээ: өгүүлэрүүн чамайг хан болгоё”([1], 58,59), Лу. Алтантовчид <<Хөх нуурт бууж, Алтан, Хучир, Сачи бэхи эедлэлдэж (ээлэлдэж) Тэмүжинээ өгүүлэрүүн: Чамайг хан болгоё>> (326) гэсэн ба 33-р хуудасны эхний нүүрэнд <<45 насандаан бин барс жилд Онон мөрний тэргүүнээ есөн хөлт цагаан тугаа байгуулж... хаан их ор суувай>> гэсэн. Лу. Алтантовчид Тэмүжинийг Хамаг монгол аймгийн ба Их Монгол улсын хаан(хан) болсныг тодорхой өгүүлсэн боловч оныг ялган өгүүлээгүй, бүрхэгдүүлсэн.

<<Монголын нууц товчоо>>, <<Асралч нэртийн түүх>>, <<Дарма. Алтан хүрдэн мянган хигээст>> гурав л Тэмүжинийг Хамаг монголын болон, Их Монгол улсын хаан болсоныг маш тодорхой ялган өгүүлсэн бөгөөд сүүлийн хоёр сурвалжид бүр Хамаг монголын хан болсон жилийг “усан барс” (1182 он) гэсэн нь маш сонирхолтой. Шар туж, Эрдэнийн товч, Эрдэнийн эрихэд шарагчин тахиа (1189 он) жил Хөдөө аралд 28 насандаа хан болсон гэсэн.

Улаан барс жил (1206 он) хаан суусан газрыг Ононы тэргүүн буюу Онон мөрний эх гэсэн.

4. Одоо гадаадын эрдэмтэдийн бүтээлээс өгүүлье. Өмнө дурдсан Сүн улсын элчин Чжао Хун Чингис хааныг “Хөх нохой жилд” (1154 онд) төрсөн гэсэн нь Рашид-ад-дины 1155 онтой ойролцоо байна. Иймд Чингис хааныг 72 буюу 73 насалсан гэдэг нь огт оргуй зүйл ч биш бололтой. Рашид-ад-дины өгүүлснээр харин 72(73) насалсан гэдэг нь бичгийн баримтгүй итгэмжит хүмүүсийн аман өгүүлэл ажээ. Чингис хаан наснаасаа оворжуу

(буурьтай) харагддаг байсан тухай Рашид-ад-дин судрын чуулгандaa Чингис хааны хэсгийн эцэст “нэгэн өглөө босоход Чингис хааны туг үс нь цайсан бөгөөд учрыг нь асуухад их улсын эзэн буурьтай харагдах ёстой гэсэн зүйл өгүүлсэн байdag.

Чингис хааны нас барсан оныг анх Жүвэйни “Чингис хаан 624 оны VIII/4 (1227 оны VIII/8) хүний өртөнцөөс ангижрав” гэжээ. (Жүвэйни. Дэлхийг байлдан дагуулагчидын түүх. Хөх хот. 1989 он, номын дээд дэвтэрийн 306-р тал). Рашид-ад-дин “Судрын чуулгандaa” Чингис хааныг төрөх үед монголчууд одон орны тоолол (зурхай) хэрэглэдэггүй байсан тул Чингис хааны төрсөн оныг тодорхойлох боломжгүй аятай юм өгүүлсэн нь бодит байдалд нийцэхгүй. Нууц товчоонд тахиа жил 1201 оноос хойшхи явдлыг нохой, гахай гэх мэт арван хоёр жилийн нэрээр өгүүлсэн. Чингис хаанд 1215 оноос Шадар туслагч болсон Кидан юлой Чуцай (урт сахалт) нь алдартай зурхайч байсан бөгөөд Өгөдэй хааны үед бичгийн сайд, сударч түшмэл байсан хүн Чингис хааны төрсөн оныг тогтоож чадах нь лавтай.

Рашид-ад-дин Чингис хааныг гижрийн тооллын 549 онд (гахай жил) төрсөн (Сборник льтописей, История монголовъ, Санктпетербургъ 1868 номын 85-р тал), 624 (гахай жил) нас барсан гэсэн. Сборникъ Лъетописей. История Чингизъ-хана отъ возшествія его на престоль до кончины. 1868 СПб 111-р тал. Гижрийн 549 он нь нарны буюу аргын он тооллын 1155, 624 он нь 1227 он ба $624-549=75$, $1227-1155=72$ гардаг. 75 гардаг нь сарны тоолол (Билгийн улирал) 30-н жил тутам нарны (аргын) тооллынхоос 1 жил илүү байдгаар тайлбарласан. Гэтэл хачирхалтай нь гахай жилд төрсөн хүн 75(74) наслахад гахай жилд нас барсан байж огт таарахгүй ба хий нас оруулбал 73, эс оруулбал 72 наслансаа байж гахай жилд төрөөд гахай жилд нас барсан байх ёстой. 75-н насыг аргын тооллын нас гэж үзээд зарим хүн $1227-75=1152$ тул 1152-1153 оныг бас Чингис хааны төрсөн он

гэдэг бололтой. Рашид-ад-дин "Судрын чуулган. УБ.1994" номын 118-р талд "Чингис хааны... ертэнцэд амьдарсан хугацаа нь 72 жил, хаанчлал нь 23 жил" үргэлжилсэн гэсний 72 жил нь аргын тооллын он байна. 23 жилийг нь 22 жил гэвэл монголын түүхэн сурвалжуудтай тохирно...) Чингис хааныг барс жил гижрийн 602 онд хаан ширээнд суусан гэдэг нь аргын тооллын 1206 он монголын нууц товчоо, бусад түүхэн сурвалж, хятадын мэдээтэй тохирдог. Харин хаан суусан насыг 51, 52 гэдэг нь 45 насандаа суусан гэдгээс зерж байна.

Есүхэй баатрыг нас бараад Тэмүүжин 13 настай (хий нас оруулаад) байсан гэдэг нь нууц товчоонд өгүүлдэг 9 настай гэдэгтэй тохирохгүй байна. Бид нууц товчоондоо итгэх нь зүйн хэрэг. $13-9=4$ ба $51(52)-45=6(7)$ (хаан суусан үеийн нас $1162-1155=7$ гарч оны зөрөөнүүд тохирохгүй байна. Бас Рашид ад-дины "барс жил, 602 онд Чингис хааны 50(51) насандаа хаан болсон гэдгээр бодвол $602-50(51)=552(551)$ гарч 549 онд тэрсэн гэдэгтэй харшилна. Чингис хаан эцгийгээ нас бараад 13 настай байсан гэж Рашид-ад-дин, Галдан (Эрдэний эрэхэд) дурдсан нь үнэндээ Дай Юан улсын түүхэнд өгүүлснээр 13 насандаа Боорчтой нөхөрлөснийг эндүүрсэн бололтой. Эсвэл "Тайзу арван гурван насандаа татар аймгийг нэг удаа байлдаж...(Хөх судар тэргүүн.108) гэсэн санаа юм болов уу".

Рашид-ад-дин "судрын чуулгандaa" Чингис хааны амьдралын 41(40) нас хүртэлхи үеийн явдал тодорхойгүй тул тэр үеийн түүхийг нь он оноор бичээгүй хураангуй өгүүлсэн. Харин үүнээс цааш нас эцэслэлэх явдалыг нь он оноор өгүүлсэн гэдэг нь харин маш чухал мэдээлэл байна. Энэ нь нууц товчоо, Лу.Алтан товчтой тохирч байна. Бас "Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл", "Дай Юан улсын түүх", Дай Юан улсын бичиг Рашинпунсаг Болор эрихэд нохой жил, аргын тооллын 1202оноос эхэлж 12 жилийн нэрээр үйл явдлийг өгүүлсэн ба $1202-1162=40$, хий нас оруулбал

41 гарч тохирч байна. Шар тууж, Эрдэний товч (120§), Хөх сударт Чингис хааныг 19 жил амарч ард түмнийг <>гар газар, хөл хесер>> амаржуулав гэж байдаг нь сонин. Хэрэв Тэмүүжин 1182 онд Хамаг монголын хаан болсон гэвэл $1201-1182=19$ нь харьцангуй тайван бөгөөд түүхийн жил (он) заагаагүй.. өгүүлсэн тэрхүү жилүүд байна. Эдгээр жилийг Чжао хун Чингис хааныг "Алтан хаанд баригдсан жил/ болгожээ. "Зүчи хан ... ертэнцэд амьдарсан хугацаа нь 40жил. (Рашид ад- дин.Судрын чуулган. УБ. 1994 номын 19-р тал). Иймд $72-40=32$ Зүчи нь Чингис хааны 32 насанд тэрсэн гэдэг нь монголын нууц болон бусад түүхэн сурвалжтай дэндүү зернэ. Сайшаал гуайн өгүүлснээр Зүчи 1179 онд тэрсэн.(Өмнө дурдсан номны 155-р тал.) $1226(7)-1179=47(48)$. Иймд Зүчийг 48(49) насалсан Чингис хаан 1162 онд тэрсэн гэвэл монгол сурвалжуудтай тохирно.(Өмнө өгүүлснийг санаад ч тодорхой. Доссоны (Д.Оссон) (1780-1855, Армянийн эрдэмтэн) Франц хэлээр 1824-1852 онд бичсэн. Монголын түүхийн номонд Есүхэй баатар татаар иргэнийг дайлж...ирэхэд нэгэн хөвгүүн 1155 төржээ... гээд (Доссоны Монголын түүх . 1988. Өвөр mongol. Дээд дэвтэр номны 74-75-р тал) "1206 оны хавар... хурапдай хийж ... сүлдийг мандуулав. Тэр жил Тэмүүжин 44 настай байсан" гэсэн. 115-р тал $1155+44=1199$ болж 1206 онтой тохирохгүй байна. Уг номны 327-р талд "Хаан VIII/8 хальсан. Нас сүүдэр 66. Энэ бол 1227 он. Сууринд 22 жил суусан" гэсэн нь монголын түүхэн сурвалжуудын мэдээтэй тохирч байна. Энэ сүүлчийн хоёр мэдээнээс тооцоолбол Чингис хаан 1162 онд тэрсэн гэж гарна. Энэ нь 1155 онд тэрсэн гэдэгтэй нь тохирохгүй байна.

Пеллиогийн Чингис хааны тэрсэн оныг 1167 гэсэн нь Рашид-ад-динаар Есүхэй баатрын нас барсан он $1155+12=1167$ бололтой. Хэрэв Чингис хааныг 1167 онд тэрсэн гэвэл хаан ширээнд суусан нас 40, нас нь 61 болж энэ нь Рашид-ад-дин, Юан улсын судар, монголын түүхэн

сурвалжуудын алинтай нь ч тохирогчий байна. Чан Чунь Бумба 1222 онд Чингис хаантай уулзахдаа “Богд эзэн таны нас өндөр болсон” (Чан Чунь Бомбын баруун зорчсон тэмдэглэл. Өвөрモンгол Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо 1993” номын 174-р тал) гэснээс үзэхэд, хэрэв Чингис хаан 1167 онд төрсөн бол 1222 онд 74 настай Чан Чунь бомбо өөрөөсөө 19 дүү 55 настай Чингис хааныг юу гэж өндөр настай гэх билээ. Харамсалтай нь өмнө дурдсанчлан Япон, Англи зэрэг орны хэвлэлд Тэмүжинийг 1167 онд төрсөн гэж бичсээр байна.

5.1368-1370 онд Мин улсын Тайзу хаан (анхны хаан) Чжу Юан Чжанийн зарлигаар бичсэн “Юан улсын сударт”, “Тайзу (Чингис хааны) шастирт” :Хорин хоёр он. Улаагчин гахай жил (1227 он). Намрын 7 сар .Шаргачин үхэр өдөр хаан халив. Нас сүүдэр 66 гэсэн тэмдэглэл байдгийг Сайшаал гуай өмнө дурдсан “Чингис хааны товчооны ” дээд дэвтрийн 24-р талд бичсэн .Манай эрдэмтэн Ч.Далай гуай өмнө дурдсан номондоо Юан улсын судраас мөн ингэж дурдсан байна .

Чингис хааны төрсөн оныг “Японы Нака Мичиё бол 1162 он гэж байна...үндэслэл нь “Юан улсын түүх болно “гэж Кацуфужи Такайши “Чингис хаан номондоо бичжээ.” (Өмнө дурдсан номын 60-р тал) “Юан улсын судраас Чин (манж) улсын хааны зарлигаар хятад хэлнээс монгол хэлээр орчуулж 1644 онд барласан (хэвлэсэн) “Дай Юан улсын түүх” номын Өвөрモンголд хэвлэсэн “Дай Юан улсын түүх. Бээжин 1987” номын 76-р талд “тайзу Чингис хааны 22-р он. Улаагчин гахай жил ...хаан...терөл еутгэв. Хаан оронд 22 жил суулаа. 66 настай ажгуу* гэж бичсэнээс бодвол Чингис хаан 1162 онд төрсөн гэж гарна.(Еутгэв (егутгэв) нь солив, халав гэсэн утгатай уг. Шашны үүднээс бичсэн уг.*терөл еутгэв* гэдэг. Энэ нь одоогийнхоор “терөл арилжав “гэсэн уг) урд жилийг нь “хар нохой жил” гэсэн (23-р тал).

Мөн 1644 онд барласан Юан улсын судрыг магадлан шалгаж, орчуулсан гэх “Дай Юан улсын бичиг “ номын өнөө үеийн Өвөрモンголд хэвлэсэн номын 78-р талд өмнө өгүүлсэнтэй адил “Хорин хоёр он улаагчин гахай жил халив...66 настай ажгуу” гэсэн байна. Оросын эрдэмтэн Иаканф Бичуриний Юан улсын үеийн хааны ордны хоёр хятад зохиол ба товчоор “тан-му” гэдэг хятадын “Дэлхий дахины түүх” номуудаас орчуулсан “История первых четырех ханов из Дома Чингисова, с китайского монахом Иакинфом. СПб. 1829” номын 142-р талд бичсэнээс орчуулбал “Монголын эзэн хаан 22 жил хаанчилаж, 66 насандaa өөд болсон” гэжээ. Энэ нь Чингис хааны төрсөн оныг зөв бичсэн оросын анхны эрдэмтэн байж магадгүй.

Дүгнэлт

1. Тэмүжин (Чингис хаан) элдэв хэмээх буюу гуравдугаар жарны усан (хар) морин жилийн зуны тэргүүн сарын тэргэл өдөр (билгийн тооллын 4 дугээр сарын 16) морин цагт (11-13 цаг буюу 11 цаг 40 минутын төржээ. Аргын тооллоор 1162 оны 5 дугаар сарын 1 буюу 31 гэж байна.

Тэмүжин анх усан барс жил (1182 онд) хөдөө аралд буюу шаргачин тахиа жил (1189 он) Хамаг монголын хан болсон.

Эл өгүүллийг болон бусад өгүүллийг Их монгол улс байгуулагдсаны 790 жилийн ойд зориулан 1996 оны VI сард бичиж дуусаад <<Орчлон компаниар>> хэвлүүлэхээр эх бэлдүүлж байгаад санхүүгийн боломжгүй туп больсон билээ. Манай хоёр томоохон сонины газар 1996,2000 онд өгсөн боловч хэвлэгээгүй төдийгүй харин эх бичиг маань алга болов. 2000 оны V сард МУИС- ийн НУФ-ын эрдэм шинжилгээний баага хуралд тавьж хэлэлцүүлсэн. Мөн нууц товчооны 760 жилийн ойн хуралд товч агуулгыг мэдээлсэн болно.

Монголын чууц тоөчоо ба бусад түүхэн сурвалжисын Чингис хааны төрсөн жил зэрэг чухал он,

1	Номын нэр нүүц төвччин гаазар	Тэмүжиний терсөн жил он, сар, өдөр, чаг, гаазар	Тэмүжиний холбоотой гол үйл явдал, онцлог, өгсөн нэр	Егүүжийн базарын нас барсан, Тэмүжин, Боргийн сүй тавсан, гэрэлзэн тухай	Хамаг монголын хан болсон жил, он, нас он, газар буюу бусад мэдээ	Монгол улсын хан болжон жил, он, нас буюу сууринч (хэн ширээнд) суусан жил, газар, улсын нэр	Нас барсан жил, он сар, газар, сууринч (хэн ширээнд) суусан жил
1	Монголын нүүц төвччин	Олоны Дэлгүүн бөлгөг 598)	Төгөөрүүн Тэмүжин-Үг Хорибухыг олзоотж ирэхэд төрсөн. Хар нэж өтөх терсөн. Тэмүжин 598)	Төмүжин 9 настайд. Бөрт 10 настайд сүй тайвад, харих олзоотж ирэхэд өтөх терсөн. Тэмүжин нэхцэн 1685)	Алтан, Хүчир, Саня бэхжүүрэн зедээрэж, хан сонж Чингис црл хүртсэн. Хар хүрхийн Хөх нүүр давж 1235)	Барс жил /1206 он Ононы тэргүүнээ хүрж 9 хөтөл цагаан түг байгуулан ... (202f)	Төнгөлд иргэний моходгох яаж гүй жил /1227/ Түрэмгий баятас/дам/ тэнгэр гарев. 2683
2	Багцаатар биизэр райгасан /1266-1273/	Дэлгүүн бөлгөг 9	Төгөөрүүн Тэмүжин-Үг Хорибухыг олзоотж ирэхэд нэж өтөхжөсөн 9/	Төгөөрүүн Тэмүжин 9 настай бүхийд /29/ Берг нэгтэй, 9 наст охин бүй /18/ Бүгдхэрэв Төтварт хорлогдрун Есүхэй эзэн гарваа тэнэр бохва /26/	Улан барс /1206/ Онон мөрний эхэнц өсөн хөхөлт Цагаан түг манзуулж Чингис хөвн цол өрөмжийгэй /39/ хөгжсан /53/	Улан барс /1206/ Онон мөрний эхэнц өсөн хөхөлт Цагаан түг манзуулж Чингис хөвн цол өрөмжийгэй /39/ хөгжсан /53/	Улан барс /1206/ Онон мөрний эхэнц өсөн хөхөлт Цагаан түг манзуулж Чингис хөвн цол өрөмжийгэй /39/ хөгжсан /53/
3	Хувцасны алтан төвч	Хар Могой/2/ 1113-1173 нь оott төврүүхий. Хар Морь	Хар Могой/2/ 1113-1173 нь оott төврүүхий. Хар Морь	Төмүжин 9 настай бүхийд /29/ Берг нэгтэй, 9 наст охин бүй /18/ Бүгдхэрэв Төтварт хорлогдрун Есүхэй эзэн гарваа тэнэр бохва /26/	Төнгөлд иргэний моходгох яаж гүй жил /1227/ Түрэмгий баятас/дам/ тэнгэр болов /179/ тэнгэр болов /179/ түм. 32/	Төнгөлд иргэний моходгох яаж гүй жил /1227/ Түрэмгий баятас/дам/ тэнгэр болов /179/ түм. 32/	Төнгөлд иргэний моходгох яаж гүй жил /1227/ Түрэмгий баятас/дам/ тэнгэр болов /179/ түм. 32/

4	Цогт тайжийн дүүлүн бага бичиг /1624/	Усан морин жил	Гал морин жил /1126, 1186 Тэмүжин		Шаррагчин тахиа /1189/ Хөдөө аявл 28 нас /22/		Гал тахай 1227 III/6 VII/12 66 настай. Түрэмгий баятас /47/ шүлэгтэй
5	Лувсандаан ян. Алтан товч. /1628- 1634, 1667/ Ононы Дэлгүүн болдог тумчин	Хар морин жил /V/16 Өдрийн дөл цагт /12/ Ононы Дэлгүүн болдог тумчин	Татварын Тэмүжин-Үг Хорибухыг олзоон ирэхэд. Хар нэж аттан төрсөн. /12/ Тумчин /Тэмүжин 12/	Тэмүжин 9 наст, Бөрт Улжийн 10 настай бийжэд сүй тавийд ирэх замд төтварт хорлогдрод гергээ ирээд нас нөхцөн /13, 14 а/ нуурт 9 хөтп цагаан түг /32/	Алтан, Хүчир, Сача бэхж зэдээдэж, Тэмүжин хан сонгож, Чингис цол ётсон. Хар зүрхийн Хөх нуурт 9 хөтп цагаан түг /32/	45 настайдаа бин барс жил Онон мөрний тэртүүнээ 9 хөтп цагаан тугаан байгуулж хаван их ор сувтай /33а/ Хөдөө аявл /дам/ 126/	22-р он, улавжин таях жил /1227/ 66 настадва III/12 тэнгэр болов. Лувсандаан түрэмгий баятасанд /125/. 126/
6	Саган сэцэн. Эрдэнэйн товч. 1 32	Шим морин жил /162/	Татварын Тэмүжиний талж ирэхүүг лүгээ. Тэмүжин /78/	Бөрт 9 настайд Есүхэй баятар сүй тавсан /78/ Төтварт хорлогдон гергээ ирээд нас барсан. Тэмүжин 17. Бөрт 13 /84/сусан	Хий тахиа жил /1189/ Хэрлан мөрний хөдөө аявл. Хөх Монгол, 9 хөтп цагаан түг /87/ 40 түмэн бидээ улс	66 дин таях жил VII/12 Түрэмгий баятаснаа тэнэр эцэгээн ёёд бонон одров.	Барс. Онон мөрний тэртүүнээ. 9 хөтп Чингисин ... ирээд чагаан түгийг /28/ /1266 он/ Хөдөө аявл /дам/ Гитгээдий баятрын уг/ хийн
7	Шамба Бямба/ Асралч нэртийн тух	Ононы Дэлгүүн болдогт. Усан морин жил /162/ V/16	Татварын Тэмүжиний олзоог ирэхүүг хар нэж аттан төрсөн. А/ Хасар модон хөх/ бийтэй /1164/		Барс. Онон мөрний тэртүүнээ. 9 хөтп Чингисин ... ирээд бүхийд Бөрт 10 настай. Бүчээ замд төтварт хорлогрон гергээ ирж нас нөхцөн.		Гал тахай жил III/12 66 минийн түрэмгий баятасанд нэхрэв. Б38 шүлэгтэй

8	Гомбожав Ганнайн урстган /1725/	Ломи Монголын боригод овгийн түүх жил /1162/ 1989 оны хэвлэл	Усан морин жилтэй /1162/				40-ийн дэгэн тал барс жил... Онон мерний эхнээс хөхөн цагаан түг баягуулж, хаван суура. /49-50/	22 он сүүх, 66 гол гажэх жил /1122/ XII сарын 1-н шайд тэнэр бөлбэй. /53/
9	Дармжаа Алтан Хурдан Мянган Хийээст /1739/	Элдээ хэмээх усан морин жил /1162/ /1711/ Хар морин жил /1162/ /26/ гагзан Пүсэндээс ийнжансан Их Монгол Улсын Чидэн алтан төвч /1765/	Татварыг дэлж эзэн Тэмүжинг нь барьж ирхээд (66)	Зүүн эгээдийн Тэмүжин наарт үүсэд ялан олз авч буух дор терсэн.	Дай садийн охин Бергтэжин сэснийг хатан болго авч .. /72/	Хүчэрэхин, Хо бэхж, Сэчин тэн хэлцэлцэх зедэг .. Хатан цол /1822/ 21 насандав ...	Галбарс жил /1206/ Онон мөрний эхнээс хөхөн цагаан түг баягуулж.. Гүр их турэмийн бэлгэс Улсын хаван сувдай.	Галбарс жил /1224 Сүүрийн 24 он цагаантай, хар түг баягуулж. Онон нэхцэв. /55/ VII/12 Энэ нь 1229 он нь гутгаарын Өгээд хаван сувсан гасантай харшигын.
10	Мэргэн гагзан Пүсэндээс ийнжансан Их Монгол Улсын Чидэн алтан төвч /1774-1775/	Хар морин жил /1162/ /26/ хасархөх битээд /1164/ /49/	Татварын Тэмүжин нэгийг ополижирээд хасар нэж этгэн хөөвтэй .. Нөхцөд терсэн гэсэн. /49/	Цагаан барс жил /17/ Тэмүжин барс жил Есүүэй баатар. Бэлэн хатан хөөвтэй .. Нөхцөд 50/	Хаван цол /72/	Улан барс /1208/ Онон мөрний эхнээс цааван түг босгон тогтоогод хөх усны Хийн дверд ижен замар. #2/ Их Монгол улс. /77/	Улаагчин тахай /1227/ Сиёва улсыг тогтоогод хөх усны Хийн дверд ижен замар. #2/ Цогцөрье /51/	
11	Хөх түүх /11796-1820/	Шим хэмээх усан морин жил /1162/ цэйх цагт /47/ Хасар төрсөн.	Элдээ хэмээх усан морин жил /1162/ зүйн цэргүүн сарын тэрэл өдөр IV/15 /16/ Ононы Далтун чолдог	Гашшуучаг Болор эрих. /11774-1775/	18 настай бергийг Тэмүжин бөрье сонгож гарласэн. /34/ /1178/	45-ны Улаан барс жил Чингис хаваны таргумын /64/ Онон мерний эхнээс маанжлагт цагаан түг босгож Тэмүжин хаван боловсрууяа. Чингис чөлөөсөн.	Сиёва улсыг сөнөөх ... 66-ны улаагчин тахай 22- мерний эхнээс чагаан түг /24/ Чингис Их Монгол богбай /21/	Улаагчин тахай /1227/ Сиёва улсыг тогтоогод хөх усны Хийн дверд ижен замар. #2/ Лурбан шан улг /Дам/ /1263 сүйнин нар Гайнуу /133/

12	Нята 3-р гэлтуүлэй жилийн 14-р иэрих. /1817/	III жарны хэр морин жил цэйх цагт /47/ Хасар төрсөн.	Татварын Тэмүжиний аргуулсан оруулах байжад авсан. /47/	Татварын Тэмүжин 17 настай Барийн 13 настай байжад авсан. /47/	28 насандав шаргачин тахиа жил /189/ Хэрэгжиний хөдөв арал /47/ Чингис шооп 8 хөт цагаан түг, 4 хөт хар супд.	45 насандаван гал барс жил /1206/ Онон мерний эхнээс хөхөн цагаан түг /24/ Чингис Их Монгол үлс /25/	Мина Гантуудын иймийг эрзэндэн хүрэж 66. Улаагчин богбай /22/ VIII/27- VIII/27 цагаан богбас наа /52/	Мина Гантуудын иймийг эрзэндэн эзэлсэн дарва ... хөдөв удмы дэлхийн Дээлтэр хан нээр газар /402/. Их өргөмжийэй. Чингис Барс цагаан хөт хар супд /404/
13	Нята 3-р гэлтуүлэй жилийн 14-р иэрих. /1817/	Хөх түүх /11796-1820/	Хөх түүх /11837- 1846- 1849/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур цэйх цагт /47/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.
14	Жамбодорж Болор толь /11837- 1846- 1849/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур цэйх цагт /47/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.
15	Галдан Эрдэнэйн туүх /1841/ хэвлэл	Шим хэмээх усан морин жил /1162/ /131/	Татварын Тэмүжин эзэн барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Татварын Тэмүжин эзэн барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Татварын Тэмүжин 13 наст бүхийд 9 наст Бергтэй Тэмүжин 17 настай ... ийн ногой Улаан ногой жилтэй 116 /132/	Татварын Тэмүжин хан хөвгүүн 28 сүүдэр. Хэрээн мерний хөдөв арал. 9 хөт цагаан супд. 4 хөт хар супд. Чингис хан. Хөх モンгол /133/	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.
16	Ихиннинаш Хэх судар /1871-1891/ хэвлэл	Хөх түүх /1182/ XI/1 Уур цэйх цагт /8,96/ Далтун чолдог	Татварын Тэмүжин эзэн барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Татварын Тэмүжин 9 наст Бергтэй Тэмүжин 9 настай ... төвийн хөвгүүн 28 цагаан супд. 4 хөт хар супд. Чингис хан. Хөх モンгол /133/	Татварын Тэмүжин 9 наст Бергтэй Тэмүжин 9 настай ... төвийн хөвгүүн 28 цагаан супд. 4 хөт хар супд. Чингис хан. Хөх モンгол /133/	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.
17	Ихиннинаш Хэх судар /1871-1891/ хэвлэл	Хөх түүх /1182/ XI/1 Уур цэйх цагт /8,96/ Далтун чолдог	Татварын Тэмүжин эзэн барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Татварын Тэмүжин 9 наст Бергтэй Тэмүжин 9 настай ... төвийн хөвгүүн 28 цагаан супд. 4 хөт хар супд. Чингис хан. Хөх モンгол /133/	Татварын Тэмүжин 9 наст Бергтэй Тэмүжин 9 настай ... төвийн хөвгүүн 28 цагаан супд. 4 хөт хар супд. Чингис хан. Хөх モンгол /133/	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.	Хөх түүх /1182/ XI/1 Уур барийн үчмэлүү харсар бөмв /391/ Хасар төрсөн.

Рашид-ед дин	Ингэлийн гюхрийн 549 он гэхийн жил Арлын 1155	Татварын эзэд Тэмүжин Хорхуухыг алжирхээд нэж өтгөж төрсөн. Тэмүжин 64/	Гүхрийн 562 /гахай Тэлчүүнгээ 13 настай байхад Есүхэй хан нас барсан.	Гүхрийн 602 он Лувлан барс / аргын 1206 он. Ононы эхэнд 9 хэлт цагван түг бостов. Чингис цэгтэв.	Гижрийн 624 Лакагийн Улаачин тахай ерbyn 1227 он VIII/15
18 Судрын чулган /1300-1310/ /1300-1310/	Юань улсын үеийн хувад туухийн сууринж ган му зэрчийн орчуулга Мокинф Бичурийн/ 1829			66 насандраа сууринж /хаван ширээнд /22 хол сусан.	Улаачин гахай/1227/ 7 сар Шарягин Ухэр өдөр хан халив. Нас судар 66
19					1227 VIII/18, нас мерний хөвөөнөө хуралдай хийж 9 хэлт цаглан судц мандуулав. Чингис 44 настай.
Дай Юань 20 улсын судар буюу тух	Дай Юань 20 улсын судар буюу тух	Татварын хöр эзэн, тухайлбал Тэмүжин-улыг алваад үрэхэд терхээ. Дэлгүүн бодвол 1162 гэж гарна.	1206 онд Оюун хөвөөнөө хуралдай хийж 9 хэлт цаглан судц мандуулав. Чингис 44 настай.	1206 онд Оюун хөвөөнөө хуралдай хийж 9 хэлт цаглан судц мандуулав. Чингис 44 настай.	1206 онд Оюун хөвөөнөө хуралдай хийж 9 хэлт цаглан судц мандуулав. Чингис 44 настай.
21	Доссоны монголын тух.	Зерчинтэй. Нас барсан он, насаар нь бодвол 1162 гэж гарна.	Татварын хöр эзэн, тухайлбал Тэмүжин-улыг алваад үрэхэд терхээ. Дэлгүүн бодрог. 175/		

Тайлбар: 1. "Дам" гэж буй. Энэ нь уг зохиолд шууд бичсан эүйл бус, харин өгүүлэл бичиг тийнхүү дүгнэсэн гэсэн уг. Уг зохиолд шууд хэлээгүй болговч Чингис хааныг өөд болсны дараа Гильтүүдэй баатарын хэлсэн шулэгт хан суусан Хөдөө арап гэдэг нь дам мэдээ. 2. 64/ нь уг номын 64-р тал гэсэн уг.

Есүхэй баатар хан болох нь

1. Есүхэй баатрыг нууц товчоонд хамгийн олон удаа хан гэж бичсэн нь
2. Олон сурвалжид Есүхэй баатар гэдэг.
3. Судрын чуулган, Богд баатар биеэр дайлсан тэмдэглэлд Есүхэй баатрыг хан гэсэн нь
4. Есүхэй баатрыг Чжао Хун "Аравны дарга", манай нэг сэтгүүлч дээрэмчин болгосон нь

Манай ууган гайхамшигт их хөлгөн судар болох Монголын нууц товчоонд анх 50-р зүйлд "Бардан баатрын... хүүд... Есүхэй баатар" гэж гардаг. "Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл (1266-1273 оны)" "Дээд өвгөн баатар хааны алдрыг ...Есүхэй хэмээмой" ("Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл. Асаралт, Хөхэнөндөр харгуулж тайлбарлав. Өвөр mongolyn соёлын хэвлэлийн хороо. Бээжин. 1985" номын 9-р тал) гэсэн.

"Хураангуй алтан товч", "Лу.Алтан товч", "Шар тууж", "Асралч нэртийн түүх", "Гангийн урсгал", "Монголын боржигид овгийн түүх", "Алтан хүрдэн мянган хигээст", "Мэргэн гэгээний алтан товч" зэрэг арав гаруй XVII-XIX зууны түүхэн сурвалжид бүгд "Есүхэй баатар" гэсэн байна. Ната-Алтан эрихэд Есүхэй баатар, Есүхэй эзэн (24) гэсэн. Рашипунцаг. Болор эрихэд 28-р талд Есүхэй гэсэн Монголын нууц товчооны (цаашид "нууц товчоон" гэе) 64-р зүйлд хонгирад овгийн Дэй сэцэн Есүхэй баатартай уулзаад

"Хацар гол охидыг

Хаан болсон таны

.....

Хатан суурин

Хамт суулгамуу

Өнгө сайт охидоо ёсгэж

Өндер сууринд өрөөл этгээд суулхуй" (Элдэндэй, Ардажав

"монголын нууц товчоон-сийрүүлэл тайлбар. Өвөрモンгол номын 120-р тал) гэсэн. Энэ шүлэгт Есүхэй баатард хандан "хаан болсон таны" гэсэн тул Есүхэй баатрыг хаан гэж үзжээ. Тийм ч учраас, хааны хүү хаан болох боломжтой ба Тэмүжин "нүдэндээн галт, нүүрэндээн гэрэти (гэрэлт)" (62) тул, хонгирадынхны заншилаар охиноо хан болох Тэмүжинд өгсөн бизээ. Хаалтан дахь уг нь эл өгүүлэл бичигчийн тайлбар болой. Цаашид ч ийнхүү бичнэ. Есүхэй баатрын нас нехөцсөнөөс хойш, Амбагай хааны хатан Уrbай, Сухатай хоёрыг ихэсийн тайлгын газар хэлэхгүй явахад Өэлүн үжин хойноос нь очоод, ихэсийн хишигээс хоцрооход "Есүхэй баатрыг үхвээ гэж, хөвгүүдий минь их эс болох хэмээн ихэсийн хишигээс, били үрээс, сархадаас яахин хождуулмуй та" (70§, 133-р тал) гэж хаан байсан хүний хатдын өөдөөс үг хэлнэ гэдэг, өөрөө мөн тийм зиндааны тодруулж хэлбэл Есүхэй баатар нь хан байсан гэсэн үг. ("били үр, сархад" нь тахилгын идээ ундааны үлдэгдэл) Нууц товчооны 177-р зүйлд Тэмүжин Ван хаанд элч явуулж хэлүүлсэн үгэндээ "Гүр хан авга чинь чамд морилж ирвээс чи зуун хүн амиан хорхан (хоргодон), буруудаж (zugataaj)... Есүхэй хан эцэгд минь ирвээс, чи тэнд өгүүлэрүүн, Гүр хан авгаас улсыг минь аварч өг, гэгдэн (гэж), Есүхэй хан эцэг минь... тайчуудын Гунан, Бахажи хоёрыг удирдаж..., Гүр ханыг хорь гучин хүнийг хашин зүг үлдэж, улсыг чинь аварч өгвөө зэ. Хан эцэг минь (ван хан), Есүхэй хан лугаа анд бололцож... тусын чинь ач хариулахыг тэнгэр газрын игээгэл (ивээл) мэдэтүгэй" (өмнө дурдсан номын 519-р тал) гэсэн. Энд Есүхэй баатрыг Тэмүжин "Есүхэй хан" гэсэн байна. Ван хан "хаан" тул, өөрийн зиндааны тодруулж хэлбэл, хан хүнээс тусламж гүйх ёстой. Бас Есүхэй баатартай анд бололцсон болохоор, Есүхэй баатрын "хан" гэж үзсэн хэрэг. Хэрэв Сүн улсын элч (1221 он) Чжа Хуны өгүүлснээр Есүхэй баатар "аравны дарга байсан" бол ("Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл" гэсэн өмнө дурдсан номын 103-р

тал) зуун цэрэгтэй Ван хан арваны даргаас тусламж яалаа гэж гүйх вэ дээ. Энэ бол түүхийг гажуудуулж өгүүлдэгийн нэгэн баримт байна. Богд баатар биеэр дайлсан тэмдэглэлд (өмнө дурдан номын 28-р тал) "Гүр хан чамайг... шахахуй дор арга мухардааан зуугаад хүнтэй ирж миний эцэг хааныг дагавай... Миний эцэг хаан нутаг, уг ард иргэнийг цөм... чамд өгчөхүй" гэсэн. Энд Есүхэй хаан эцэг гэжээ. Нууц товчоотой адил өгүүлжээ. 16-р талд "Ван хан урьд Есүхэй хаантай найрамдаж" гэсэн. Гүр ханы цэрэг Ван ханы цэрэгтэй нийлсэн болохоор хүчтэй, олон цэрэгтэй байсан байж таарна. Иймд тэдгээрийг дайлсан Есүхэй баатрын цэрэг ч хүчтэй бас цөөнгүй байсан болов уу. Есүхэй баатар "тайчуудын Гунан, Багажи хоёрыг удирдаж" тулалдсан тул Есүхэй баатар Хамаг монгол, тайчууд хоёрын удирдагч байсан байна. Рашид-ад-дин "Ван хан зуун хүнтэй зугадаж зайлав. Есүхэй хан түүний талд орж... түүнтэй анд бололцсон юм". Энэ явдлын талаар Хутула хан Есүхэйд хэлэхдээ "түүнтэй нөхөрлөх нь өөдгүй хэрэг" гэжээ. ("Судрын чуулган. УБ.1994" номын 81-р тал). Эхний хоёр өгүүлбэр нууц товчоотой тохирч байна. Харин сүүлчийн өгүүлбэр нь нууц товчоонд байхгүй бөгөөд үнэмших аргагүй өгүүлбэр байна. Учир нь Хутула ханыг байхад Есүхэй баатар яалаа гэж хан байх вэ дээ. Рашид-ад-дин өөр хэд хэдэн тохиолдолд "Есүхэй баатар" гэсэн. "Дай Юан улсын түүх. Үндэстний хэвлэлийн хороо.1987" номын 11,12-р талд "Ван хаан зуу илүү цэргээр дутаан Есүхэйгийн дэргэд ирэв... Аймаг иргэнийг олзлоод... өглөө. Ван хаан төдүй Есүхэйн тусламж сэтгэн ам алдаж анд бололцовой" гэсэн. Энд "Есүхэй хан", "Есүхэй баатар" гээгүй зүгээр л Есүхэй гэсэн. Санаа нь нууц товчоотой тохирч байна. Авга хан ахдаа хөөгдөж, амь зулбан зугатсан Ван ханд тусалж, улс иргэнийг нь авч өгнө гэдэг Есүхэй баатрын үнэхээрийн уужуу сайхан, өгөөмөр сэтгэлийн илрэл бөгөөд энэ нь ч хожим Тэмүжинг Ван ханаас тусламж гүйх нүүртэй болгосон билээ. "Инжиннаш.

Хөх судар. Тэргүүн дэвтэр. Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо. 1991" номын 92-р талд "Бартан баатар хан авга бүхүйгээс өмөглөн хамгаалж манай хэрэйдийг тэтгэлээ. Өнөө их баатар чи бээр өршөөлт сэтгэлийг өверлөн өнчин ядангийг тэтгэдэгийн тул өчүүхэн намайг өршөөн өмөгт цэргээн авч үхэхэд хүрсэн миний өшөөг хариулж өгөх ажаамуу" хэмээн өр өвөдтөл мөргөхүйеэ гэж байна."Буурайг тэтгэн дарагдсаныг тэнхрүүлэх нь бачим зант миний багаас явсан энгийн явдал бөлгөө" (92-р тал) "Есүхэй баатар хэрэйд улсын нийтийг дагуулан төвшиггөөд дайны олз бүхнийг цөм хе Ванд өгч..." (93-р тал) гэж байна. Гэтэл манай нэрд гарч байгаа сэтгүүлч томоохон сонинд "юун үнэн, түүх үнэн" өгүүлэлдээ Есүхэй баатрыг дээрэмчин гэж "баталсан" нь ёстай санаанд багтамгүй явдал бөгөөд найман зуу шахам жилийн өмнөх харь улсыг муулах дуртай элчээс ч хол давжээ. Нууц товчооны 96-р зүйлд "Эрт өдөр Есүхэй хан эцэг лүгээ хэрэйд иргэний ун (ван) хан анд хэмээлдсэн ажгуу" (өмнө дурдсан "нууц товчоо" номын 221-р тал) хэмээн Ван ханд очиж булган дахь бэлэглэхэд "ван хан маш баясаж өгүүлэрүүн:

Хар булган дахын хариу

Хагацсан улсыг чинь хамтатгаж өгсү

Булган дахын чинь хариу

Бутарсан улсыг чинь бүхүдгэлдэж өгсү" (дурдсан номын 221-р тал) гэдэг. ("Бүхүдгэлдэж" бүхэл болгож, бүрэн болгож гэсэн үг.) Энд "хагацсан улс", "бутарсан улс" гэдэг нь Есүхэй баатар улс (иргэнтэй) байсан гэдгийг, тэр улс нь Тэмүжиний улс (иргэн) болох ёстойг харуулж байна.

"Тоорил ханы өгүүлсэн үгийг Жамухад өгүүлж илэрүүн: "Эрт өдөр Есүхэй хан эцэгт минь тус сай хийгдсэнийг сэтгэн нөхцүү, би. Хоёр түмэн болж баруун гар болон морилсу" (105, 255-р тал) гэсэн "хан эцэгт минь" гэсэн Ван ханы үгийг "хан эцэг нь", "сай" гэснийг "сайн", "хийгдсэнийг"

гэдгийг хийснийг" гэж ойлгох нь зүйтэй байна. Лу.Алтан товчид энэ хэсгийг "Эрт өдөр Есүхэй хаан эцэг нь тус сайн хийснийг сэтгэж, би хоёр түмэн болон баруун гар болон морилсу" гэсэн. ("Лувсандаанзан. Алтан товч.УБ.1990" номын 26-р хуудасны эхний нүүр). Энд Ван хан Есүхэй баатрыг "Есүхэй хаан эцэг нь" гэжээ. Өөр газар ингэж хэлээгүй. Нууц товчооны 106-р зүйлд Жамуха хариу хэлэхдээ "Онон мөрөн өөд андын улс энд буй, андын улсаас нэг түмэн, би эндээс нэг түмэн болж болж газраа нийлэлдье" гэсэн (дурдсан номын 264-р тал) Энд бас л Есүхэй баатар улстай байсан, тэр нь одоо Тэмүжиний улс, түүгээр ч барахгүй Жамухтай адил түмэн цэрэг гарч болох боломжтой гэсэн байна. Жамухаас салж нүүх үед зуур тайчуудыг дайрахад тэд гөхийгөөд (хулчийгаад) зугатадагаас үзэхэд Тэмүжинг дагасан цэргүүд цөөнгүй байжээ. Мөн 150,151,164-р зүйлд "Хорижин хатан, Хуурчин хатан... буурч (тогооч) Шихихурийг ашигжкухуй (зодчихуй)... Шихихүр өгүүлэрүүн: "Есүхэй баатар, Нэхүн тайж хоёрыг үхэхүйн (үхсэний) тул ийн ашигдахуй" (дурдсан номын 353-р тал) гэснээс үзэхэд бас л Есүхэй баатар хаан, Нэхүн тайж нь тайш (хааны дараах албан тушаал, их цэргийн жанжин, одоогийн ерөнхий сайд) байсан гэсэн санаа байна. Т.Дашцэдэн, Широтари Куракичи нар "тайж"ийг латинаар "taisi" гэж галигласан. Нэхүн нь тайши байсан ч учраас Тэмүжин түүний хүү Хучирыг хан бол гэж байсан биз (177§) Өзлүн үжин гээгдэж хоцроод "түглаж биеэр морилж зарим... иргэнийг ицаав (няцаав)" (73§,142-р тал) гэснээс үзэхэд Есүхэй баатар нь Хамаг монгол, тайчууд хоёрын эзэн байсан бөгөөд, тэрхүү эзний баталгаа туг барьж явжээ. Тийм ч учраас зарим иргэн нь ойлгож буцжээ. "Энэ нь хэдийвээр овгийн хаан нас барсан боловч хаан эзний сүр хийморь болох туг сүлд байх тул Өзлүн үжин энэхүү туг сүлдийг барьж олон ард иргэдийг бишрүүлэн хураан ирэх бээр оролдсон хэрэг билээ". (Л.Хурцбаатар. Ч.Үзэм. "Монголын бөө мөргөлийн

тайлга, тахилгын соёл. Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо.1991” номын 38-р нүүр). Гэвч харамсалтай нь тогтсонгүй ээ. Аргагүй биз ээ.

Тайчуудын Таргудай Хирилтүг тэргүүтэн Есүхэй баатрын бэлбэсэн хоёр гэргий, хүүхдүүдийг гээж нүүхэд Чирха өвгөн одож ятгаад жадлуулж ирээд “гэртээ бэрх хэвтэж байхад” нь Тэмүжинийг ирэхэд “сайн эцгийн чинь хураагдсан (хураасан) улсыг маань бүрэн авч” (73§, 142-р тал) нүүхэд гэсэн. “Рашид-ад-дин. Часть II. Сборникъ Лътописей. Исторія монголовъ. Исторія Чингизъ-Хана” СПб.1868 номын 53-р талаас мөхөс би орчуулбал: “есүхэй баатар олон монгол овог (аймаг)-ийн удирдагч байсан. Түүний төрөл төрөгсөд нь түүнд дуулгавартайяа даган захирагдаж байсан бөгөөд өөрсдийн дотроос түүнийг нэгэн дуугаар хаан ширээнд суулгасан”. Энд дурдсан төрөл төрөгсдийн тоонд тайчууд орохгүй. “Дай Юан улсын түүх.Үндэстэний хэвлэлийн хороо.1987” номын 11-р талд “Есүхэй олон аймагуудыг дайлаж эрхдээн оруулаад аугаа хүчин нь ямагт нэмэв” гэсэн. Иймд Есүхэй баатар бол үнэн хэрэг дээрээ хамаг монгол, тайчууд хоёрын их хуралдайгаар өргөмжлөгдөгүй хан (хаан) байжээ. Одоогийнхор хэлбэл “ханы үүрэг гүйцэтгэгч” байжээ. Хадаан тайшаас хойш, Хотула хааны дэргэд тайш болж байсан бололтой. Хотула хаан, Хадаан тайш хоёр Амбагай хааны өшөө авахаар Алтан хааны (зөрчидийн) цэрэгтэй байлдаж бут цохиж олон цэрэг олзлож, хэмжээлшгүй олз олж байсан байна. (Өмнө дурдсан Рашид-ад-дины “Судрын чуулган” Часть- II) Гэвч татаруудтай 13 удаа байлдаж “өсөл өсөн хясал хясан ядав” гэсэн. (58).Гэтэл Есүхэй баатар л татартай байлдаж “татарын Тэмүжин- Үгэ, Хорь бух тэргүүтэн татаруудыг” (нууц товчоо, 60) олзлон ирсэнийг бодоход Есүхэй баатар олон цэрэгтэй, тодруулж хэлбэл Хамаг монгол, тайчууд хоёрын бүх цэргийг мэдэж байжээ. Татаруудыг бут цохиж Тэмүжин-Үгэ нарыг олзлон ирсэн тухай монголын арав гаруй түүхэн сурвалж, Судрын чуулган, Дай Юан улсын түүх зэрэгт

үндсэндээ адил бичсэн байна. Есүхэй баатар Хотула ханыг нас нөхөцсний дараа Хамаг монгол, тайчууд хоёрын удирдагч байжээ. “Есүхэй баатар нь... “арван гурван насан дагаан өвч хуягт хүнийг шувт харван унасан морийг нь авч унаж дутаан явдаг”... нэгэн эрэлхэг дайчин хүн болохоор барах үгүй мөн ч төв голч, арга бодлоготой бөгөөд бусадтай бүлгэмдэж чаддаг хүн тул маш олон төрөл аймаг бүлэг нь ирж түүнд харьялагдасн ба цөөхөн бус [гэрийн хүмүүстэй] болжээ” (Ши Вей: “Чингис хаан. Сиянганы хэвлэл, 4 нүүр”), (“Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр. Хоёр дахь хэвлэл. Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо. 1991” номын 13-14-р тал). Есүхэй баатар нь анхын гэргий Өэлүн үжинийг Мэргэдийн их Чилэдү гэргий болгон авч явахад нь өнгийж хараад л анхны харцаар дурлаж гэргийгээ болгохоор шийдсэн “Ромео” байжээ. Нөхрийг нь алахаар завдан хөөсөн боловч цаадах нь зугатаж амжсан. Өүлэн үжин Чилэдүд үлэмж хайртай байсан нь “үнэрийг минь үнэсч яв” гэж цамцаа өгч, хэрэв өөр нэртэй гэргий авбал “Өэлүн гэж” нэрлэ гээд Чилэдүгийн хойноос их дуугаар эхэр татан үйлснаас тодорхой байна. (56).Гэвч Өэлүн Үжин Есүхэй баатард дасаж 5 хүүхдийн нь эх болжээ. Хоёр хоёр насны зөрөөтэй хүүхдүүдтэйг бодоход хоорондоо их дотно байсных биз. Есүхэй баатар хэдийгээр булааж авсан ч гэсэн жинхэнэ хань нь болж чадсан Өэлүн үжиний марташгүй хань нь байжээ.

Тэмүжин Хамаг монгол аймаг ба Их монгол улсын хан болсон нь

1. Тэмүжин усан барс жил (1182 онд) Хамаг Монголын хан болсон нь
2. Хамаг монголын хан болсныг Монголын нууц товчоо
3. Их Монгол улсын хан болсон нь
4. Монголын нууц товчоо нь монгол төрийн түүх болох нь

Тэмүжин элдэв хэмээх (жарны нэр) усан морин жилийн (аргын тооллын 1162 он) зуны тэргүүн сарын улаан тэргэл өдөр (билгийн тооллын IV/16) дөл цагт (морин цаг; 11цаг-13 цаг буюу 11 цаг 40 минутаас 13 цаг 40 минутын хооронд) гартаа хар нөхжатган төржээ. (Аргын тооллын 1162 оны V/31 гэдэг). Мэргэн гэгээн Лувсандамбийжалсан “Алтан товчдоо” (49-р тал). Жамбадорж. Болор тольдоо (391-р тал) Хасарыг үлэмж магтсан байдаг ба Чингис хааны зарим гавьяаг Хасарын болгож өгүүлдэг тул “Хасарыг хар нөхж (буюу бөөм) атган” төрсөн гэсэн. Үүгээр үзвэл “Хар нөхж” нь эр зориг, баатарлаг явдлын бэлэг (бэлгэ) тэмдэг бололтой. Инжиннаш гуай Тэмүжинг бүр хоёр гартаан нөхж атган төрсөн (Хөх судрын 98-р тал) гэж эр зоригийн бэлэг (тэмдэг) гэсэн санаагаар өгүүлсэн. Гэтэл харин нууц товчоонд өгүүлснээр бол Өзслүүн (Өзлэн) эх харгис хатуугийн тэмдэг гэж үзсэн. Нууц товчооны 78-р зүйлд Тэмүжин, Хасар хоёрыг Бэгтэрийг харваж алаад ирэхэд “барагсад... гартаан хар нүдүн (нөхж) атган төрлөө энэ” гэдэг нь Тэмүжинг хэлсэн хэрэг. (Элдэндэйн өмнө дурдсан номын 166-р тал) Тэмүжинг хан болохыг анх урианхай Жаржуудай зөгнөн мэдсэн ажээ. Нууц товчооны 97-р зүйлд (97§) “Ононы Дэлүүн болдогт бүхий дор Тэмүжиний төрөхүй дор булган нэлхэ (өлгий) өглөө би. Энэ хүүгээн Зэлмийг өглөө, би” гэдэг (Элдэндэй, Ардажав сийрүүлэл тайлбар. 1986” номын 226-р тал) Энэ нь нэг талаас Есүхэй баатар хан буюу тийм зиндаанд байсан гэсэн үг. Нөгөө талаас, нялх хүүхэд хараад хүүгээ өгнө гэдэг бол, Тэмүжинг хан болно гэж урьдаас мэргэн зөгнөж, гүнээ итгэж агуу сэтгэл гаргасан хэрэг. Хонгирадын Дэй сэцэн Есүхэй баатар, Тэмүжин хоёртой уулзаад, хонгирадынхан хаан хүнд охиноо өгдөг зуршилтай гээд, Тэмүжинг “нүдэндээн галт, нүүрэндээ гэрт хөвгүүн” (өмнө дурдасан номын 115-116-р тал) иш татсан хэсэг нь одоогийнхоор “нүдэндээн галтай, нүүрэндээ гэрэлтэй” (“нүүрэндээ галтай, нүдэндээн цогтой” гэсэн үг гэдэг нь

ойлгомжтой) гэж дуу алддаг төдийгүй охиноо өгдөг билээ. Энэ нь бас Есүхэй баатрыг хан гэж үзээд Тэмүжинг хан болно гэж үзсэн хэрэг. Есүхэй баатар Тэмүжинг хан болгохыг гэрээслэсэн байна... Лу. Алтан товчийн (1990 оны Улаанбаатарын хэвлэл) 15-р хуудасны хоёр дахь нүүрт Тэмүжинг эцгийгээ нас барсаныг дуулаад маш гаслахад Чирха өвгөн сэргээн

“Тул загас мэт яахин гасламуй, чи

Туурга (торгон) цэргээн бэхлээ гэж эс хэмээлдсэн биш үү

Лагар загас мэт яахин лай барин гасламуй, чи

Нармай улсаан байгуулья гэж, эс хэмээлдсэн биш үү?” гэснээс тодорхой байна. Өзслүүн эх, Тэмүжин, Хасар хоёрыг Бэгтэрийг харваж алаад орж ирэхэд “эх хоёр хүүхдийн царайг ухаж, өгүүлэрүүн барагсад” гэдэг. Өзслүүн эх хоёр хүүхдээсээ юу ч асуулгүйгээр л тэдний юу хийснийг ухаарсан гэсэн үг. Одоо 78§-ийн уг шүлгийг сийрүүлье (ганц нэг үг ялимгүй өөрчлөн хойно тайлбарлав)

“Барагсад

Халуунаас минь халаж гараруун

Гартаан хар нөхж атган төрлөө, энэ

Харвисаан хазах хасар нохой мэт

Хаданд довтлох хавлан мэт

Уураан даран ядах арслан мэт

Амьд залгису гэх мангас мэт

Сүүдэртэн довтлох шонхор мэт

Сэмээр залгих цурхай мэт

Ботгоныхоо борви хазах буур мэт

Бороонд шахах чоно мэт

Хүүхдээ гэлийн ядаж идэх ангир мэт

Хэвтшээн хэндвөөс өмөөрөх (дайрах) цөөвөр мэт
Барьж үл саарах барс мэт
Балмад довтлох бараг мэт барваа,
Сүүдрээс бус нөхөргүй
Сүүлнээс бус чичээгүй" гэсэн байдаг.(Өмнө дурдсан
сийрүүлэл, тайлбар номын 166-167-р тал)

Энд "халуун" гэдэг нь "эхийн умай" гэдэг нь ойлгомжтой. Уг эхэд "халад" гэж байсныг "халаж" болгов. "Халах" нь солих гэсэн утгатай "Хааны алба халаатай, эзний алба ээлжтэй гэдэг". Нөгөө талаар "хал үзэж, халуун чулуу долоох, хашир суух", "хайр нь дотроо, хал нь гаднаа" гэдгээс үзэхэд "хатуу, ширүүн" гэсэн утгатай байна. Бөхчүүд барьцаа хүчээр солихыг "барьцаа халах" гэдэг. Үүгээр үзвэл "халуунаас халад гараруун" гэдгийг "умайгаас өвтгөж гарлаа" гэж ухаарч болно гэсэн утгатай үг байна. Иймд хар неж атган төрснийг Өэлүн эх хатуу ширүүн, хэрцгийн тэмдэг (бэлгэ) гэж ойлгожээ. "Нүдэн" гэдгийг "нэж" гэв. Аливаа гөрөөс малын хэвллийн дотоод зулзагыг агуулсаныг нь харбис (харвис) хэмээмой. "Хорин нэгтийн тайлбар толь. Өвермонголын Ардын хэвлэлийн хороо.1979" номын 337-р тал. Хаблан-царлан түрэг хэлний kanlan хэмээх нь барс, ирвис хэмээх. (дурдсан номын 169-р тал дахь зохиогчдын тайлбар) Бороон- богоол нь түрэг хэлэнд... шуургыг хэлдэг байна (170-р тал) Гэлих-залах, туух. Аливаа мал адгуусныг авч хөөн явахыг гэлимой хамээмой. ("Хорин наймтын толь. Өвермонголын Ардын хэвлэлийн хороо 1994" номын 1106-р тал) Баруг-рагид-ийг түрэг хэлний барак хэмээх нь нэг зүйлийн бужигир үстэй нохойг (дурдсан номын 172-р тал) хэлдэг байна. Тэмужиний хэрцгийг "хавлан", "арслан", "мангас", "шонхортой" зүйрлэсэн. Гэтэл энд "Харвисаан (харбис баан) хазах хасар нохой мэт" зүйрлэлд үр зулзагаа тээсэн тэр хэсгээ хазаж байгаа нохойтой, "ботгоо хазах бууртай (эцэг), хүүхдээ гэлийн (залж

туун) ядаж идэх ангиртай зүйрлэдэг нь юуны учир бэ? Яагаад эцэгтэй зүйрлэсэн бэ? Адилхан нэг эцгийн хүүхдүүд шүү дээ. Тэмүжин бол эцгийн оронд "эцэг болох" нэг айлын гал голомтын эзэн төдий биш гэдэг санаа байна. Тэмүжин дүүгээ "бялжиур" (болжмор), "сагусун"ы (soqosun хэмээх нь загас; дурдсан номын 157-р тал; зохиогчдын тайлбар) булаасны төлөө алсан юм гэж үү. Арай ч угүй баймаар. Тэмүжин бол зугээр нэг ахмад хөвгүүн өөрийн гэрийн эзэн төдийгүй эцгийн байр суурийг жинхэнэ утгаар залгамжлагч, тодруулж хэлбэл, хан болох ёстой хан хүү (хун тайж) байсанд хэргийн учир оршино. Тэмужиний хамгийн эрхэм, ариун нандин хан болох хүслийн нь сөрен эсэргүүцжээ. Тайчууд нүүгээд явах нэг хэрэг. Гэтэл өөр эхээс төрсөн, эцэг нэгт дүү нь эцгийн гэрээс зөрчиж, дуулгаваргүй, бүр булааж байгаа явдал бол хан хүний өөдөөс эсэргүүцсэнтэй адил болжээ. Тийм учраас Тэмүжин шийтгэх эрхтэй ажээ. Ийм ч учраас Бэгтэр өөрөө "завилан сууж хүлцэв" (77§) гэжээ. Тийнхүү алж шийтгэх нь тэр гурвын хувьд ойлголцсон, ердийн явдал болжээ. Тэмүжин гал голомтоон бүү бүрэлгэдгүн дүү Бэлгүдэйг бүү тэвчидгүн (орхигтун) гэж гүйсан. Энэ гуйлтыг ёсоор болгож, хожим Бэлгүдэйг өмөөрч зодолдож (132§) бас татаруудыг хэрхэх тухай их зэээр (зөвлөлөөр) шийдсэн нууцыг задруулж олон хүний амь нас алдуулан (152§) үлэмж их хохирол учруулсан атал донгодож их зэд оролцох эрхийг нь хасаад л өнгөрчээ. Энд би Тэмужинг дүүгээ алсныг зөвтгөх буюу зөөлрүүлэх гээгүй. Жинхэнэ учир шалтгааныг нь л олох гэж ядаж байгаа минь энэ билээ.

"Сүүдрээс өөр нөхөргүй

Сүүлнээс өөр чичээгүй" хэллэгийн талаар хоёр үг өгүүлье. Хан хүнд албат, харц хичнээн хэрэгтэй атал, тийм албатгүй болсон байтал эцгээс заясан дүүгээ ална гэдэг, тэр хан болох хүсэлдээ өөрөө садаа болж тун ч тусгүй хэрэг хийснийг нь ухааруулах гэсэн үг мэт. Чухам л

"сүүдрээс өөр нехөргүй" гэдэг үгнээс л сэргийн сая ямар тусгуй хэрэг хийснээ ухаарч гэмшсэн болов уу. "Чичээ" нь чичдэг, хатгадаг юм гэсэн угтатай ажээ. Тийм ч учраас хятад хадмал орчуулганд "ташуур" гэсэн нь аргагүй оносон үг болов уу? Гэтэл Өэлүн эх энд чухам тийм "чичээ (ташуур)" болох эцэг байхгүй тул зоргондоо болсныг өөрөө тийм "ташуур" болж чадахгүй байгаагаа хэлсэн нь сэтгэл зүйн довтолгоо юм. Ташуур буюу хэлдэг, зөвлөдөг хүнтэй болох ёстой гэсэн санаа байна. Тийм ч учраас Тэмүжин Хамаг монголын хан болоод, Боорчи, Зэлмэ хоёрт "Та хоёр намайг сүүдрээс бус нехөр үгүйд сүүдэр болж, сэтгэлийг минь амуулбаа (амраав) за, та. Сэтгэл дор атугай (байтугай)" гэв. "Сүүлнээс өөр чичээ (ташуур) үгүй дор сүүл болж, зүрхийг минь амуулваа за, та. Чээж дотор минь атугай гэв" (125§)./өмнө дурдсан номын 341-р тал гэсэн./ Үнэхээр Боорч бол зөвийг нь дэмжигч буруугийн нь болиулагч мартсаныг нь сануулагч, унтысаныг нь сэргүүлэгч их зөвлөгч болсон билээ. Ийнхүү Өэлүн эх өвгөдийн үгийг үндэс болгож, мэргэдийн үгийг иш болгож хүмүүжүүлсний ачаар хожмын хойно хамгийн хан, улсын эзэн болсон чөр хүний зөв үгийг авч буруу үгийг гээж, зөв мэргэн шийдвэр гаргадэг хан болжээ. Эцгээсээ балчирхан 9 настай хоцорсон хүнд хэцүү цагт нь харж хандан, хамжин тэтгэхийн оронд хан эцгийн нь ах, дүү анд нехөд, албат ард нь аргагүй л хүчтэнийг бараадан, хөөрхий өнчин хэдэн хүүхэдтэй бэлбэсэн хоёр хатныг үл тоомсорлон хар бууцан дээр хаяж гээн одоход эцгий нь эрхэм анд Чирх өвгөн тэднийг буцаах санаатай очиж учирлан ятгахад "цээлийн ус тасарч цэгээн чулуу цуураад" байхад чи яласан юм ухаарч нүдээ нээдэггүй хүн бэ? Хэмээн загнаж, зоо нуруунийн нь хүртэл жадлан буцаасныг үзэж уярал, харууслын нулимсаа унагаж явсан. Зоригт Өэлүн эхийн харсаар сууж хамаг албатаа алдахгүйг хичээн тут барьж тунхаг зарлаж тоотой хэдийг эргүүлж ирэхийг үзэж эрхгүй эр зоригийн

шандас нь чангарч л байсан бизээ. Гэвч буцааж авчирсан хэд ч буцан одож, адаг сүүлд Мэнлэг эцэг ч хаян нүүж хар бууцан дээр ганц гэр хоцорч хорвоогийн амьдралын эрээн барааны цаана эрх биш учир ёс байдгийг ухаант эхийн мэргэн сургаалаас, угийн сэргэлэн ухаанаар ухан мэдэж, ухааран ойлгож авсан биз. "Биеийг нь хураахаар сэтгэлийг нь хураагтун. Сэтгэлийг нь хурааваас бие нь хаашаа одох", "Бие бөх бөгөөс ганцыг ялах. Сэтгэл бөх бөгөөс олныг ялах" (Алтан товч) гэдгийг ойлгон мэдэж авсан байх. Өэлүн эхийн амьдралын өөдрөг сайхан бодолтой, сөхөрч нугаршгүй чин зоригтой, өнөө маргаашийг өнгөрөөх амьдралын аар саар зүйлийг ч амжуулж, өвөг дээдсийнхээ нандин сургаалаар алсыг харж, амьдралыг зохицуулж, зорьсон зорилготой, чиглэсэн чигтэй, хандсан хандлагатай, хатуужсан бодлоготой, харцтай ч нехөрлөж чадах, хаантай ч харьцаж чадах, хамгийг ч захирч чадах хааны бууртай, хамаг олныг бие дээн татах арга, билгийн ухааныг ёстой хайраа дотроо, халаа гаднаа байлгаж хүмүүжүүлсэн болов уу.

Элбэг баян, эрх тансаг амьдарч байсан тэдний амьдрал дордож, аргагүй байдалд хүрэхэд ухаант Өэлүн эх зүгээр уйтгарлаж, уруу царайлж суулгүй, харин ч "бүс бүсэлж", "богто гоо чанга уян" гадаа гарч эр болж, гэрт орж эм болж, халиар мангиар ч түүж, үндэс ч ухаж амьдралын төлөө өөрөө дайчин, цогтой тэмцэгч байж, үүгээрээ үлгэрлэн үр хүүхдээ зовлон бэрхшээл дааж, сөрч чадах сэтгэлийн тэнхээтэй, итгэлийн одтой болгон хүмүүжүүлжээ. Тэд загас ч барьж, зурам ч алж идэж байжээ. Энэ нь тэд зөвхөн идэх хоолгүйдээ тийнхүү байсан төдий биш өрөөсөө амьдралын төлөө тэмцэгч байлгах гэсэн эхийн хүмүүжлийн үр нөлөө юм. Тэмүжин Боорчтой анх уулзан нехөрлөөд нум сумаа над ац (өг) гэхэд чи миний өмнөөс эрсдүүзэй гээд өгөлгүй өөрөө эргэн харваж эхний хүнийг шархдуулдаг. Дараа нь буцаж ирээд би чамгүйгээр 8 агтаа авч чадахгүй

байсан. Чи хэдийг авах вэ? гэж асуун байгаагаас үзэхэд нөхрийг үлэмж хүндэтгэж өөртөө татаж байгаагийн илрэл болно. Энд ямар ч ихэмсэг бардан зангиин ул мөр алга байна. Тэмүжиний цаашдын өөдлөн дэгжихэд бусдын тусламж зайлшгүй хэрэгтэй байсан ба чухам тусалж чадах хүнээ бол Ван гэж зөв сонгож, өөртөө татсан явдал нь яах аргагүй Өэлүн эх, дүү нар, гэргий Бөрт үжиний санал зөвлөгөөг авсных болов уу. Есүхэй баатар нь Ван ханын Гүр ханд ялагдан зуугаад цэрэгтэй үлдэж ядарч явахад нь өгөөмөр сэтгэл гарган өөрийн биеэр цэргээ удирдан Гүр ханыг хөөн явуулж хаан эрх, хатад хуухэд орд гэр, албат ардыг нь буцаан өгдөг. Энэ сайхан өгөөмөр сэтгэл, гүн тусламжийн хариуд уярсан Ван хан Есүхэй баатартай анд болсны хожим Тэмүжинг Ван хаанаас тусламж гүйх нүүртэй болгожээ. Энэ бол эцэг Есүхэй баатраас Ван ханд оруулсан агуу их далд “хөрөнгө оруулалт” ажээ. Тэр үеийн ёсоор “анд хүний амь нэг, үл тэвчилдэн амины арич (хамгаалагч) болно.” (117§) гэдэг. Тодруулж хэлбэл, нэг нь нөгөөгийнхөө төлөө амь биеэ үл хайрлан тэмцэж, хоёр биенээ тэтгэн нөхөрлөж, тусалж явах ёстой ажээ. Тэр цагийн сайхан ёс эдүгээ хүртэл уламжлан ирснийг өгүүлье. Миний төрсөн Архангтай аймгийн Хан-оюут суманд (odoogийн Эрдэнэмандал сумын Оюут баг) “тал болох” гэж сонин ёс байдаг. Энэ нь яс маҳны барилдлага холбоогүй хоёр хүн харилцан бие биеэн хүндэтгэж үерхэн нөхөрлөхийн дээд нь болох ёс байна. Хоёр хүн тал болно гэдэг нь нийлээд нэг хүн мэт байна гэсэн үг ажээ. Ийм учраас бие биенийгээ “тал” гэдэг. Гэхдээ ахмадыгаа тал ах, дүүгээ тал дүү гэдэг. Найр хийх ёслол үйлдэн албан ёсны болгодог байна. Найр хийж, ерөөл тавиулж бэлэг солилцдог байна. “Тал эвдэрвэл тамын ёроолд, сал эвдэрвэл далайн ёроолд” гэж тал болсноо ихэд эрхэмлэдэг билээ. Чухам ийм учраас Тэмүжин Ван ханд “эрт өдөр эцэг лүгээ минь анд хэмээлдсэн ажгуу. Эцэг, хүү мэт буй заа” хэмээн өгүүлж эцэг мэт хүндэтгэж байгаагийн

илрэл болгож хадам эхийнхээ бэлэглэсэн булган дах бэлэглэхэд Ван хан маш баясч, Тэмүжиний хүслэн болсон сайхан уг:

“Хар булган дахын чинь хариу
Хагацсан улсыг чинь хамтадгаж өгсү
Булган дахын чинь хариу

Бутарсан улсыг чинь бүгүдгэлдүж өгсү” гэдэг билээ(96§, 21-р тал.) Ер нь одоо ч гэсэн эцгийн анд нөхрийг эцэг мэт хэмээн хүндэтгэдэг ёсыг баримталдаг хүмүүс байдаг.

Тэмүжин Бөрт үжинээ гурван мэргэдэд булаагдаад Ван ханд очиж “гурван мэргэд гэнэн бүхийд ирж эм хүүвээн даулиж (булаагдан) автав. Хан эцэг минь эм, хүү аварч өгтүгэй хэмээн ирэв, би” (104§, 251-р тал) гэдэг. Энд тэмдэглэхэд “эм, хүүгэн...автав” гэсэн тул Бөрт үжин баригдах үедээ жирэмсэн байсан байна. Рашид-ад-дин судрын чуулгандаа “Мэргэд овогийнхон зохистой тохиолдол ашиглан Чингис ханы орон гэрийг дээрэмдэн жирэмсэн эхнэрийг нь авч явсан.” (Рашид-ад-дин. Сборник летописей том.II.М. 1960.65-р тал) гэсэн. “Ван хан Жамуха дүүд, би эндээс хоёр түмэн морилсу, баруун гар болж, Жамуха дүү хоёр түмэн болж зүүн гар боллон морилтугай” гэдэг (104§, 251-р тал). Эндээс харбал мэргэдүүд их хүчтэй байжээ. Рашид-ад-дин мэргэдүүдийг их хүчтэй байсныг бас тэмдэглэсэн. Нууц товчооны өгүүллээр мэргэдээс Тогтоо бэх тэргүүтэй удуйд мэргэд хэдий ялагдсан ч их үг хэлж баруун тийш зугатаж Чингис хаанд ихэд чирэгдэл болсон билээ. Жамуха, Тэмүжин хоёр хоёр удаа анд болсон байсан тул Жамуха Тэмүжинд туслах ёстой ажээ. “Буур хээрийн тулалдаан” гэдэг эл тулалдаанд Тэмүжин зохион байгуулалтын их үүрэг гүйцэтгэн, эцгийн албатаас цэрэг үүсгэсэн төдийгүй Увас мэргэдийг бие даан довтолсон бололтой.” Тэмүжин дүрвэж айсуухун иргэн дунд “Бөрт, Бөрт” гэж дуудан явахад Бөрт үжин, Хуагчин жирийн (хоёр)

Тэмүжиний жолоо цулбуураас шене таньж барижухуй... Үзвээс, Бөрт үжинийг таньж тэврэлдэн тосолцлов" гэдэг. (110§, 273-р тал). Сэтгэл уярам уулзалт болжээ. Тэгээд Ван хан, Жамуха хоёрт "эрих хэргээн оллоо" шене бүү делье. Энд бууя бид" (110§, 274-р тал) гэдэг. Энэ бол мэргэдийг бут цохиж олз олж, ешөө авах нь гол нь бус гэдгийг харуулсан өгөөмөр сайхан сэтгэл, уужуу ухаан, хайр сэтгэлийн илрэл юм. Мэргэдийг хүйс тэмтрэх бүрэн боломж байсан ч Тэмүжиний санаалаар төдийлэн ашигласангүйээ. Энд Бөрт үжин Тэмүжинтэй тэврэлдэн уулзаж байхад, харин Бэлгүдэйн эх "хөвгүүд минь хад(хаад) болчихов хэмээгдэв. Би энд муу хүнтэй төвэж (нийлж), эдүгээ хөвгүүдийн нүүр хэр үзэх үй, би" гээд гүйж шугуйд шургаж эс олдсон нь сонин. (112§, 283-284-р тал). Ван хан, Жамуха хоёрыг Тэмүжин бишрэн өгүүлрүүн: хан эцэг минь, Жамуха анд хоёроо нөхцөгдэж (хоёртой нөхцөж(нийлж)) тэнгэр газраа хүч нэмэгдэн,

"Эрхэт тэнгэрт нэрийдэн

Эх этүгэнээ хүргэж" (113§, 286-р тал) гэж байна."Тэнгэр газраа хүч нэмэгдэж" гэдэг нь бөө мөргөлийн үүднээс тэнгэр харж үзэж ивээн тэтгэлээ гэсэн үг. "Эрхэт тэнгэрт нэрийдэж" нь эрх мэдэлт тэнгэрээс намайг нэр заан тэтгэж энэ тэтгэх учраа эх этүгэнээ (дэлхийд) хүргэлээ гэж өмнөх санааг бүр лавшуулан хэлсэн нь сонирхолтой. Нэг ёсондоо хан болох замынхаа эх тавьчихлаа гэсэн санаа болов уу. Жамухтай гурав дахь удаагаа анд бололцон амраглалдан нэг жил хагас болоод нүүхэд Тэмүжинд Жамуха "Тэмүжин андаа уул шахан бууя, адуучин, бидний алацууга хүртээе. Голд шахан бууя. Хоньчид хургачид, бидний хоолоо хүртээе гэв" (118§, 307-р тал) Чингис хаан энэ үгийн цаад утгыг үл ойлгон, эхээсээ асууя гэж сэм хоцорч асуухад, олны санаа бодол, явдал мөр, ер хүнийг сайн таньдаг гархай, ухаалаг Бөрт үжин чухам л энэ үгийг хүлээж байсан бололтой, хэлж байгаа угэндээ аргагүй итгэсэн учраас хадам эхийн

урдуур орж "Жамух анд уйданга хэмээгдэн бөлгөө. Эдүгээ биднээс уйдах цаг болов..." (118§) гэж хэлсэн үгийг зөвшөөрч үл буун шене дөл нүүдэллэн явдаг. Жамухын хэлсэний гол санаа одоо хоёр тийшээ салж нүүе гэсэн санаа нь ойлгомжтой баймаар юм. Гэвч Тэмүжиний санаанд Жамух салж нүүүнэ гэсэн бодол даанч ороогүй, үнэхээр андалдаж, амралдан тойлон жаргаж (117§, 303-р тал), үл умартах үгс өгүүлэлдэж байсан (201§) учир ийм үг сонсоно гэж үгт бодоогүх болов уу. Нөгөө талаар, тэр үед язгууртангууд бусдад үл ойлгогдох ётг үгээр ярилцдаг байсан тул далд утгатай байх хэмээн санасан бизээ. Тэрхүү жил хагасын дотор хамаг монголын хан хэн болох вэ? гэдгийг дээр дооргүй ярилцаж байсан биз. Гэтэл олны санаа бодол Тэмүжин рүү хандаж, Тэмүжинг хан бөх бодолтойг ойлгосон, энэ талаар тууштай байгааг мэдээд салж нүүе гэсэн боловуу даа. Шөн дөл явсаар үүр гийхэд үзвэл "Хачаун- Тохураун, Хархай- Тохураун, Харалдай- Тохураун ах дүү гурвуул, Хадаан Далдурхан ах дүү тавуул..., Мэнгэт Хианы Өнгүр нар... баруласаас Хувилай, Худус ах нар дүү нар, ... Зэтэй, Доголху чэрби ах дүү хоёр, Үгэлэн 7эрби (Боорчийн дүү), ... Зэлмийн дүү Чаурхан, Сүбээдэй баатар, ... Дэгэй Хүчүгүр,... Архай Хасар, Бал, Сүйхээт чэрби, Сүхэхэй нар ирэв. Бас Хорчи усун өвгөн, Хөхөцөс мэнэн бааринаа дагуулан нэгэн хүрээ ирэв. Ер нь 28 овгийн, 8 хүрээ хүмүүн уван цуван ирцгээдэг" (Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр) Хорчи ирж "Буданцар богдын барьж авсан эмээс төрсөн Жамухтай хээл нэгтэй, хэгээ (хүүхдийг бүрхсэн хальс) гагцтай бөлгөө." (319 тал 121§) Аливаа малын төлийн гарахаас урьд дотроон устай нимгэн хальс гарахыг хэгэй хэмээмой. ("Хорин наймтын тайлбар толь. Өвер mongolын Ардын хэвлэлийн хороо 1994" номын 880-р тал) Заарин (зайран) ирж надур (надад) нүдэнд ийн үзүүлвээ. Хуагчин ухаа /үнээ/ ирж Жамухыг орчиж (тойрон эргэлдэн) явж гэр тэргэнийг (бариатай гэр ачсан

тэргийг) нь мөргөлөөд Жамухыг мөргөж өрөөл эврээ хугалж солжир эвэрт болж эвэр минь ац хэмээн Жамухын зүг мөөрөн шороо сацан сацан байму. Мухулар хуа (ухаа) үхэр их гэрлүгээ дээр өргөж хүлж жигдүж (зүтгэж) Тэмүжиний хойноос их тэргэгүр (тэргүүр - тэргэний замаар) мөөрөн мөөрөн айсурун тэнгэр газар эдэлдэж Тэмүжинийг улсын эзэн болтугай хэмээн улс тээж авч айсу хэмээн заарид (олон зайран) нүдэн дор үзүүлж надур заамой" (121§, 319-р тал). "Заарин" үгийн хятад хадмал орчуулгад "бурханы хэлмэрч" гэж орчуулжээ. "Монголын нууц товчоо. орчуулга тайлбар.УБ.2000" номын 241-р тал, "бурхан" нь тэр үеийнхээр тэнгэр. Иймд Заарин нь бөө мөргөлийн үүднээс "тэнгэрийн элч" ажээ. Хуагчин (ухаагчин) үнээ энд үнээний хүйс зохицуулан ухаа өнгийг ухаагчин гэжээ. Хуа (ухаа) үхэр нь эр үхэр. Үнэхээр бодит байдалд ухаа үнээ Жамухыг тойрон эргэлдэн гэр тэргийг нь мөргөөд өрөөсөн эврэ хугалсан байж болно. Тэгээд бас Жамухыг мөргөсөн байж болно. Харин энд Жамухыг мөргөөд эврээ хугалсан гэдгийг үнэмшихэд бэрх юм. Ухаа үнээ, ухаа үхэр хоёр нь "тэнгэрийн элч" болно. "Тэнгэрийн элчийн үйлдлийг хорчи (бөө) тайлан байна." "Мөргөж байгаа нь Жамухыг буруутгаж байгаа хэрэг. Өрөөсөн эвэртэй болно гэдэг нь Жамухыг Тэмүжинээс салсныг буруутгаж "эврийг минь ац (аг)" гэдэг нь хоёулаа нийл, салж болохгүй гэсэн санаа. Дараа нь их тэргэнд хөллөсөн ухаа эр үхэр гэр тэргийг дээр өргөж (үнэндээ ганц бус олон үхэр хөллөдөг тул үхэр дээр өргөх боломжгүй юм, гэхдээ ганцаар тэргэнд сийртоод өргөх гэсэн байж болох) гэвч энэ онцгой заарин заасан үхэр тул өвөрмөц хүчтэй байх, мөөрөн мөөрөн Тэмүжиний хойноос явж байгаа нь Тэмүжин эзэн юм" гэсэн санаа. Тэнгэрийн элчисийн явдлыг тайлж, өмнө хэлснээ бататган "тэнгэр газар зөдэлдэж (зөвлөж) Тэмүжин улсын эзэн болтугай хэмээн улс тээж авч айсуй" гэжээ. Цааш нь "Тэмүжин чи улсын эзэн болвоос намайг заасны тул хэр жаргуулах чи, хэмээвээ.

Тэмүжин өгүүлээрүүн, "үнэн тийн улс мэдүүлвээс түмний ноён болгосуу" хэмээвээ. Элэ эд төрийг заасан хүнийг, намайг, түмний ноён болвоос юун жаргалан буй.. гучин.. эмст болго. Бас юугаа хэлэлсэнийг (хэлснийг) минь эсрэг сонос" хэмээвээ. (121§, 319-р тал) Энд "улсын эзэн" гэдэг нь зөвхөн Хамаг монгол тайчууд хоёрын хан болохыг хэлсэн бус бүр эсгий туургатаны (хэрэйд, найман, мэргэд, татаар зэрэг) хан болохыг хэлжээ. Тэмүжин ч тийм хан болох дуртай байжээ. Хорчи өөрийгөө ихэд өргөж байгааг бодоход хан болох хичнээн чухал бөгөөд бас бэрх болохыг, өөрөө их нөлөөтэй болохыг харуулж байна. Тэр тэргүүн бөө байсан байж таарна. Бөө мөргөл ихэд нөлөөтэй байсан байна. Бөөгийн шүтлэгээр дамжуулан олон түмнийг Тэмүжинд улам бүр хүчтэй татах бодлого явуулах ажээ. Залуу Тэмүжинд юу хэлснийг сонс гэж чухал нууц зөвлөгөө өгсөн байна. Харамсалтай нь тийм зөвлөгөөний талаар ганц үг алга.

Тэмүжиний хойноос дагасан том баг буюу хүрээ нь 1. "Гурван тохарад, таван таргуд Мөнгөт хианы хүү чи, Өнгүр чаншуд, баядаараан .. надур / надад/ нэгэн хүрээн болж" /213, 713-р тал/ ирэв. Өнгүр нь Тэмүжиний үеэлэд. Энд дурдан байгаа "Мөнгөт хаан" нь 50-р зүйлд гардаг "Бардан баатарын Мэнгит хиан" мөн болой. Учир нь Боржигид овгийн нэгэн салбар нь хиад болно. Бардан баатрын "Мэнгит хиан" Есүхэйг бас 67-р зүйлд Есүхэй хиан гэсэн байдаг. Добун мэргэний бугын өрөөсөн гуяар авсан Баядын удам баядууд хожим Мэнгит хааны харьят болсон ажээ. "Мэнгит" нь зөв бичлэг.

Нууц товчоонд ганц нэг тохиолдолд нэг хүний нэрийг хоёр янзаар өгүүлсэн байдаг. 49-р зүйлд Сэчэ бэхи, 123-р зүйлд Сача бэхи, 179-р зүйлд Сача болсон.

Энэ нь хоёр шалтгаантай байж магадгүй. 1-рт Нууц товчоо нь тухай тухайн үйл явдлыг сайн мэдэх хүнээс сонсож бичсэн тул нэг нэрийг хоёр өөр хүн

өөрийн нутгийн аялгаар өгүүлснээс болсон байж болно.

"Мэнгэт", "Мөнгөт" нь ийм буюу. 2-рт анх монгол бичгээр бичсэн нууц товчоог хятад дүрс үсгээр галиглахдаа хоёр янзаар галигласан байж мэднэ.

/Хоёр өөр хүн буюу ганц хүн ч гэсэн/ "Сача" гэж нэг галиглахад "Сэчэ" гэж бас ондооноор галигласан байж болно.

2. "Баарин аймгийн Хорчи Усун өвгөн Хөхөчөс мэнэн бааринаараа нэгэн хүрээ ирэв" /120, 314-р тал/, 3.Хунан тэргүүтэй Гэнигэс, 4.Даридай Отчигин, 5.Унжин сахайд, 6.Жүрхэний Сорхат жүрхийн хүү Сача бэхи, Тайчу хоёр нэгэн хүрээн /122§, 325-р тал/ 49-р зүйл^{хүү} охин БархагийнХутугту Юрхи бөлгөө. Хутугту Юрхийн хөвгүүд Сэчэ бэхи, тайчу хоёр бөлгөө.Юрхи овогто н тэд болвоо /73-р тал/ гэсэн.

Монгол бичигт ХХ зуунаас өмнө Я,Ж/3/ үсгийг үгийн эхэнд адил дүрсээр бичдэг. Иймд "Юрхи" нь "Жүрхи" болно. "Сорхат"-ийг "Хутугт" гэх нь зөв бичлэг бололтой. Мөн 139-д "Зүрхин иргэний ёсон" өгүүлснийг харьцуул. 7. Нэхүн/Нэгүн/ тайжийн хүү Хучар бэхи, 8.Хутула ханы хүү Алтан отчигин. Хабул хааны Охинбархаг, Бардан баатар, Хутугту Монхор /хүү Бүри бэхи зүрхнийхний хамт/, Хутула ханы удмынхан бүгд иржээ. Хулан баатрын Их Чэрэн ирсэн тодорхойгүй байна. Гэвч "Богд баатар биеэр дайлсан тэмдэглэлд" Хутугту Мөнгүрийн дүү Бүри бэхи болон ... Хулан баатрын хүү Их Чэрэн жич тэдний харьяат .. Төдөгэн отчигиний харьяат нэг хүрээн бүрдүүлжээ.

Ийнхүү Хабул хааны удмынхан бүгд иржээ.

Жалайр, дархад, чаншиуд, баяд, барулас, боржигид, мангуд зэрэг 24 овгийн хүмүүс Тэмүжинд сайн дураараа нийлж ирцгээжээ.

Ийнхүү тэд Химурга горхины Айл харганад бууж (байж) бүхий дор нийлэн буув. Тэндээс нүүж Хүрэлх дотор Сэнггүр горхины Хар зүрхний Хөх нуурт

буув. /122§, 325-р тал/

Тэмүжин хан болохыг хүсэж байсан. Гэвч шууд би хан болъё гэхгүй нь ойлгомжтой. Тэрхүү нүүж ирсэн улсууд удирдлагатай, тодруулж хэлбэл, хантай болох нь хэрэгтэй нь ойлгомжтой. Тэд хүрээ хүрээгээрээ ярилцаад ахмад буюу удирдагчаа /бэхи/ явуулж, тэд нь чуулж, хэнийг хан сонгохоо ярилцсан биз.

Хан болж болох хүн гэж бас байх ёстай. Энэ нь үнэндээ Хабул ханы удмынхнаас байх ёстай. Хамгийн түрүүн Хутула ханы отгон хүү Алтанд чи хан бол гэж Тэмүжин хэлсэн биз. /179§, 534-535-р тал/ гэтэл Алтан зөвшөөрөөгүй ажээ.

Нэхүн тайжийн хүү Хучар бэхид чи хан бол гэжээ. Гэвч бас зөвшөөрсөнгүй. Нэхүн тайжийн хүү Хучир бэхи хан сонгогдох эрхтэй гэдгээс бодоход, Есүгэй баатар нь хуралдайгаар сонгогдоогүй хан байсан, Нэхүн нь тайш байсан гэдгийн илрэл болно. Дээрээс Бартан баатарын хөвгүүн хэмээн Сача, Тайчу хоёрыг та хан бол гэж ядав заа, би гэж Тэмүжин хэлжээ. Энд Сача, Тайчу хоёрыг Бартан баатрын хөвгүүн гэсэн нь буруу болой. 6, 49, 50, 139-р зүйлүүдээс үзэхэд Сача бэхи, Тайчу хоёр бол Охин Бархагийн ач нар билээ. "Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл. Г.Асралт, Хөхөндөр харгуулан орчуулав. Өвөрмонголын Соёлын хэвлэлийн хороо.1985" номын 31-р талд "Хучир, Алтан нард ... Бархаг баатрын хоёр хөвгүүн Сэцэн бэхи, Тайчу дор эзэн бол .." гэж Тэмүжин хэлсэн гэжээ. Энд Бардан баатар гэхийг "Бархаг баатар" гэж засчээ. Гэвч дутуу байна. "Бархаг баатрын хүү, Хутугту Юрхи /Жүрхи/ бөлгөө.Хутугту Юрхий /Жүрхий/ хөвгүүд Сэцэн бэхи, Тайчу хоёр бөлгөө" гэж 49-р зйлд тодорхой өгүүлсэн. /бас 122,139§/. "Охин Бархагийг" бас "Бархаг баатар" гэж байсан байх нь ээ. Рашид-ад-дины өгүүлснээр Охин Бархагийг кидан нутгийн /Зөрчиidийн/ Алтан хан татаруудаар бариулж "модон илжгинд" хадаж алжээ.

Ингэхлээр Охин Бархаг өөрсөндөө гавьяатай чухал хүн, харин Алтан ^{Ал} нүгэлтэй хүн, магадгүй хан болохоор жишигдэж байсан ч байж мэднэ. Хабул хаан ууган хүү, охин Бархагтаа иргэдээсээ “элгэндээ сөст, эрхийдээ ончтой ... эр дутам эрдэмтэн бөхөс хүчтэнийг” /139§, 381-382-р тал/ ялгаж өгсөн тул их л баатарлаг байсан биз ээ. Иймд тэдгээрийн удирдагч охин Бархагийг баатар бус гэхийн аргагүй биз. “Элгэндээ цөст” зүрх зоригтой, “эрхийдээ ончтой” гэдэг нь “эрхий мэргэн” гэсэн үг. “Бардан баатарын хөвгүүн хэмээн Сача, Тайчу хоёрыг” гэдгийг “Бархаг баатрын ач хүү Сача, Тайчу хоёрыг” гэж ойлгох нь зүйтэй байна. Сача бэхи, Тайчу хоёр хан болохыг бас зөвшөөрөхгүй ажээ. Тэд дургүйдээ бус үнэндээ бол чадахгүйдээ зөвшөөрөөгүй ажээ.

Есүхэй ханаас хойш хамаг монгол, тайчуудын холбоо задарч хамаг монгол нь олон жил хангуй байсан. Тайчууд хамаг монгол хоёр бүр естөн болсон. Хамаг монголын зарим нь тайчууд Жамухтай нийлсэн. Жамуха хэрэг дээрээ Хамаг монголыг нэгтгэж хан болох санаатай олон улс дайсагналцсан тийм үед хан болох хүн бол зовох л байж дээ. “Алтан, Хучар, Сача бэхи бүрэн эедэлдэж /зөвлөлдөж/ Тэмүжинээ өгүүлэрүүн:

Чамайг хан болгоё
Тэмүжинг хан болбоос бид
Олон дайнд алхинч хуулж /давхиж/
Өнгө сайн охин хатан, орд гэр
Харь иргэний хацар голоо хатан охин
Харгам сайн агт хатишуулж ачарч өгсүү, бид
Ороо гөрөөс авлаваас оторч өгсүү бид
Хээрийн гөрөөсний хээлийг нь нэгдтэл шахаж өгсүү, бид
Гуугийн гөрөөсний гуяыг нь нэгдэж шахаж өгсүү бид
Хатгалдах өдөр халыг /зарлигийг/ чинь бус болговоос

Харь ширээс, хатан эмээс минь хагацуулж
Хар тэргүүнийг минь газар хөсөрд гээж од
Энх өдөр зеийг чинь звдвээс
Эрс хараас эм хүүгээс минь иричүүлж
Эзэн үгүй газар гээж од”
гэж эдүй үг барилдаж ийм аман алдаж Тэмүжинийг Чингис хэмээн нэрийдэж хан болговоо. /123§, 327-р тал/

Ийнхүү Тэмүжинийг нүүгээд явахад урьдаас ярилцаж хэлэлцэхгүйгээр /Тэмүжин Жамухыг салж нүүнэ гэж ёстой зүүдлээ ч үгүй, санаанд нь огт ороогүй зүйл байсан/, хойноос нь сайн дураараа даган хүрч ирж, хамтран хэлэлцэж, Чингис цол өгч хан өргөмжилжээ.

Зарим үгийн утгыг тайлбарлада. Алхинчи –alvinci хэмээх нь хошууч болой.. Алхинч болвоос мэдээ, чимээг сургахаа хүн; даруй тагнуул, харуул гэсэн утгатай,/ Элдэндэй гуайн дурьдсан номын 55-р тал/ Хуулгабаа-эртэний монгол үг, мал адгуусны давхиж, довтлохыг /гүйдэл/ заав /55-р тал/ “харгам” нь морь малын хондлой. “о:т орчу” нь одож, явж, ав хийхэд гөрөөс, араатныг шахаж хаших гол үүрэг гүйцэтгэгч байна гэсэн үг. “Харь шир” / Элдэндэй, Ардажав гуай “Ариг шилэгээс” гэв./ гэсэн нь харийн иргэн зарц гэсэн утгатай байна. Есүхэй баатрын зарц Хуагчин эмгэн мэт. Зарим эрдэмтэн Хуагчин эмээг хятад зарц эмэгтэй гэдэг. Алтан, Хучар, Сача бэхи нар бол ийм зарцтай улс биз. “Харь шир” .. хоёр хагацаас хан гарц сацуу больюу гэдгээс тодорхой байна. /Лу.Алтантовч.УБ.1990, 91-р хуудасны арын нүүр/ “Эрэс хар” нь эрчүүд, хар хүн буюу зарц гэсэн утгатай. “Харь шир”, “эрэс хар” шүлгийн зэрэгцүүлсэн мөрний үг. “Эе” нь эв зе, зөвшин хэлэлцэн тохирсон шийдвэр гэсэн үг. “Иричүүлж” нь салах, хагацах, ангижуулах, салгах гэсэн үг. /331-р тал/

Хан өргөмжилсөн газрын тухай өгүүлье. Өмнө өгүүлснээр “Хар зүрхний

"Хөх нуурт буув" /122§/ гээд 123-р зүйл "Алтан, Хучар, Сача бэхиж бүрэн зөдэлдэж .. Тэмүжин ... хан нэрийдэж хан болговоо" гэсэн "Лу.Алтантовч. УБ.1990" номын 32-р хуудасны 2-р нүүрт "Хар зүрхний Хөх нуурт бууж, Алтан, Хучир, Сэцэн бэхиж бүхүн зөдэлдэж Тэмүжинээ өгүүлэрүүн: чамайг хан болгоё" гэсэн. Иймд Хар зүрхний Хөх нуурт байхдаа ярилцаж Тэмүжинг хан болгохоор шийдвэрээ. Хан суусан газрын тухай харамсалтай нь нууц товчоонд байхгүй. Лу.Алтантовчид ч шууд бичээгүй. Харин "Шар тууж", "Эрдэнийн товч", "Хөх түүх", "Эрдэнийн эрих"-д "Хөдөө араг" гэсэн.

"Хураангуй алтан товч", Лу.Алтантовч, "Асрагч нэртийн түүх"-д Гилүгэдэй баатрын Чингис хааны шарил ачсан тэрэг шаварт суугаад байхад хэлсэн шүлэгт "Хэрлэнгийн Хөдөө араг, хан суусан газар чинь" /Лу.Алтан товч.УБ.1990. номын 127-р хуудасны эхний нүүр/ гэсэн. Хар зүрхний Хөх нуурт хан суусан гэж шууд хэлсэн газар алга байна. "Хөдөө араг" бол бага газар биш бололтой. "Хөх түүх" зэрэгт "Хөдөө уудам дэлхий" гэсэн. Нууц товчооны 136-р зүйлд "Хэлүүрэн /Хэрлэний/ хөдөө арлын Долоон болдогуудаа бүхий дор" гэсэн.

136-р зүйлд "Чингис хааны ауруг Харилт нуураа бөлгөө" /136§, 372-р тал/ гэсэн. Ц.Дамдинсүрэн гуай "Аврага" гэдэг нэр бол XIII зууны үед байсан Монголын орд Аураг мөн гэдэг саналыг дэвшүүлсэн билээ. Монголын нууц товчоо. УХГ.УБ.1976. номын 14-15-р тал/ гэсэн. Харилт нуур Аураг ордон нь Хөдөө аралд оршиж байна. /"Монголын нууц товчоо" Газар усны нэр. О.Сүхбаатар гэсэн газрын зураг/, "Жамбадорж.Болор толь.Үндэсний хэвлэлийн хороо, Бээжин, 1984. Номын 404-р талд Ван хааныг сөнөөсний дараа "Хөдөө уудам дэлхийн Дэлгэр хан нэрт газар" гэсэн. Энэ нь чухамдаа "Хөх түүхээс" авсан бололтой. Өвөрмонголд хэвлэлсэн "Хөх түүх"-д "Дэлгэр" үг нь алга. "Хэрлэн хэмээх мөрний хөдөө арлын уудам дэлхийн дээр хан гэх нэрт газраа тэнгэрийн эд эрдэнээр үүдсэн

монгол алтан орд харш байгуулж, хаан орноо суувай" /Хөх түүх. Өвөр монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.1996 номын 47-р тал/.

Ц.Дамдинсүрэн гуай "Хэрлэний хөдөө араг нь одоогийн Баян улаан уул мөн"/өмнө дурьдсан номын 16-р тал/ гэсэн. Баян улаан уулын хоёр оргилын нэгийг нь Баян хан, нөгөөг нь Дэлгэр хан гэдэг байна. /"Монголын нууц товчоон.УБ.1947" номын 22-р тал/

Хамаг монголын хан болсон жил, оныг "Жамба.Асрагч нэртийн түүх.1666. номын 22-23-р тал", "Дармаа.Алтан хүрдэн мянган хигээст номын 72-р тал" хоёр номонд усан барс жил /1182 он/ гэсэн. Харин "Шар тууж" /1604, 1634/, , "Эрдэнийн товч" /1662, 84-р тал/, "Эрдэнийн эрих" /1841, 133-р тал/ номонд "Шарагчин тахиа жил"/1189 он/ хаан суусан гэж байна.

Монгол нууц товчооны өгүүлээмжээр бол 1182 он нь илүү үнэмшилтэй. Учир нь Саган сэцэний "Эрдэнийн товчийн 84-р талд Тэмүжин 17 настайдаа нохой жил /1178 он/ Бөртэ үжинтэй гэрлэсэн." /1162+17-1=1178/. Бас Рашипунцаг "Болор эрихийн" 34-р талд 18 настай Бөртийг Тэмүжин өөрөө сонгон гэрлэсэн гэдэг. Бөрт үжин Тэмүжинээс нэг ах тул Тэмүжин 17 настай байхдаа гэрлэсэн байна. Эндээс үзвэл гэрлэсэн он нь 1178 он / шар нохой байна./ "Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр. Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо.1991" /Анх 1987 онд хэвлэгдсэн/ номын 149-р талд "Шарагчин гахай /1179 он/ Тэмүжин .. мэргэдийг дайлж" гэсэн ба 158+-р талд "Тэмүжин, Жамуха хоёр 1181 онд "салж нүүжээ" гэсэн."

"Ш.Нацагдорж.Чингис хааны цадиг.УБ.1991 номын 43-р талд "1178 онд Тэмүжин .. мэргэдүүдийг довтолж цохиж Бөрт үжинийг авчирсны дараа "Тэмүжин, Жамуха хоёр, 1181 оны .. тэргил өдөр нүүжээ" гэсэн. /44-р тал/

"Чулууны Далай. Их Монгол улс. 1206-1260. Хөх дэвтэр. УБ.1994" номын 44, 45-р талд мөн ийнхүү өгүүлсэн.

1181 онд Тэмүжин, Жамух хоёр салж нүүхэд Жамухаас салж Тэмүжинд ирж нийлсэн улс Хар зүрхний Хөх нуурт буудалласан. Хэрэв Сача бэхи, Тайчу, Хучар бэхи, Алтан отчигин нар 1182 оноос хойш Жамухаас салж ирсэн бол “1181 онд нүүсэн улсын араас ирж “нийлж буув” гэмээргүй.”Шар туж”, “Эрдэнийн товчоо” 1189 оноос буюу Тэмүжиний 28 наснаас эхлэн хэд хэдэн дайныг өгүүлсэн он нь нууц товчооныхтой тохирохгүй байна. 34 насандaa Шар Сартуулын Тогмагийг авав гэсэн. (Шар тужын 23-р тал) Гэтэл нууц товчоонд 1219 онд буюу 57 насандaa Сартуулруу аян дайнд мордсон гэсэн. 37 насандaa Хэрэйдийн ван хааныг авав. (Шар тужын 23-р тал) Гэтэл нууц товчооныхоор 1203 он буюу 42 насандaa хэрэйдийг эрхэндээ оруулсан билээ. Ер ихэнх үйлсээ төгсвэй, би эдүгээ амран суусугай хэмээгээд 19 жил сууж (31, 33 дугаар тал) гэсэн нь бодит байдалд огт нийцэхгүй. Иймд “Шар туж”, “Эрдэнийн товч”, “Эрдэнийн эрихийн” Тэмүжин 28 насандaa шаргачин тахиа жил (1189 он) хан суусан гэдгийг итгэхэд бэрх байна.

Харин 21 насандaa Хамаг Монголын хан сууснаас хойш 19 жил, (1201 он хүртэл) Жамухын өдөөсөн дайнд ухарсан, татаруудтай байлдаж Мэгжин сүүлтийг алсан, Сача бэхи, Тайгу хоёрыг алсан 3 үйл явдлыг нууц товчоонд тэмдэглэсэн. Энэ 19 жилийт “амарсан” эсвэл “хоригдсон (Чжао хун)” жил болгодог ажээ. Тахиа жил 1201 оноос эхлэн үйл явдлыг жилээр өгүүлсэн нь Рашидаддийн “Тэмүжиний ялалт амжилт нь 40 насанаасаа эхэлсэн бөгөөд үүнээс цааш үйл явдлыг жилээр өгүүлсэн” гэдэгтэй тохирч байна.

Хамаг монголын хаан болоод цаашид зөв болох нь нотлогдсон их төр ёсоо үүдэн зохион байгуулж төр ёсыг тогтоон төлөвшүүлэх агуу их үйлсээ эхэлжээ.

Ийнхүү Тэмүжинг усан (хар) барс жил (1182 онд) Хөдөө арлын харилт нуур гэдэг газар ауруг гэдэг ордон байгуулан хамаг монголын хан

өргөмжилжээ.

Хамаг монголын хан болсныг хамгийн түрүүнд Монголын нууц товчоонд дэлгэрэнгүйгээр хамгийн тодорхой өгүүлжээ. (Харамсалтай нь хан суусан он жилийг өгүүлсэнгүй) Лу.Алтан товчид Хамаг монголын хан болсон оныг улаан барс жил (1206) оноор дурдсан хирнээ цааших өгүүлсэн нь хамаг монголын хан болсныг тоочсон. Гэтэл улаан барс жил 1206 онд Их монгол улсын хан болсныг ялгаж салгаж өгүүлэлгүйгээр зөвхөн Жүрчидэйд шагнал өгсөн хэсгээс өгүүлдэг. (177-207 хэсгийг орхиод 208§-ээс эхлэн өгүүлдэг.)

Харин Шамба. Асрагч нэртийн түүх анх удаа “Хамаг монголын хан суусан жилийг усан барс (1182) он гэж (22-23р тал) маш тодорхой заасныг Дармаа, Алтан хурдэн мянган хигээст” дээ (72-р тал) давтан өгүүлжээ. Энэ хоёр сурвалж л Хамаг монгол (аймаг), Их монголын улсын хан болсон оныг тодорхой ялан өгүүлжээ.Хан болонгуутаа хамгийн эхэлж нөхөрлөсөн Борчи, Зэлмэ хоёрыг бүгдийн ахлагч болгоод бас Жамуха андаас хагацааж намайг гэж сэтгэн нөхөцсөн (нөхөрлөсөн) өтгөс өлзийт нөхдөө өндөр албанд түшиж (томилоод) бүхнээс илүү болгоё гэсэн. Борчийн дүү (хамаатны) Өгөлэй (Өөлэй) чэрби. Хачиун-Тохураун...ах дүү Жэтэй, Догулху дөрөвт хоромсого агсуулав. Чухамдаа хааны бие хамгаалагчид ажээ. Хувилай, Чилгүдэй, Хархай-Тохураун гурвуыг Хасарын удирдлагаар Илд агсаж “хүчир хэхүүнийг хүзүүгийн нь хянгарадхун, оморхахууны Омороугий нь онлижадхун (отлогтун)” (124§, 332-р тал) гэв. Хорчин, илдчин нь хааны ордон дахь хааны бие хамгаалагч ажээ. Ер нь тэр олон улс дайсагналцсан ороо бусгаяа цаг үед хааны бие хамгаална гэдэг хамгийн чухал, хамгийн хүнд үүрэг байжээ.

Хааны хоол унд бэлдэнэ гэдэг хааны амь настай холбоотой бас нэгэн чухал үүргийг үеэл дүү Өнгүр болон Сүйхэт чэрби, Хадаан-Далдуурхан

гурвад саналын нь дагуу хариуцуулсан. Хааны хоол хүнсний эх үүсвэр болох хонь хариулах албыг хүслийн дагуу Дэгэйд хариуцуулсан. Дараагийн чухал алба бол өргөө гэр баристай байдаг гэр тэрэг, ерөөс хааны нүүдлийн хесөг болох гэр тэрэг хариуцах үүргийг саналын дагуу Хүчүүгүрд хариуцуулжээ.

Бас нэгэн чухал алба болох хааны уналга морьд хариулагч агтачны албыг Бэлгүйдэйд, адуучны албыг Худ, Морич, Мулхалху гурвад хариуцуулжээ.

Хааны эд хөрөнгө хариуцан хамгаалагчаар Сүбээдэй баатрыг томилжээ. Харилцаа холбоо буюу хол, ойрыг холбогч элчээр Архай хасар, Тахай, Сүхэхэй, Чаурхан дөрвийг томилжээ. Хааны ордонд үйлчлэгч нарыг хариуцсан "гэргэн доторхийг басаалах (хариуцах, захирах)" албан тушаалд Додай чэрбийг томилжээ. Нэг үгээр хэлбэл, хаан төрийн зохион байгуулалт хийжээ. Хан болоод төдий л удаагүй байхад Жамухын дүү Тайчар Зечи Дармалагийн адуу дээрэмдэж "арван гурван хүрээний байлдааныг" өдөөжээ. Нууц товчооны 129-р зүйлд "Чингис хаан тэнд Жамухад хөдөлгэгдэж Ононы Зээрэнээ Хавчигайяа(Зээрэн хавцалд) хоргов.(351-р тал) гэсэн." Энэ нь Жамухад түрэгдэж ухран Зээрэн хавцалд амь хоргодов гэсэн санаа. Үнэндээ тэр үед (1183 онд) Чингис хаанд Жамухыг ялах боломж байгаагүй бололтой. Чухам Чингис хааны цэргийн жанчны авьяас тодорч бүрэн ялагдах боломжоос мултарч зохистой газар (Зээрэн хавцалд) хоргодож хамгаалалтанд орсон нь Жамухын хувьд ялагдал болжээ. Ийм ч учраас Жамуха ихэд уурлан чонос: овгийн хөвгүүдийг далан тогоонд буцалгаж (шилжсэн утгаар, уур буцлах, хор шар буцлах). Нэхүдэйн цагаан гоогийн толгойг морины сүүлд чирч давхижээ. Нэхүдэйн цагаан гоо Жамухаас салж Чингис хааныг дагасан.

Ван ханд Тэмүжин олон удаа тусалж, тэтгэж, бүр албан ёсоор "эцэг

хүү" хоёр болсон боловч овилгогүй, бие тоосон Сэнгум үл итгэх байдал эхлэн үзүүлсэн төдийгүй цаашид бүр Жамух, Алтан, Хучир зэргийн үгэнд орж гэнэдүүлэн баривчлах муу санаа гаргаж, эцгээ ёс бус байна гэсээр атал үгэнд нь эс орон, эцэг хүүгийн барилдлага тасрахад хүрсэн тул Ван хан арга буюу зөвшөөрч, гэхдээ өөрсдөө хий гэдэг. Сэнгум нарын хуйвилдааныг Мэнлэг эцэгийн зөвлөснөөр ухаарч, гэнэтийн довтолгооныг зарц Бадай, Хишилиг хоёрын ачаар мэдэж, хүч ширүүн тулалдааны анхны дайралтыг няцаадаг билээ. Гэтэл ёстой мөнх тэнгэрийн ивээлээр, Сэнгум шархдаж, Ван ханыг Чингис ханыг нэхэн бут цохьё гэхэд Ачиг Ширүн ятган болиуладаг нь юутай аз завшаан. Энэ бэрх тулалдаанд шархдсан Өгэдэйг Борхул морин дээр дүүрч ганцаар ирдэг. Боорчи ганцаар ачааны янгиатай морь унаж ирдэг. Энэ тулалдаанд Чингис хаан том ялагдал хүлээж, хамаг цэрэг нь сарнин тархаж өрдөө 2600 цэрэгтэй болжээ. Гэвч хүрч ирвэл байлдана гэж зориг төгс хэлж байсан.

Үнэндээ урван тэрсэлсэн Ван ханы их цэргийг ялах боломж алга байжээ. Гэвч ялна гэж бүрэн итгэж энэ талаар Ван хан, Жамух, Алтан, Хучир, Сэнгум наарт хүн болгонд тохиуулан, заримыг нь тохуурхан ётг утгаар нэгэнтээ дайсан болцгоосныг "2600"-хан цэрэгтэй болоод мунгинаж явахдаа хэлүүлдэг нь гайхалтай. Ер нь энэ тулалдаанд их цэрэг нь бүрэн байж чадсан эсэх, Хасар хаана байсан эсэх нь тодорхойгүй. Гэвч дүү Хасартайгаа нийлж уран аргаар гэнэдүүлж Ван хан, Сэнгум хоёрыг зугатаалгажээ. Ван хан ч удалгүй алуулжээ.

Таян хаантай байлдая гээгүй, байлдах боломж ч их муу байсан үед басамжлан тохуурхан өдсөн тул арга буюу байлддаг. Цэргүүд нь дурамжхан байхад дүү Бэлгүтэй, Отчигин хоёрын их итгэл дэмжлэгээр байлдахаар тогтдог. Бүх цэргээ өөрөө манлайлаж дүү Хасараар гол цэргээ удирдуулан аз сорьсон их тулалдаанд арга буюу ордог. Даян ханы зүй

ёсны болгоомжилсон зөв аргыг хүү Хүчүүлүг нь бие тоон үл тоомсорлосоноос болж найманууд ялагдсан байна. Бас л "тэнгэрийн ивээлээр" ялдаг билээ. Ийнхүү хоёр том аймаг өөрсдөө өдөж байлдаад хүч давуу, боломж сайтай атлаа ялагдсан. Харин "эцэгэс өвгөдийг" барсан естэн татарыг бол Алтан ханы цэрэг довтлох үед хажуугаас нь хамсан байлдахаар Ван хан, Сача бэх хоёрт хэл хүргүүлдэг. (Ван хан, Сача бэхийн эцэг, Амбагай хан гурвыг татарууд Алтан ханд барьж өгч модон илжгэнд хадуулж алуулдаг. Есүгэй баатарт хор өгч алсан). Гэтэл Сача бэх ирээгүй төдийгүй, урьд нь өдөөсөн хэрэг дээрээ нэмж харин ар гэрт үлдэгсдийг довтолж "тавин хүний хувцсыг тонож, арван хүнийг алж" дайсан дээр дайсан болсон тул машид хилэгнэн байлдаж устгасан билээ. Хамгийн хүчит Жүрихэн омгийнхон өөрсдийн буруугаас болж ялагдсан. Нууц товчоонд зүрхинийхнийг ялсаны бахархсан өнгөөр өгүүлсэн байдаг.

Чухам ийм учраас

"Одтой тэнгэр
Орчиж бүлгээ
Олон улс булх (дайсан) бүлгээ
Орондоон үл орон
Олзöлдөн бөлгөө.
Хөрст этүгэн (дэлхий)
Хөрвөж бөлгөө
Гүр улс булх бөлгөө
Хөнжилдөөн үл хэвтэн
Гөрлөлдөн(герөлцөн) бүлгээ" 254§ гэсэн байна.

Тийм цагт

Хүсэж эс явав заа
Хүрэлцэхүй дор болов заа

Буруулж эс явав заа

Булхалдахуй (дайсагналцахуй) дор болов заа.

Амар ч эс явав заа

Алалдахуй дор болов заа

гэж өгүүлжээ.

"Лу.Алтан товч.УБ. 1990" номын 106-р талын эхний нүүрт

Алтан бие минь алжааваас алжаатугай

Аху төр минь бүү алдартугай

Бүтэн бие минь зовбоос зовтугай

Бүрэн улс минь бүү сандартугай

гэсэн байдаг. Гэтэл Шар түүж, Эрдэнийн товч, Хөх сударт үйл явдалыг хэт хураангуйлж, он жилийг буруу тогтоон 19 жил амруулсан байдаг.

Нууц товчоонд бас цааш нь (254§)

"Хан эцэг тань хамаг улсаан байгуулан

"Хар тэргүүнээ гандуулж

Хар цусаан намбаалж (юулж)

Хар нүдээн үл ирмэн

Хавтгай чихээн дэрд үл тавин

Ханцуй бээн дэрлэж

Хормой бээн дэвсэж

Шүлсээр ундалж

Шигжээс (шүдэнд орсон) махаар хонож

Магнайн хөлсөө улд хүртэл

Улын хөлсөө магнайд гартал"

өлөмлөн хичээн явсан ажээ".

Ингээд "Монголын нууц товчооны" 202-р зүйлд өгүүлснээр "Төдий сисгий (эсгий) туургат улсыг шударгатгаж (нэг удирдлагад оруулж) барс жил

Ононы тэргүүнээ хурж есөн хөлт цагаан туг байгуулаад Чингис хаанд хан нэр тэнд өгөв". Улсын нэрийг "Их монгол" гэж "Алтан хүрдэн мянган хигээст" (77-р тал), Алтан эрихэд (25-р тал) шууд бичиж Инжиннаш "Их монгол улсын Чингис хааны тэргүүн он" гэж дам өгүүлсэн. Чжао хун (1221 оны Сүн улсын элч) "Манай Жиэз Дингийн IV онд (1211) Татар сая нэрийдлээ нэгэтгэн Их монгол улс хэмээн нэрийдсэн ("Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл. Өвер mongolын Соёлын хэвлэлийн хороо. 1985" номын 107-р тал) гэсэн. "Хураангуй алтан товч", "Лу.Алтан товч", "Гангийн урсгал", "Монголын боржигод овгийн түүх", "Болор эрих", "Алтан эрих", "Хөх судар"-т 45 насандаа бин (улаан) барс жил Онон мөрний эхэнд 9 хөлт цагаан туг байгуулан (сүүлийн дөрөвд "9 цацлагат", "9 манжлагат", "9хөхөлт" цагаан туг гэв) Чингис хааныг хаан болгосон тухай өгүүлсэн. "Нууц товчоо"(9 хөлт), "Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл"(9хөхөлт), "Асрарт нэртийн түүх"(9 хөлт), "Алтан хүрдэн мянган хигээст", мэргэн гэгээний "Алтан товч"-ид барс буюу улаан барс жил хаан суусныг тэмдэглэсэн. "Чингис хааны төрсөн он зэрэг чухал гол үйл явдлын товчоон" үз. "Рашпунцаг. Болор эрих" номын 54-55-р талд "Улаан барс (1206) Тайзу Чингис хааны тэргүүн он өвлийн сүүл сард Монголын халх, баарин, баяд,... монголжины мянган тэргүүтэн, бус бас харьяат олон аймгуудын эзэд бүгд цуглаж бүрэн. Тэмүжиний дүү нар хийгээд сайдууд лугаа зөвлөж өгүүлэлдэрүн "манай эзэн энэ Тэмүжин төрснөөс янагш их буянтай бөгөөд өршөөл журам ба мэргэн баатар, цог жавхлан тэргүүтэн хотол эрдэм бүридсэний тул үнэхээр тэнгэрээс занасан эзэн мөн амой. Эдүгээ манай монгол улсад бүгдийн хаан болгосугай" хэмээн Тэмүжинд мэдүүлж тогтоод сайн өдөр сонгож бүрэн. Онон мөрний эхинд ордыг байгуулаад есөн манжлагат цагаан тугийг босгож олон бүгдээр Тэмүжинийг залж ирсэн хойно Тэмүжин өөрийн биеэр тэнгэр газар хийгээд дээдэстээн

тахиж мөргөөд Бат-өлзийт тавцан дээр хаан болон суувай. Тэр цагт дэчин таван сүүдэртэй бөлгөө. Тэр учир дээр эс үзсэн таван зүйлийн өнгө лүгээ тегссөн гайхамшигт нэгэн их шувуун хааны тус дээрх огторгуйд цэрвэн байж "Чингис Чингис" хэмээн олонтаа донгодхуйг олон бүгдээр үзээд гайхаж өгүүлэлдэн "үүнийг шинжилвээс манай энэ хаанд дээд тэнгэр бээр Чингис хэмээх цол өгвэй" хэмээгээд даруй дүү нар, хөвгүүд ба олон сайд түшмэд хийгээд хамаг улс иргэн нь бүгдээр маш баясч тэнгэрээс занат хамгийн эзэн эцэг, түмэн наст Богд Чингис хаан хэмээн дуудаж, есөнтөө мөргөвэй. Тэр өдөр Чингис хаанд баярын их хурим өргөөд олон бүгдээр ханаталаа хуримлалаа" гэж өгүүлжээ.

"Дөчин түмэн Бидэ (бид) улсын эзэн болоод зарлиг болоруун мунданин явж нармайг зовон зөөж зонхилон хураахуйяа мунгинаж, зоволдон, жаргалдан хүчээн үлэмж өгсөн молор эрдэнэ мэт энэхүү Бидэ улс минь мунгаан үзэтэл зовбас бээр (зовсноор), ерөнхийн гол болсоноор хедлөхийн дээд Хөх Монгол хэмээгдэхүй" (Саган сэцэн. Эрдэнийн товч.УБ.87-р тал) хаанд "хас буу (хас эрдэнэ) тамга" өргөн барьсныг зарим сурвалжид бичсэн байдаг. Чингис хаан, хаан болоод хаан төр байгуулах албанд үнэнээр зүтгэсэн олон хүмүүсийг хичээсэн зүтгэл, хийсэн гавьяанд нь тохируулан мянганы ноён, түмний ноён, чэрби болгож есөн эндэ^л ортол үл яллах, дархлах, хатнаа өгөх, дуртай цагтаа орж гаран, юу хүссэнээ авдаг эрх олгох зэрэг зүйл зүйлийн шагнал урамшлыг гавьяа зүтгэлий нь дурдан байж олгов. Эхэлж итгэн ирж, эргэж буцалтгүй хүчээн өгсөн олон хүн мянганы ноёд болов. Бүгд 95 мянган болов. Баруун, төв, зүүн түмэн байгуулж Боорч, Наяа, Мухулайгаар ахлуулав.

Ер нь нэг үгээр хэлэхэд төр улс байгуулахад хичнээн их, хичнээн үнэнч үйлчилснээр нь төчнөөн их хэргэм, зэрэг, шагнал, соёрхол гардуулжээ. Өөрийн амь аврахад тусалсан боржигидийн боол, зарц явсан Сорхон шар;

Бадай, Хишилиг гурвыг мянганы ноён болгож, хамгийн дээд шагнал буюу газар нутаг сонгуулан дархан эрхтэй (олз, орлогоосоо хаанд хишиг өгдөгүй) болгож, эд баялагийт ёстой л сэтгэл харамгуй үлэмж их өгсөн. Дараа нь засаг цааз, хууль ёс тогтоон тунхаглажээ. Мөн 1204 оноос хүүхэд, дүү нартаа заалгаж эхэлсэн уйгаржин монгол бичгийг төрийн бичиг болгож, тамга, бичиг эрхлэгчээр Татангуаг томилжээ. Их цэргийн ерөнхий жанжинаар Хувилайг томилжээ. Хишигтэн, хэвтүүл, тортон цэргийг түмд хургэж, мянганы ноёдоос илүү эрх мэдэлтэй болгож, ээлж хишиг хэрхэн солилцохыг хүртэл нарийн тогтоожээ. Хэлсэн, шийдсэн, тогтсон зарлиг зэргийг "Хөх дэвтэрт" бичиж байхыг үүрэг болгож Шихихутагийг улсын заргач болгов. Их монгол улс байгуулж, З түмний ноён, 95 мянганы ноён томилох, гавъяатан жанжин нараа шагнахаас эхлээд хишигтэн хэвтүүл, тортон цэрэг, ээлж солих хүртэл, нүүдлийг хэн мэдэж хэн нь их нүүдлий урд, хэн нь ард явах зэргийг хүртэл нарийн заасан хаан төрийн зохион байгуулалтын талаар хамгийн дэлгэрэнгүй 202-р зүйлээс эхлэж 234-р зүйл хамран өгүүлжээ. Чингис хааны олон байлдаанаас бүр илүү чухал болгон онцгой дэлгэрэнгүй товоилгон бичсэн нь Хамаг монгол аймгийн хан болсон тухай болон Их монгол улсын хаан болсон тухай хамгийн гол хэсгийг ноён оргил болгон өгүүлсэн нь учиртай. Монголын нууц товчообол Чингис хааны байгуулсан монгол төрийн түүх байна. Монгол улсын хувьд Чингис хааны агуу их гавъяа нь монгол төр улс байгуулсан явдал болно.

Чингис хааны язгуур буюу угийн бичиг (мод)

Монголын нууц товчоонд Чингис хааны дээд 22 үеийн нэрийг заримын нь гэргийн хамт дурдсан байдаг. Яаж ийнхүү 22 үеийн нэрийг дурдсан бэ? Гэдэг асуудал гарна. Монголчууд нэн эртнээс үр хүүхэддээ уг гарал,

удам угсаагий нь сайтар таниулан тогтоолгодог заншилтай байжээ. Нэг үгээр хэлбэл, ямар овог, ясны хэний хэн бэ гэдгээ сайтар мэддэг аман түүхийн уламжлалтай байжээ. Тухайлбал, Чингис хааныг боржигид овгийн хиад ястан (алтан урагийнхан, алтан ястан) гэдэг байжээ. Энэ талаар 1307-1311 оны үед персийн (одоогийн Ираны) алдарт эрдэмтэн байгалийн ухааны нэвтэрхий толь, түүх, ургамал судлал, хөдөө аж ахуй барилгын техникийн бүтээл туурвисан Рашид-ад-дин (1247-1318) Илхаант улсын Хасан хан (оросоор нь Газан-хан), Өлзийт ханы төрд шадар сайд байхдаа бичүүлсэн "Судрын чуулган" даа "Монголчууд төрсөн хүүхэд бүрдээ түүний уг удамыг нь тайлбарлан таниулж, ухааруулан хадгалуулдаг заншилтай учраас овог бүр яруу тод тогтоосон угийн бичигтэй (гэрийн үеийн түүхтэй). Ийм учраас уг удам, овог аймгаа мэдэхгүй нэгээхэн бээр үгүй. Уг удмаа хадгалдаг арабуудыг эс тооцвол, монголчуудаас өөр ийм заншилтай овог, аймаг байхгүй." (Рашид-ад-дин. Сборник летописей История монголовъ, История Чингизъ-Хана (Пб.1868" номын 8-р тал). Нууц товчоонд Чингис хаан өөрийн удам судраа мэддэг төдийгүй, Ван хан болон Тоорил (Хабул хааны үеийн боол)-ын удам судрыг сайн мэдэж байсан. Энэ уламжлал ямар нэг хэмжээгээр хожуу үе хүртэл, тодруулбал бараг XX зуун хүртэл үргэлжилжээ. Рашид-ад-дины өгүүлснээр угийн бичиг буюу гэрийн үеийн түүх (угийн бичиг) ялангуяа хааны удмынханд олон байжээ. Нууц товчооноос гадна олон түүх тухайлбал "Алтан дэвтэр", "Алтан хуйлмал" нэртэй түүх байжээ. (Бэхи (ноён), болон хааны номын санд)

Эртнээс өөрсдийгээ монгол гэж нэрлэдэг байсан овог, аймагууд бараг 2000 орчим жилийн өмнө дайсагналцан тулалдаж ердөө хоёр эрэгтэй, хоёр эмэгтэй үлджээ. Хоёр эрэгтэйн нэр нь Нукузъ (Чонос), Кыянъ (Хиан) юм. Өмнөх номын 135-р тал. "Тэр хоёр өрх айл дайснаас айн тийшээ нэвтэрэн очиход бэрх бартаатай ганц нарийн зөргөөс өөр хаанаасаа ч орох замгүй

уул хад, их ой хүрээлсэн хэцүү газарт очжээ... Тэр газрын нэр нь Эргунэ-Кун (Эргэнэ-Хун)... тэдний удам олон жилд тэр газраа сууж, өнөржин үржжээ... газрын зай нь давчдан хүрэлцэхгүй болхоор тэр сүрхий хавцал, уулын давчуу сувээс ямар сайн арга, хялбар замаар гараахыг биеэсээ зөвшин асуулдажээ. Тэд... төмрийн хүдрийн орд газрыг олцгоожээ. Тэд бүгдээр цуглаж, ойд их түлээ зэхжэж, бүхэл бүтэн тулмаар нүүрс бэлтгэж, далан морь, шар нядлаж, ширий нь бүхэл өвчин, төмөрчний хөөрөг хийгээд, түлээ нүүрсийг тэр хэвгий уулын бэлийг хайлан урстал нэгэн зэрэг хөөрөгджэй байхаар зэхжээ. Тэгээд хэмжээлшгүй их төмөр авч, уулын сүвийг онгойлгожээ. Тэд нар хавцлаас цөм цүг нүүдэллэж удам тал газар гарцаажээ". (Монголын ардын аман зохиолын дээж бичиг. Хоёр дахь хэвлэл. УБ. Номын 213-214-р тал.1*). Эрдэнэ-хунаас гарагсадын дунд "зарим овгийн удирдагч, тэргүүн бэхи (ноён) Бөрт чоно байлаа. Добун баян, гэргий Алан гоо болон өөр хэд хэдэн овог нь чухам Бөрт чонын удам юм. Бөрт чоно нь олон гэргийтэй байсан бөгөөд авааль гэргий Гоо маралын хамгаас азтай хаан суусан хүү нь Бидежи-хаан(Батачи хан) юм.(Өмнө дурдсан орос судрын чуулганы 4-р тал) Нууц товчоонд дурдсан Чингис хааны дээд 22 үе нь үнэн байдалд тохирох эсэхийг тогтоох боломжгүй ч гэсэн үнэхээр бахархахгүй байхын аргагүй түүхийн баримт юм. Монголын нууц товчоо, Лу. Алтан товч хоёрын Чингис хааны дээдсийн жагсаалт ердөө ганц хүнээр зөрж байна. Үүнд Лу.Алтан товчид Чингис хааны дээдэс 23 үеийг бичжээ. Хабич баатрын дараа Бэгэр (Бигэр) баатрыг "Хураангуй алтан товч", "Эрдэнийн товч"(76-р тал) "Асрагч нэртийн түүх (9)", "Гангийн урсгал"(43), "Монголын боржигод овгийн түүх"(32), "Алтан хүрдэн мянган хигээст"(19), "Мэргэн гэгээний алтан товч"(18), "Хөх түүх"(45), "Эрдэнийн эрих"(131), "Болор толь"(387), гэсэн 10 түүхийн сурвалжид дурдсан байна. Иймд монголын нууц товчоонд Бэгэр баатрыг

орхижээ гэж үзэж болох байна. Ингэвэл Чингис хааны дээдэс 23 болно. Зарим сурвалж 22 үед баригдаж, Бэгэр баатрыг оруулсан хирнээ Хайдуг Хураангуй алтан товч, Эрдэнийн товч, Асрагч нэртийн түүх, Хөх түүх, Эрдэнийн эрихэд орхисон байна. Мэргэн гэгээний алтан товч, болор тольд Хачи хүлэгийг орхисон байна. Монголын нууц товчоонд Мэнэн тудуйн хүү нь Хачи хүлэг, Хачин, Хачиу, Хачула, Хачиун, Харандай, Начин баатар долоон бөлгөө.(45) Хачи хүлэгийн хүү Хайду Номалун эхээс төрсөн.(46) Элдэндэй, Ардажавын "Монголын нууц товчооны сийрүүлэл-тайлбар. Өвөрモンголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1986. Номын 65,66-р тал".

Рашид-ад-дин Бодончарын хүүхэд гэж Бука(Буха), Буктай(Бухтай) хоёрт дурдсан нь үнэн хэрэг дээрээ хоёр ах Буху хатаги, Бухату салжи хоёрын эхний нэрийг дурдсан шиг байна. Бодончарын хүү Хабич, түүний хүү Бэгир хоёрын нэр орхижээ.

Лу. Алтан товчид "Маха тудуны Номалун тортон гэргийгээс долоон хөвгүүн төржихүй. Анхны ах нь Хачи хүлэг, Хачин, Хачиу, Хачила, Харалдай, Хачуун, Начин баатар долоон бөлгөө. Хачи хүлэгийн хүү Хайду нэрт бөлгөө". (Лу.Алтан товч.УБ. 1990. Номын 8-р хуудасны арын нүүр). "Маха" үгийг нууц товчоо, судрын чуулган хоёрт "Мэнэн" гэсэн. Судрын чуулганд Дутум-Мөнөн (өмнө дурдсан 1868 оны орос номын 14-р тал). Алтан товчид нууц товчооны өмнө дурдсан 45-р зүйлд "Мэнэн тудуны" ард "Номалун тортон гэргий" гэж 46-ээс үг оруулж утгыг нь өөрчилжээ. Энэ зөв үү? Монголын нууц товчоо нь манай ууган түүхийн сурвалж гэдэг нь маргаангуй үнэн тул нууц товчооны үгийг илүү хүндэтгэн авч үзэх нь аргагүй шүү дээ. Гэвч бас шууд тулгаж болохгүй. Учрыг нь олох гэж оролдьё. (Энд "торгон гэргий" үгийг алтан товчид сүүлд нэмжээ. "Тортон" нь "тарган" үгийг буруу бичсэн нь байна. Учир нь судрын чуулган болон

монгол зарим сурвалжид "Номалун тарган" гэдэг). Цааш нь Хачи хүлэгийн 6 дүү ямар ямар овогтон болсныг нууц товчоо, Лу.Алтан товч хоёрт үндсэндээ адилхан өгүүлдэг. Лу.Алтан товчид "Хачины хүү Ноёгидай нэрт белгөө" өгүүлбэр орхиж "ноёмсог авирт" гэж эхэлсэн. Гэтэл судрын чуулганд "Дутум-Мэнэн 9 хүүхэдтэй. 8 нь алуулсан, ганц Хайду үлдсэн. Энэ 9 хүүхдийн нь эх Мунулун хатан бас Мунулун-Тарган гэдэг"(дурдсан орос номын 17-р тал). Хайду-хан нь Дутум-Мэнэний ач гэж ахмад Бэхүүдийн хадгалдаг "Алтан хуйлмалд" дурджээ. Гэвч энэ үгийг хүндэтгэн үзэх аргагүй юм гэж Рашид-ад-дин өгүүлжээ. (дурдсан номын 13-р тал). Гэтэл энэ нь харин нууц товчооны өгүүллээр Хайду нь Мэнэн тудуны ач гэсэнтэй тохирч байна. Судрын чуулганы ганц Хайду үлдсэн гэдэг нь Дай Юан улсын түүх, мэргэн гэгээний алтан товч (Махагарьд Мэнрөл хатан гэсэн), болор эрих зэрэгт Номалун хатан жалайр аймгийн хүүхдүүдийг тэргээр дайруулж алж, шархдуулсан тул тэд өшөө авч Номалун хатан, түүний хүүхдүүдийг алж ганц Хайдуг нууж үлдээж авга ах Начин нь аварсан гэдэгтэй тохирч байна. Хэрэв Мэнэн тудун (Маха Тудун), Номалун хатан хоёрын хүүхдүүд (Хайдугаас бусад нь) алуулсан бол нууц товчоо, Лу.Алтан товч хоёрт Хачи Хүлэгийн 5 дүүгийн ноёгидай, барулас, эрдэмт барула, төдөгөн барула, будаад, адархан овог хэрхэн үүсэх билээ. Харин Хайдуг зарим сурвалжид боржигид овогтой гэнээс өөр ах, дүү нарын нь талаар огт дурддаггүй. Иймд Хайдугийн ах нар нь эхнэр, үр хүүхдийн хамт алуулж, ганц Хайду үлдсэн нь үнэн байх нь. Нэгэнт Мэнэн тудуны хүүхдүүд алуулаагүй гэдэг нь нууц товчоо, Лу.Алтан товч хоёроос тодорхой ба нууц товчоо "алтан хуйлмал" (Судрын чуулганд дурдсан) хоёрт Хайдуг Мэнэн тудуны ач гэсэн тул Номалун нь Мэнэн тудуны гэргий бус, харин Хачи хүлгийн гэргий болж нууц товчооны "Хачи хүлэгийн хүү Хайду Номулун эхээс төрсөн" гэдэг нь үнэн байна.

Хачи хүлэг, Номулун гэргий хоёр 9 буюу 7 хүүхэдтэй, отгон нь Хайду. Хайдугийн ах нар, эхнэр хүүхэд нь жалайруудад алуулж Хайдуг нууж (түлээн дор буюу бүрхээрт эсвэл бүр хөхүүрт) үлдээж Авга ах Начин баатар нь авч, гэртээ өсгэж бойжуулжээ. Хожим нас бие гүйцэж, Начин баатар авгын хамт жалайруудаас өшөө авч тэднийг боол болгожээ. Хайду хан болж, Начин баатар туслагч болж ихэд алдаршсан гэж Мэргэн гэгээний алтан товч, гангийн урсгал, алтан хүрдэн мянган хигээст, болор эрих, дайюан улсын түүх зэрэгт өгүүлсэн.

Нууц товчооны 51-р зүйлд "Хутула хааны хүүд Зөчи, Гирмау, Алтан турван бөлгөө. Хулан баатрын хүү нь Их Чэрэн бөлгөө. Бадай, Хишилиг хоёр дархадын ноён тэр бөлгөө. Хадаан, Төдөөн хоёр ураг үгүй бөлгөө" гэсэн. "Бадай, Хишилиг... ноён тэр бөлгөө" өгүүлбэрийн өмнө хойно нь Хабул хааны 3 хүүхдийн үр хүүхдийг өгүүлсэн нь ер авцалдахгүй байна. Учир нь хэдийгээр Чингис хааны алтан амийг аварч дархан ноён болсон ч гэсэн, Хабул хааны ачийн адуучин (зарц) хүнийг энд дурдах ёсгүй билээ. Бусад түүхэн сурвалжид огт байдаггүй. Монголын эхний "таван хааны үнэн түүхийг бичих үед Хишилигийн ач улсын түүхийн хүрээлэнгийн эрхлэгч бөгөөд улсын түүхийн найруулагч, түүх бичгийн захирал байсан Хорихусуны ("Дай Юан улсын бичиг. Өвөр mongolын Соёлын хэвлэлийн хороо. 1987" номын 15-р тал, оршил) хийсэн хэрэг. Чингис хааны өөд болохоосоо өмнөхөн хэлсэн үгэнд бас "Хувилай хүүхний үг өөр буй" (Лу.Алтан товч.УБ. 1990. Номын 126-р хуудасны эхний нүүр. Бас өөр хэд хэдэн түүхэн сурвалжид байдаг) гэсэн илт зусардсан өмнөх, хойнох үгтэйгээ авцалдахгүй үг бичсэн байдаг. Энэ бараг Хувилай хаан, Хорхусан хоёрын "наймаа" байж магад. (Мөн өмнө дурдсан номын 304-р тал). "Жи (Zhi) Юаны 25-р оны (1288) хаврын дундад сард Се до цолт Са ли ман зэргийн түшмэд хааны өвгөдийн магад хуулийн дуудаар орсонд Шизу хаан

(Хувилай) зарлиг болоруун: "Тайзунг хааны явдлыг ч бичсэн нь үнэн ... руйзунг (Тулуй) хааны явдалыг өчүүхэн солжихуй" гэсэн. Юу сольсон гэдэг нь тодорхойгүй нь харамсалтай. Лу.Алтан товчид (Лу.Алтан товч нь Хувилай хааны үед зохиосон "Алтан дэвтэр" зэргийг ашигласан буюу эсвэл Чингис хааны хэсгийг тэр үед зохиосон байх). "Чингис Богд эзний бие бэрх чилээрхэж бас Тулуй эзэн чилээ болсонд ... нэгэн сайн болвоос нэгэн нь муу буй хэмээгсэнд ... Тулуй эзэн бурхан болов". (Лу.Алтан товч.УБ.1990. номын 114-р хуудасны 2-р нүүр) гэсэн. Гэтэл яагаад нууц товчооны Өгэдэй хааны хэсэгт Өгэдэй хааны золиос болсон Тулуйг Чингис хааны золиос болгов? Түүхийг илт гүйвуулахын учир юу вэ? Цаашид Тулуйг нас барсан хэмээн үзэж үүндээ тохируулан бичсэн. Өгэдэй хааны хэсгийг нууц товчооноос огт өөрөөр өгүүлсэн. Гүюг хааны дараа Мөнх хаан суусан, тодруулж хэлбэл, хаан ширээ Тулуйд шилжсэнийг зөвтгөх үүднээс ийнхүү сольсон юм биш байгаа даа. Хувилай хаан ийнхүү солиход нөлөөлсөн юм биш байгаа даа. Шар тууж (47-р тал) эрдэнийн товчид Тулуй эзнийг сэргүүн ахуйд өөд болсон гэсэн. "Нууц товчооны 255-р зүйлд "Өгэдэйн урагт" "Өлөнд хучивч үхэр үл идэх, өөхөнд хучавч нохой үл идэх төрвөөс миний ураг дор нэгэнүү нь сайн үлү төрөх ажуу хэмээн зарлиг" болов гэснийг нэмсэн ч байж магад (зарим эрдэмтэний өгүүлдэгээр)*.

"Эрдэнийн товч", "Алтан хүрдэн мянган хигээст", "Мэргэн гэгээний алтан товч" зэрэгт Дува (Дуя) сохорын дервэн хүүхдийн нэрийг "Доной, Догшин, Эмнэг, Эрх" гэж бичээд "ойрад, өөлд, баатад, хойд хэрнүүд дервэн овогтон болвой. (Эрдэнийн товч.УБ.1961. номын 73-р тал) гэсэн. Харин Берт чоныг Батсанаа, Батцагаан хоёр хүүтэй байсан бөгөөд Батсанаагийн удам тайчууд овогтон болсон гэсэн нь нууц товчоо, Лу.Алтан товч судрын чуулган зэрэгтэй тохирохгүй худал зүйл болно. Эрдэнийн

товчид Бэгтэр, Бэлгүдэйн эхийг Тагш хатан (номын 78-р тал) гэсэн. Лу.Алтан товчид Бартан баатар, Есүхэй баатрын хоёр дахь хатан хоёрын нэрийг Сочигил үжин гэсэн. Судрын чуулганд "Сүнигүл фүжин" гэсэн. Есүхэй баатрын хоёр дахь хатны нэр нь Тагш, Бардан баатрын хатны нэр Сочигил үжин (Сүнигүл фүжин) ажээ. Мэргэн гэгээний алтан товч нь Хасарыг хэт дэвийлгэж харин ч Чингис хааныг үл ойшоох аясаар бичсэн ба Өүлэн (Өөлэн) хатныг Есүхэй баатартай нэгэн жил нас барсан гэж худал бичсэн боловч Есүхэй баатрын нас барсан оныг цагаан барс жил гэж анх мэдээлсэн бөгөөд Батачи ханыг Бөрт чонын 29 насан дээр гарсан, Тамажийг Батачи ханы 21 насан дээр гарсан (Мэргэн гэгээн. Алтан товч. Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо.1998 номын 41-р тал) гэх мэтээр хүүхэдийг нь эцгийнхээ тэдэн насан дээр гарсан гэсэн нь тун гайхалтай.(Ната Алтан эрихдээ үүнийг иш татан өгүүлсэн.) "Бодунчарын тэрсэн жил нь сүнг улсын тайсу кан боо хэмээгсэний гуравдугаар оны улаан морин жил" (өмнө дурдсан номын 42-р тал) гэсэн. "Бодунчарын улс гүрэн нь маш олон болсон дор бүгдийг Монгол улс хэмээн нэрийдбэй. Сүнг тэр лүгээ зохицон судар бичиг эрдмийг туулбай. Гэр дор тэр ёсны багштай, хээр дор замын сахиултай, гэгээн онол утгын тогтоолтой гэж бичсэн.(өмнө дурдсан номын 46-р тал)" "Бодончар хан нь удмын мод (угийн бичиг)ны үрийн цөм нь юм.(10) "Бодончар нь Алан гоогийн гурав дахь хүү, олон Монгол овгийн удирдагч, эзэн бөгөөд дэндуу зоригтой, дайчин нэгэн юм". (өмнө дурдсан "Судрын чуулганы" 12-р тал) гэсэнтэй үндсэндээ тохирч байна. Добу мэргэний Булаг хатан Буху, Бухачи хоёр хөвгүүнтэй гээд дараа нь Алаг хатан авсан ба шалтгаантай болсон хойно Добу мэргэн нас барсан (42-р тал) гэх мэт өмнөх Добу мэргэн нас барсан (42-р тал) гэх мэт бусад сурвалжуудад байдаггүй, нууц товчооноос зерсэн мэдээ дурдсан. Энд Мэргэн гэгээн Бодончарыг тэнгэрийн хүү, Алангоог гэрлээр

жирэмсэлсэн гэж үздэг өмнөх түүхчидийн өгүүлснийг няцаажээ. Мэргэн гэгээний Алтан товчийг Алтан эрих, Хөх түүх, Болор толь ашиглан бичсэн. Ер нь Мэргэн гэгээн өмнөх түүх бичлэгт нилээн шүүмжлэлтэй хандсан. Добун мэргэний Алан голоо хатныг Хөх түүхэд "нүүр хийгээд хацар дэлгэр, жигд цагаан шүдтэй, нүд агуу, хамар өндөр тэгш, улаан уруултай, бие зөөлөн, үс хар, зус маш тунгалаг, дуун яруу, хөлсөн хир ба нойр зоог өчүүхэн, нууц орон зөөлөн, зузаан үс унгас цөөн, их зааны явдалтай зөвшөөрөх эргигч шар үсүн үгүй бөгөөд голоо нарийн биетэй тэр мэт бэлгэ чанар төгссөн" (43,44-р тал) гэсэн. Добун мэргэний нас барсан хойно Алангоо хатаны Добун мэргэнээс гарсан Бэлгүдэй, Бүгүнүүдэй хоёр хүүд (хүү) нь энэ эх, бидний ах дүү үе хая хүн үгүй, эр үгүй бөөтөл эд гурван хүүд төрүүлби. "Гэр дотор ганц Маалиг баяуудай хүн буюу. Эд гурван хүүд түнийх буюу зэ" (18) гэж нууц товчоонд өгүүлдэг.

Хүннүгийн үеэс (Сыма Циний түүхийн тэмдэглэл), Алтан хан хүртэл, эр хүн тэжээж чадах хэрээр хичнээн ч эхнэртэй байж болдог ба хэрэв нөхөр нь нас барвал, нөхрийнх нь ах, дүү, бүр төрсөн хүүхэд нь бус бол өөр эхнэрийн хүү нь ч аавынхаа эхнэртэй сууж болдог заншил ёсоор эхийгээ "ах дүү үе хая хүн үгүй" (үе хая нь үеэлд хаяалд ах дүүгийн хүүхдүүд) байтал гэж өгүүлсэн байна. Үнэхээр ч Добун мэргэний төрсөн ах Дува сохор (согор гэдэг нь анчин гэсэн утгатай урианхай үг гэж би 1990 онд Урлаг утга зохиол сониноос уншсан санагдана.) нас барсан ба 4 хүү нь хаяад нүүсэн болохоор юуны "үе хая" байх вэ дээ. Алангоо эх хоёр хүүхдийнхээ тийнхүү ярилцахыг ухаарч мэдээд хонины бага зэрэг үнэртэй бололтой мах чанаж өгөөд хэлдэг нь учиртай (хавар махны ховор цагт мах чанаж өгч хүүхдүүдээ уярааж байгаа хэрэг). Үнэн худлыг хослуулан "Цэгээн шар хүн гэрт өрх тогтын гэгээ бээр орож, хээл минь билиж (илбиж) гэгээ нь хээл дор минь шингэх бэлгээ." (21) гэдэг нь хэрэг дээрээ хүн

орж ирээд хурьцсан санааг хүүхдүүдээ эвтэйхэн хэлж буй хэрэг.

Хөдөө хүүхдийг ходоод (гэдсийг) илж, үнсэж хурьцахыг битүүгээр ходоолох гэж ярьдаг тохиол байдгийг би хүүхэд байхдаа сонссон. "Ээжээ, ах эгч хоёр ходоолоод байсан" гэж 5-6 настай хүүхэд ээждээ хэлж хорь гарсан, гэртээ байсан эгчээ ичээсэн гэдэг.)

Алангоо хүн орж ирдэгийг нуусангуй. Харин "гэрэл нь хээлд шингэсэн" гэж урнаар гүйвуулаад нар сартай холбож "гараах нар сарны хилээр шар нохой мэт шарвалзаж (баярлаж) гараах бэлгэө" гэсэн (21) буцаад хүн болсон нь сонирхолтой. "Гэрэл", "нар", "сар" хэрэглэж, хаалгаар бус "өрх, тогтын гэгээгээр орж ирдэг" ер бусын, тодруулбал "тэнгэрийн хүүд" болгон дүрсэлж хожим хан болно гэж хэлсэн нь биелсэн. Эцсийн дунд хүн орж ирээд хээлийг нь илээд баярлаад гардаг байна.

Хожмын түүхчид сүсэг бишрэлээр далимдуулан Бодончарыг тэнгэрийн хүү болгосон. Энэ нь үнэндээ Чингис хааны Тэнгэрээс занят Бөрт чонын удам тасарсаныг нөхөх аятайхан шалтаг болж "тэрлээр жирэмсэлсэн" домог үүсжээ.

Иймд Бодончар⁷ бол Маалиг баядын хүү гэсэн Бэлгүдэй, Бүгүнүүдэй хоёрын үг үнэн бөгөөд эх Алангоогийн хариулт үнэндээ үүнийг няцааж чадсангүй ээ. Ингэхлээр Боржигин овогийнхон баядын нэг салбар байна.

Бөрт чонын удам Добу мэргэн хүрээд тасарсан гэдгийг шамба (Бямба) "асрагч нэртийн түүх", "Гомбожав тангийн урсгал" мэргэн гэгээний алтан товч зэрэгт дурдсан.

Гэвч Бодончар нь уг удам буюу яс махан талаасаа Бөрт чоноос тасарсан болохоос бус ухаан бодлоос нь тасраагүй төдийгүй харин ч сайн сайхан, тухайлбал амьдралын төлөө нугаршгүй дайчин тэмцэгч хатанзоригт уужуу сэтгэлт гэдгээ хагас жил хиртэй өвсөн нэмбүүл (овоохойд) амьдарч, дараа нь "бие тэргүүн, дээл захат сайн" гээд адангхан урианхайчуудыг оруулж

авснаар харагдаж байна. Цаашдаа монгол олон овогоо нэгтгэн удирдаж хамаг монголын эх үүсвэрийг тавьсан гэдгийг үнэмшихгүй байхын аргагүй. Тодруулж хэлбэл, Бөрт чонын бэхி (ноён) явсан, Бадачийн хан явсан өв уламжлалыг орхиогүй төдийгүй шинэ нэхцэлд улам ч бататган хөгжүүлжээ. Нууц товчоонд хамгийн түрүүнд Хорчи өвгөн "Бодончар богд" гэдэг. Рашид ад-дин, мэргэн гэгээн (Лувсандамбийжалсан) Бодончар хан (хаан) гэсэн.

Иймд Чингис хааны дээд үе нь 23 үе байна. Бөртэ чоноос Добу мэргэн нь 12 үе, 13 дахь үе нь Алангоо хатны Бодончар мунхаг байна. Бодончар мунхагаас Ёсухэй баатар нь 11 үе болж байна.

Рашид ад дины үед удмын мод буюу угийн бичиг, гэрийн үеийн түүхийн хэд хэдэн хувилбар, гэхдээ зөрчилтэй хувилбурууд байжээ.

Рашид ад дин Бөртэ чоноос Ёсухэй баатрыг оролцуулан 18 үе дурдаж 5 үе орхижээ. Рашид ад дин нууц товчоо буюу түүнтэй хамгийн дөхүү Лу.Алтан товчийн эхийг олж үзэж чадсангүй. Юан улсын үед түүхийн хүрээлэнгийн захирал, хааны итгэмжит сайдад хүртэл түүх зохиоход нь нууц товчоог үзүүлээгүй тухай Баяр гуай өгүүлсэнийг сийрүүльв. "Юан улсын Вен зонг Заяат хаан Төв Төмөр 1331 оны дервэн сараас эхлэн "дэлхийг зарчимлах их дүрэм" хэмээх цуврал бичигийг зохиож найруулуулав. Үүнийг найруулуулан бичихэд Чингис хааны үеийн материал дутагдаж байсан учраас ерөнхий найруулагчийн тушаал хариуцсан бичгийн мэргэдийн хүрээлэнгийн эрдэмтэн Юй Жий "улсын бичиг товчооноор өвөг хаан Тайзуугаас инагшийн үйл явдлын нэмэн бичсүгэй хэмээн гүйсан" гүйдал нь хааны зөвшөөрөл олсон боловч бичгийн мэргэдийн хүрээлэнгийн зарлиг хүлээсэн сайд Ташихай "товчооныг гадны хүнээр уламжлуулж үл боломой" (Юан улсын судрын 181-р боть "Юй Жийгийн намтар") хэмээн өгч үзүүлсэн үгүй.(Баяр галиглэв. Монголын нууц товчоон. Тэргүүн. Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо.1998" номын өмнөх үг"). Ийм

учраас нууц товчооны зарим мэдээг түүхчид зөвхөн итгэлт хүний амнаас л сонсож байсан учир тэр нь яг үнэн байх баталгаагүй юм. Ер нь "алтан дэвтэр" нь нууц товчоог мэдэх хүмүүсээр ахин яриулсан нь байж магадгүй. Гэхдээ энд зарим нэг заавар өгсөн байж болзошгүй. I-V Чингис хаан болон зарим хүний угийн бичиг (мод) үз.

I.Чингис хааны угийн товчоон (угийн бичиг (мод), буюу ургийн бичиг)

1.Монголын нууц товчоо (Цэрэнсодном)	2. Лу. Алтан товч	3. Хураангуй алтан товч (Булаг)
1. Бөрт чоно, Гоо марал	1. Бөрт чоно, Гоо марал	1. Бөрт чоно, Гоо марал
2. Батачи хан	2. Бат цагаан	2. Бадай цагаан
3. Тамача	3. Тамачин	3. Тэмүчин (Тамачин)
4. Хорицар Мэргэн	4. Хорицар мэргэн	4. Хорицар (Хорицар) мэргэн
5. Уужим борхул	5. Уужим буурал	5. Уужим буурал
6. Салихачу	6. Сали галзуу	6. Сали галзуу
7. Их нүдэн	7. Их нүдэн	7. Их нүдэн
8. Сэмсочи	8. Сэмсочи	8. Сэмсочи
9. Харчу	9. Харачус	9. Саль галзуу (Харацус)
10. Боржигидай мэргэн Монголжин гоо	10. Боржигидай Мэргэн, Монголжингоо	10. Боржигидай мэргэн
11. Торголжин баян Борогчин гоо	11. Торголжин баян Борогчин гоо	11. Торголчин (Торголжин) баян Борогчин гоо
12. Добун мэргэн Алан гоо	12. Добун мэргэн Алан гоо	12. Добу мэргэн Алун гоо
13.1. Бодончар мунхаг (10)	13. 1. Бодончар мунхаг	13. 1. Бодончар
14.2. Хабичи баатар (9)	14. 2. Хабичи баатар	14. 2. Хабичи баатар
15.3. Мэнэн тудун (8)	15. 3. Бэгир баатар	15. 3. Бигир баатар
16.4.Хачи хүлэг Номуулун(7)	16. 4. Маха тудун	16. 4 Маха түдэн
17. 5. Хайду (6)	17. 5. Хачи хүлэг	17. 5. Хачи хүлэг
18. 6. Байшинхор догшин (5)	18. 6. Хайду	18. 6. Байшинхор догшин
19.7. Тумбинай сэцэн (4)	19. 7. Байшинхор догшин догшин (5)	19. 7. Тумбинай сэцэн
20. 8. Хабул хаан (3)	20. 8. Тумбыхай сэцэн	20. 8. Хабул хаан
21. 9. Бартанбаатар (2)	21. 9. Хабул хаан	21. 9. Бардам баатар
22. 10. Есүхэй баатар (1)	22. 10. Бартан баатар	22. 10. Есүхэй баатар
	23. 11. Есүхэй баатар	

Чингис хааны угийн товчоон 3-6


4. Саган сэцэн Эрдэнийн товч	5. Рашид ад-дин судрын чуулган	6. Дай Юан улсын түүх
1. Бөрт чоно, Гоо марал	1. Бөрт чоно, Гоо марал	

2. Батцагаан Батсанаа
 3. Тамаадаг
 4. Хоричар мэргэн
 5. Уужим буурал
 6. Сали галзуу
 7. Их нүдэн
 8. Сэм сочи
 9. Хали Харчүү
 10. Боржигидай мэргэн
 Монголжин гоо
 11. Торголжин баян
 Борогчин гоо
 12. Дува (Дуя) сохор
 Добун мэргэн
 Алун гоо
 13. 1. Бодончар мунхаг
 14. 2. Хабич баатар (хан язгуурт)
 15. 3. Бигир баатар
 16. 4. Маха тудан
 17. 5. Хачи хүлэг
 18. 6. Байшинхор догшин
 19. 7. Тумбихай сэцэн
 20. 8. Хабул хаан
 21. 9. Бардам баатар
 22. 10. Есүхэй баатар
2. Битеж-Хаан (Батачи хан)
 3. Тимаж
 4. Кигу-мэргэн
 5. Кучум-Бугрул
 6. Их-нидүн
 7. Сам-Сочи
 8. Халы-Хажу
 9. Дубун-баян
 10. Будунжар
11. Буха, Бухтай
 12. Дутумь Мэнэн
13. Хайду-Хан
 14. Бай-санхур
 15. Түмэн-хан
 16. Хабул хаан
 17. Бартанбаатар
 18. Есүхэй баатар
1. Алан гоо
 2. Бодонцар
 3. Хабич хүлэг баатар
 4. Маха тудун Моналун
 5. Хайду
 6. Бай шонхор
 7. Тумбинай
 8. Хабул хаан
 9. Бардам баатар
 10. Есүхэй баатар

Тайлбар:

I. Бухагийн хүү Дутум-мэнэн гэснээс дүгнэвэл Буха нь Бэгир баатар баймаар


II. (Судрын чуулган)



III. (Судрын чуулган)




IV. Монголын нууц товчоо



5. Охин бархаг (6) Хутугту Жүрхи - (7) Сача бэхи, Тайчу
 Барданбаатар (6) Мэнгэт хиан, Нэхүн тайш, Есүхэй баатар, Даридал отчигин
 Сочигил үжин
 Хутуг т у Мөнгүр -> Бүри бөх
 Хутула хаан -> Зочи, Гирмаа, Алтан отчигин
 Хулан -> Их Чэрэн -> Нарийн Гэгээн
 Хадаан
 Тедөгөөн





Инжиннашийн үе залгамж

1. Чингис /1162/
2. Толи эзэн /Тулуй/
3. Хувилай сэцэн хаан
4. Чингим хунтайж
5. Дармабала
6. Буянт хаан
7. Заяат хаан
8. Тогоон төмөр хаан
9. Усхал хаан
10. Хархуцас хаан
11. Ажи тайжи
12. Абараий хаан
13. Хуурцаг хаан
14. Баянмөнх жонон
15. Барсболд хаан
16. Алтангэээн дай юан хаан
17. Сэнгэдуурэн хаан
18. Засаг Бэйс Хүмү ноён
19. Засаг бэйс Гүнчигжав ноён
20. Доржиял ноён
21. Чинбишрэлт ноён
22. Диндов ноён
23. Лхаван норбуу
24. Туслагч Ванчинбала ноён
25. Инжиннаши /1837-1891/ (Хөх судар. Тэргүүн дэвтэр. 18-19-р тал)

Чингис хааны өөд болсон нь

1. Чингис хааныг өөд болсон тухай нууц товчоонд өгүүлсэн нь
2. Хураангуй , Лу. Алтан товч зэрэгт ан агнахад "гоо марал, берт чоно, хөх бор морьтой хар хүн орох" гэсэн нь
3. Чингис хааны нууц оронг гэмтүүлээд Гүрбэлжин гоо зугатан Хар мөрөнд унаж үхсэн нь
4. Шударга хаан, Чингис хаан хоёрыг идтэн болгосон нь

Нууц товчооны 265-р зүйлд "Нохой жил (1226) ийн намар Чингис хаан тангуд иргэнд морилов... Есүй хатныг авч одов... Өвөл Ар бухын олон хулад (хулан) авалбаас... Чингис хаан зост борыг унаж бөлгөө. Хулад даариж ирвээс зост бор үргэж, Чингис хааныг мориноос унаваас, мариан (бие) маш өвдөж Чуурханд буув. Тэр шене хоновоос манагар Есүй хатан өгүүлэрүүн: "хөвгүүд ноёд хэлэллэдүүтхүн (хэлэлцэгтүн). Хаан шене мариа халуун хонов" хэмээвээ." (Элдэндэй 880-р тал)

Чингис хаан шархдаад, хөвгүүд, ноёд хэлэлцээд буцъя гэтэл Чингис хаан "Тангуд иргэн биднийг зүрх ядан харив хэмээхүүн, бид элч... илэж (илгээж) ... үгий нь ухаж ... ицаваас (няцваас, буцваас) болжээ." (880-881-р тал) гэв. Үнэхээр элч илгээтэл "Аша Гамбу (Хамба) өгүүлэрүүн Дайранхуй үгэс би өгүүллээ. Эдүй бээр бөөсү (бөгөөсү) та монгол хадхалдаа сурч хатхалдсу гэвээс би... Алашай зорьж надур ирэгтүн, тэнд хадхалдъя" гэжээ. (881-р тал) "Энэ үгийг Чингис хаанаа хүргэвээс, Чингис хаан мариа халуун аруун (байруун, байхад) өгүүлэрүүн "Же дели (тийм), ийм их үг өгүүлүүлж хэр ицагдахуй (буцахуй), үхэрүүн (үхсэн ч) үг дор шахаж явъя" хэмээж "мөнх тэнгэр чи мэд" хэмээн Чингис хаан Алашаас зорьж хүрч, Аша Гамбаг авч тэрэм гэрт, тэмээн ачаат иргэнийг нь үнэсээр хийстэл (881-тад) талуулж (олзолуулж) ... цэргийн хүнийг "баригсаар (барьснаан) ологсоор (олсноон) авагтун" хэмээн зарлиг болов" (882-р тал) Ийнхүү Чингис хаан мориноос унаж бэртэж бие нь олон хоног халуурч

байсан ч Аша Гамбын их угэнд эрс дургүйцэж эр зориг гаргаж цэргүүдээ тулалдуулж ялжээ. Аргагүй л цэргийн их жанжны уг, үйл мөн дөө. "Тангуд иргэн уг өгүүлж, угэндээ үл хүрэхийн тул тангуд иргэнд Чингис хаан аялан моходгож (мохоож) ирж гахай жил (1227 он) Чингис хаан тэнгэрт гарав" (268,898-р тал) гэдэг.

Хураангуй алтан товчид "Гахай жилд эзэн богд Есүй хатныг авч мордон" (Хураангуй алтан товч. Өвөрモンголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1989 номын 65-р тал) гэж байгаа нь тангуд улс уруу довтолсныг өгүүлсэн биз. Хангай ханд их ав талбихуйдаан зарлав. "Бөрт чоно, гоо марал орох буй, түүнийг бүү ал. Хөх бор морьт бужигар үст хар хүн орох буй. Түүнийг амьд барь" (66-р тал) гэж үнэмшихийн аргагүй эйл өгүүлдэг. Чоно, буга орохын хажуугаар хүн орно гэдэг юу гэсэн уг вэ? "Хөх бор морьтыг барьж, чи "хэнийх буй" гэж асууваа. Дуун эс гарав. Эзэнд авч ирж өгөв. Эзэн асуув. "Монголын богд эзэн цэрэг мордов гэж Шударга хаан харуул гаргаж билээ. Хөлт моринд үл гардах, Хөсболд хөх бор гэгч билээ. Гүйцэгдэв. Дөрвөн таваг минь хувирахуй болов. (67-р тал)" гэсэн.

Тэр тангуд улсын оруулж... лууван хааныг зусаж, түрэмгий балгасунаа богд эзэн хүнд хала хучиж (халууцаж) алтан амиан гархуй цагт" (73-р тал) гэсэн. Яагаад халуурсныг бичсэнгүй ээ. Гүрбэлжин гоо хатныг автал тэр хатан "өнгө минь таны цэргийн тоосонд хиртэв." (71-р тал) усанд орья гэж Чингис хаанаас зөвшөөрөл авч яваад усанд үхсэн гэдэг Лу. Алтан товчид Эс хамбыг (Аша Гамбыг) барьж, ... иргэнийг нь үнсээр хийстэл талвай. (124-р хуудас, эхний нүүр) гэсэн. Шар туужид "Гүрбэлжин гоо хатан нууц орон даан химхис хавтүүлж эзний нууц орон гэм болгоод дутааж хар мөрөнд унаж үхвэй ... Тэндээс эзний чилээ бэрхдэн амь нь ойртохуй дор" гэж бичсэн (Шара туджи. Монгольская Летопись XVII века М. Л. 1957" номын 34, 35-р тал)

"Динг (улаагчин) гахай жил ... тангуд улсад морилон орох зуур хангай ханыг ав талбин бүхүйд эзэн ... гоо марал, ... бөрт чоно орох ... бүү аладхун... Хөх бор морьтой хар хүн оромуй" (Саган сэцэн . Эрдэнийн товч 1961. УБ номын 121-р тал) гэж өмнө өгүүлсэнтэй адил өгүүлээд "Гүрбэлжин гоо хатан биеэ ухиан (угаан) харьж ... шөнө умтагсан хойно эзний алтан биед гэм болсноор ... эзэн чилээ бэрхдэн амь нь ойртохуйд.. " 126, 127-р тал) гэсэн.

Сия (тангуд) улсыг тогтоогоод буцаж намар нь Хөх хияны доорд мөрнөө буусанд хааны сүрээр чилэвэй, ... гэрээс зарлиг болж хальсан (Лубсандамбийжалсан Алтан товч. Өвөрмонголын Соёлын хэвлэлийн хороо 1998" номын 64-р тал) гэсэн.

"Зарим бичигт... Гүрбэлжин гоо хатныг асарсанаас хумсаар нууц дор хуулж гэм болбой хэмээжүхэй" (Дармаа. Алтан хүрдэн мянган хигээст Өвөр монголын Ардын хэвлэлийн хороо 1987" номын 82-83-р тал) гэсэн.

Рашинпунцаг болор эрихдээ "Чингис хаан ... Гүрбэлжин гоо хатныг асарсан шалтгаанаар халив хэмээжүхүй. (Болор эрих. Өвөр монголын Ардын хэвлэлийн хороо 1985" номын 139-р тал) гээд шүүмжлэн "Хэрэвдээ Гүрбэлжин гоо хатны учраар хальсан нь үнэн л бөгөөс хятадын судар хийгч мэргэд нарийвчлан гаргаж тэмдэглэлтэй ажи" (136-р тал) Энэ болон ... Хасрын догшин sumaар тэднийг (шударга хааны цэргийг) хядсан ... зэргийн хэрэг цөм худал хуурмаг нь маш илэрхий (136-р тал)

"Шударга хааны хатан Гүрбэлжин гоог биедэн аван атал ... тэр бээр муу сэтгэж (сэтгэвч) очижүүхэн хөнөөлийг үйлдэвч хорлон эс чадаад ... түүндээн гэмшиж өөрөөн дутаан... хөр мөрөнд унаж үхэв" (Хөх түүх. Өвөрモンголын Сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо. 1996" номын 52-р тал) гэсэн.

"Чингис эзний бие морьноос шилжсэн учраа бага чилээрхсэн боловч ... улаагчин гахай жил тангуд улсад морилон одох зуур ... гоо марал, бөрт

чоно ... хөх бор морьтой хар хүн ..." (Галдан Эрдэнийн эрх. Өвөр монголын Ардын хэвлэлийн хороо 1999 " номын 138-р тал) гээд "Гүрбэлжин гоо хатан бээр Чингис хаанаа муу санаж өчүүхэн хөнөөл үйлдэвч хорлон эс чадаад түүнээ гэмшиж хар мөрнөө унан үхвэй. (139-р тал) гэсэн.

"Чингис эзнийг шударгын хатан хороовой хэмээдэг... нь Султан хааны Үнэгэн хэмээгч нэгэн нялх хөвгүүнтэй ирснийг хавт Хасар хатан болгон авсан ажгуу. Тэр Үнэгий өчүүхэн хөвгүүн бээр урьд эцэг Султан ханыг алсан ба тэжээсэн эцэг Хасарынг худдулагсан (худганд хорьсон) хоёр бүрд Чингис эзнээ өслөн тийм муу алдарыг тархаасан хэмээмой" (Жимбадорж Болор толь. Үндэстэний хэвлэлийн хороо.Бээжин 1984" номын 422-р тал)

Шарын шашны үүднээс төвд (тангудыг эзлэнэ гэдэг тэр тусмаа хааныг нь бурхан гэдэг байхад үнэмшихэд бэрх байсан биз. Тийм ч учраас ав хийснийг мушгин гүйвуулж гоо марал, бөрт чоно, хүн гурвыг оруулж, тэр хүн нь шударга хааныг "өглөө могой болох, түүнд барьж үл болох үдэд хүрэн эрээн барс болох түүнд барьж үл болох, үдэш гоо шар хөвгүүн болж хатан лугаа наадаж суух буй. Түүнд барьж болох гэж хэлэв" (Лу. Алтан товч. УБ 1990" номын 123-р хуудасны арын нүүр) гэсэн ба "эмгэн монголын цэргийг угтан ирээд эр агтадыг харааж үхүүлбэй. (мөн нүүр) гэсэн. Худагт хорьсон Хасарыг гаргаж харвүүлж тэр эмгэнийг алуулсан (Хасараас өөр хүн харваж алж чадахгүй гэж) гэсэн. "Шударга хааныг могой болсон цагт эзэн (Чингис хаан) гар्यд болов. Барс болсон цагт нь эзэн арслан болов. Хөвгүүн болсон цагт нь эзэн өвгөн болж баривай. (124-р хуудас эхний нүүр) Та миний уландор гурав хугасхийж эвхсэн эрээн хошлон буй. Түүгээр боож ал гэв... Гүрбэлжин гоо хатныг минь хар хумснаас эхлэн бүгдийг нэгжидгүн хэмээгээд үхвэй. Эзэн богд Гүрбэлжин гоо хатныг авбай: (124-р хуудасны арын нүүр) гэв. Ийнхүү нууц товчоог

үлээмж ашигласан Лу. Алтан товч шашны нэлээнд автан, Хасарыг өмөөрөх үүднээс мушгин гүйвуулжээ.

Нэхөр болох шударга хаан нь алуулсан, тангудуудад их хатуу хандсан тул Гүрбэлжин гоо хатан зугатан хар мөрөнд унаж үхсэн байж болно(үүнээс хойш хатны гол гэсэн гэдэг). Харин Гүрбэлжин гоо хатныг авахын төлөө тангудтай байлдсан гэдэг худал юм.

Нууц товчоонд бичсэн нь ёстой илүү ч үгүй, дутуу ч үгүй үнэн байх нь ээ. Итгэхээс өөр арга алга.

2000.VII.14

Монголын нууц товчоог бичиж дууссан оны тухай

(Монголын нууц товчоог бичиж дууссан оны тухай мэдээ нууц товчооны төгсгөл, тодруулж хэлбэл 282-р зүйлд "Их хуралд хуриж (хурж) хулгана жил хуран сард Хэллүрэний (Хэрлэний) Хөдөө аралын Долоон болдог, Шилхинцэг хоёр зуураа ордос (олон ордон) бууж, бүхүй дор бичиж дуусба" гэсэн. (Элдэндэй, Ардажав) Монголын нууц товчоон-сийрүүлэл, тайлбар. 1986 номын 972-р тал)

Хөдөө арал бол Тэмүжиний хаан суусан газар гэдгийг Хураангуй алтан товч, Лу.Алтан товч, Асрагч нэртийн түүхэнд Гилүгэдэй баатрын Чингис хааны шарил ачсан тэргийг шаварт суухад шүлэглэн хэлсэн үгэнд "Хэрлэний хөдөө аралаа хан суусан газар чинь" гэж (Лу.Алтан товч. УБ.1990, Монгол бичгээр,127-р хуудасны эхний нүүр) дам өгүүлсэн Шар тууж, Эрдэнийн товч, Хөх түүх, Болор толь, Эрдэнийн эрихэд шууд "Хөдөө аралд" хан суусан гэсэн. Энэ бол Тэмүжиний Хамаг монгол аймгийн хаан болсон газар. Бас Өгэдэй хааны хан суусан газар болно. Иймд хөдөө арал бол хааны ордон буудаг газар байна. "Хуран сарыг" 7 дугаар сар гэж үздэг.

Энд дурдан байгаа хулгана жилийн махбод буюу өнгийг заагаагүй тул 1228, 1240, 1252 зэрэг онуудаас олж тогтоох хэрэгтэй байна.

Нууц товчооны 269-р зүйлд "Хулгана жил Чагадай, Бат тэргүүтэн баруун гарын хөвгүүд, Отчигин ноён, Егү, Есүнгэ тэргүүтэн зүүн гарын хөвгүүд, Тулуй тэргүүтэн гол хөвгүүд, охид, хүргэд, түмэтийн, мянгатын ноёд бүрэн болж, Хэлүрэний Хөдөө аралаа гүрээр хуриж Чингис хааны .. зарлигаар Өгүдэй (Өгэдэй) хааныг хан өргөвэй" гэж бичсэн. (Өмнө дурдсан Элдэндэй гуайн номын 891-р тал) Энд өгүүлж байгаа хулгана жил нь шороо буюу шар хулгана жил гэдэг нь тодорхой. Чингис хааныг оршуулаад буйр сэлгэн хааны олон ордон (ордос) буугаад их хуралдай (хурал) хуралдажээ.

Ийнхүү 1228 он буюу шороон хулгана жил нь 282-р зүйлд заасан нехцел бүрэн тохирч байна. Ингэхлээр 1228 онд нууц товчооны Чингис хааны хэсгийг бичиж дуусжээ. Чингис хааны хэсгийг анх эхэлж бичсэний бодит гэрч нь "Лу.Алтан товчид: Нууц товчооны зөвхөн Чингис хааны хэсэг байдаг явдал юм. "Цэндийн Хандсүрэн. Цэнд гүн ба Монголын нууц товчоо.УБ.1997" номын 40 дүгээр талд "Юан улсын нууц түүх 10 дэвтрийн гадна бас дараа зохиосон хоёр дэвтэр" гэсэн. Энэ бол Е Дэхүйн 1908 онд барласан "Монголын нууц товчооны" оршил болно.

Чингис хааны хэсгийг 1228 онд бичиж дууссан гэдэг саналыг анх хятадын түүхч Дин Цянь гаргажээ. Японы З.Ишхама (1940 онд), Т.Кобаяси (1954 онд), С.Уемура(1955), австралийн И де Рахевильц (1965), өвөр mongолын И.Иринчин (1984), Ш.Гаадамба (1988), Америкийн Ф.И.Кливэз нар мөн энэ саналыг дэмждэг байна. "Mongolica K750 летию "Сокровенного сказания.М."Наука. 1993" номын 49 дүгээр талд германы М.Таубе "магадгүй бид, 12 жилээр хоцорсон биш биз" гэж 750 жилийн ойд зориулсан өгүүлэлдээ бичсэн.

Төвдийн түүхч Гунгаадоржийн 1346 онд бичсэн "Улаан дэвтэрд" дурдсан

"Их товчоон" бол Нууц товчооны Чингис хааны хэсэг буюу Чингис хаан, Өгэдэй хоёрын хэсгийг нийлуулсэн нь байж магадгүй.

Өгэдэй хаан улаан бичин жил (1236 он) "Есөн зүйлийн шастирыг сайтар орчуулан бичүүлээд, өмнөөн уншуулж ялган айладбай (Есөн зүйлийн шастир хэмээгч Цжи си-ийн бичсэн Жүнг бичиг буй)" Тэдүй эрхин түшмэдийн хөвгүүд ач нар дор шастир бичгийг сургуулаад хууль ёсыг ялган өгүүлж, бодгосын явдлыг ухуулан, Биян Шиу Со нэрт яамныг .. Жинг жий Со яамныг байгуулбай. Түүнээс улам бичгийн төр мандлуугаа" ("Дай юан улсын түүх" Бээжин. 1987 номын 100-р тал) гэсэн. Ийнхүү Өгэдэй хаан хятадын түүх шастирыг сонирхон уншуулж, хүүхэд багачуудад ялган тайлбарлаж байсан юм чинь эцэг Чингис хааны түүхийг бүр ч илүү сонирхож байсан нь мэдээж хэрэг. Нэг үгээр хэлбэл, Өгэдэй хаан суурин орны (тухайлбал Алтан улсын) териин бодлогыг авч хэрэгжүүлж байсан хэрэг. Засгийн хэргийг ерөнхийлэн шийтгэх "Чжүншү.шэн" яамыг 1231 онд багуулж хидан Елжий Чуцайд хариуцуулжээ. Женхайг (Чингай) баруун гарын түшмэл болгожээ. (Өмнө дурдсан номын 88 дугаар тал) Чингай нь бичиг хариуцсан бөгөөд сударч (зарлиг, ер өдөр тутмын явдал, түүхийг бичигч буюу эрхлэгч) түшмэл байсан бололтой.

1240 онд Бат, Гүюг, Мөнх тэргүүтэй гол ван, түшмэдүүд өрнөдөд (орос, польш зэрэг оронд) байлдаж байсан ба бас урагшаа Сүн улстай ч байлдаж байсан тул энэ цагаан хулгана жил (1240) их хуралдай хуралдах боломж ч үгүй, шаардлага ч үгүй юм. Бас Өгэдэй хааны амьд байтал хааны түүхийг "бичиж дуусав" гэж бичих боломжгүй юм.

1241 онд "Хаврын дундад сар дор Тайзунг хаан авад одоод хүндэд чилээрхсэн дор эмч үзээд өгүүлэрүүн: амины судал буурчухуй хэмээхүй дор хуангхэу Наймалжин ихэд айж Елжий Чуцайг авч ирээд асуубаас ... айладхарун: Эдүгээ ер шунахай муу хүмүнийг хэрэглэсний тулд тэд цол

баан худалдаж эд таваарыг авумуй. Жич бас баригдсан ял үгүй иргэн олон буй. Эртний хүмүний өгүүлсэн ану нигэн сайн үг өгүүлбээс муу ер гараму (гармуу) хэмэчхүй. Эдүгээ дэлхий дахины эрүү дор оруулсныг гаргаваас зохимуу хэмээвээс хуангхэу зөвшөөж гаргатугай хэмээхүй дор Елюй Чуцай дээд эзний зарлиг үгүй бөгөөс үл болмой хэмээхүй дор мөн тэдүй хааны чилээн өчүүхэн амус хийбэй. Елүй Чуцай орж эрүүтэнийг гаргасугай гэж айладхаваас хаан зарлиг болж үл чадан толгой баан гэгэлүгээ. Тэр шөнө эмч мөнхүү үзвээс амины судал сайн болжуухий ... Өвлийн дундад сар дор тайзунг хаан авалаар (ав хийхээр) одсугай хэмээхүй дор Елюй Чуцай дай и одоныг тоолж үзээд авлаваас үл зохимуу хэмээвээс (111, 112-р тал) хааны дэргэдэх нөхөд харвах намнахыг ятгах бөгөөс жаргалт бус хэмээв. Тэдүй хаан авлаар одоод ... одо ла хе ман (Абдурман) нэрт түшмэл дарс авч ирсэнд хаан шөнө дөл болтол зоогловой. Тэр шөнө үүр гийхүй дор хаан төрөл өгүтгэв. (138-р тал)" гэсэн. Харагчин туулай жил (1243 он) зуны дунд сар дор .. одо ма хегийн (Абдурманы) ялган өгүүлснийг сударын бичээч нар судар дор эс бичвээс гарыг нь огтолмуй хэмээхүй дор Елюй Чуцай өгүүлэрүүн: урьд хааны улсын төр бүгдийг өтэхү (өтөл) түшмэл дээн надур тушаасан бөлгөө. Сударын бичээчийн дор юун хабийа (хамаа) үйлийг ёсоор зохилдуулваас аюул үгүй, өөрийн зоригоор явмуй за. Хэрэв ёсон лугаа эс зохилдоос бээр үхэхүйгээс үл аюун бөгөөтөл гар огтлохуй дор хэр аюуму хэмээвээс хуангхэу үл зөвшөөрөхүй дор Елүй Чуцай их дуунаар өгүүлэрүүн: "өтэхү (өтөл) түшмэл би тайзу, тайзунг хаан дор хүчин өгч гучин илүү жил болтол хоёр сэтгэл барьсан үгүй. Эдүгээ намайг гэм үгүй бөгөөтөл алаж хэр болох хэмээв" (114-р тал)

1243 он гэхэд Өгэдэй хааны түүхийг бичээд дуусаж байсан ба харин нас барсныг бичих л үлдээд байжээ гэсэн дүгнэлт хийж болох юм.

Учир нь Наймалжин хатан судрын бичээчээр Өгэдэй хаан нас барсныг Абдурманы хэлснээр бич гэж Елюй Чуцайд тушаасан байна. Гэтэл Елүй Чуцай Өгэдэй хааны нас барсан талаар Абдурманы ялган хэлснийг хүлээн зөвшөөрөөгүй тул Наймалжин хатны зарлигийг эсэргүүцэж үл биелүүлжээ. Ингээд хөх луу жил буюу 1244 онд Елюй Чуцай ч нас барж товчоонд ч гар хүрээгүй бичигдсэн байдлаар нь хадгалсан бололтой. Чухамдаа Өгэдэй хааны хэсгийг бичиж дууссангүй, 1240 он буюу түүнээс өмнөх байдлыг бичсэнээр орхижээ. Нас барсныг бичихийн оронд 4 сайн үйл, 4 буруу үйл үйлдсэнийг нь бичсэн бололтой. Нас барсныг эс тооцвол Монголын нууц товчоон 1243 он буюу түүнээс өмнө бичиж дууссан гэж үзэж болох юм. (Монголын нууц товчоог хятадын Бао Тинбо (1805 онд), оросын И.П.Кафаров (1866 онд), хятадын Ли вэнь-тянь (1896 онд), японы Н.Мичиё(1907 онд), Ш.Хаттори (1940 онд), зөвлөлтийн С.А.Козин (1941 онд) Ц.Дамдинсүрэн (1947 онд), түргийн А.Темир(1949 онд), германы Э.Хэниш(1950), чехийн Поуха(1956), Х.Пэрлээ (1957 онд), японы Ш.Ивамура(1963 онд), Ш.Бира(1978 онд), Өвөр монголын Баяр (1981 онд) гуай нар 1240 онд бичсэн гэжээ) Монголын нууц товчоо нь монгол хүний монголоороо бичсэн Чингис хаан, Өгэдэй хаан хоёрын товч хураангуй нууц (иймд үнэн) түүх юм.

Гүюг хаан 1246-1248 онд хаан ширээнд суусан ба Мөнх хаан 1251-1259 онд хаан ширээнд суусан.

Хувилай хааны зарлигаар Өгэдэй хааны түүхийг шинээр бичүүлж Гүюг хааны түүхийг хэрэг дээрээ орхиж, харин Мөнх хааны түүхийг шууд ил түүх болгон бичүүлжээ. "Дай юан улсын түүх, Бээжин. 1987" номын 293-р талд Жи юаны 25-р он (1288 онд) "Хаврын дундад сард се му цолт Са ли маны зэргийн түшмэд хааны өвгэдийн магад хуулийг дуудаар орсонд Шизу хаан зарлиг болтуун, тайзунг хааны (Өгэдэй) явдлыг бичсэн нь үнэн, руйзун

(Тулуй) хааны явдалд өчүүхэн сольжухуй. Динзунг хааны суусан нь эс удлаа. Түүнд юу өгүүлмү. Сиянзүн хааны явдлыг та эс мэдсэнээс бус мэдэх хүнээс асууваас зохимой хэмээв" гэсэн. Мөн жи юаны 27 дугаар онд (1290 онд) "Се му цолт салиман, хан лин Юан яамны Сиюу ши цолт Улудэй тайзунг хааны магад хуулийг өргөлөө" (өмнө дурдсан номын 295-р тал) гэсэн. өмнө нь тайзунг (Өгэдэй) хааны магад хууль, тодруулж хэлбэл: түүхийг үнэн бичжээ гэсэн атал энд ахиад өргөлөө гэдэг нь сонин. Өгэдэй хааных бус харин сиянзунг Мөнх хааны түүх байж магадгүй. Хувилай хааны хөдөө аралд очиж албан хэрэг явуулсан түүхийн баримт харагдахгүй ба үнэндээ ч Хувилай хаан Хөдөө аралд тухлах нүүргүй буй заа. Иймд Монголын нууц товчооныг 1264, 1276, 1288 онд Хөдөө аралд бичиж дууссан гэж хэлэхгүй ээ. Харин Мөнх хааны үед 1252 онд бичсэн тухай баримт харагдахгүй байна.

2001.IX.2

Иш татсан номын жагсаалт

I. Монголын нууц товчоо

1. Цэндийн Хандсүрэн. Цэндгүн ба Монголын нууц товчоо (Цэнд гүнгийн орчуулсан "Монголын нууц товчооны" гар бичмэл эх) УБ.1997. 646тал.
2. Монголын нууц товчоо. Хуучин монгол хэлнээс одоогийн Монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав. IV хэвлэл. 1990. Анх 1947 онд монгол бичгээр Улаанбаатарт хэвлүүлжээ. (редактор Ш. Нацагдорж) 256 тал.1957, 1976 онд кирил бичгээр хэвлүүлжээ. Өвөрモンголд 1957 онд хэвлэсэн.
3. а. Монголын нууц товчоон. Тэргүүн Дэд. Баяр галиглэв. Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо.II хэвлэл.1998. Анх 1980 онд 3 ботиор хэвлүүлжээ.
6. Монголын нууц товчоон. Монголын үндэстэний эртний уран зохиолын цуврал бичиг. Баяр гуай (3-200-р тал), Ц. Дамдинсүрэн (201-496-р тал) гуай хоёрын орчуулга. Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо 1997.
4. "Монголын нууц товчооны" харгуулан хянасан дэвтэр. Хуасай Дугаржав. Өвөрмонголын Соёлын хэвлэлийн хороо 1984. 274 тал.
5. Монголын нууц товчоо. Латинаар галиглаж хэвлүүлсэн Т. Дашицэдэн. УБ. 1985. 216 тал.
6. Монголын нууц товчоон. Шинээр орчуулж тайлбарласан Мансан. Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо 1985. 494 тал.
7. Монголын нууц товчоон-сийрүүлэл тайлбар. Элдэндэй, Ардажав сийрүүлж тайлбарлав. Өвөрмонголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо 1986.1046 тал (1-115 удиртгал, 1-974. Монголын нууц товчоон-сийрүүлэл тайлбар, 975-1031 хүн, овог, газрын нэрийн хэлхээс (монгол, хятад латин бичгээр бичсэн), 1031-1044 ашигласан номууд).
8. Монголын нууц товчоон. Ихэмянгудай Иринчиний сэргээлт. Өвөрмонголын Их сургуулийн хэвлэлийн хороо. 1987. Хөх хот. 288 тал.
9. Монголын нууц товчоо. Б. Сумъяабаатар. Үсгийн галиг. УБ. 1990. (Хятад галигийн хамт Ширатори Куракицийн латин галиг, худам монгол сийрүүлгийг нэг дор оруулсан.) 968 тал.
10. Монголын нууц товчоон. Худам (язгуур эртний) монгол бичгээр монгол бичиг, утга судлалын үүднээс Ш. Гаадамбын төсөөлөн нягталж сэргээсэн сийрүүлэг эх, тайлбар. УБ. 1990. (1-216 нь монголын нууц товчооны сийрүүлэг, 218-416-р тал нь "зарим уг, хэллэгийн тайлбар (691 уг тайлбарласан).
11. а. Монголын нууц товчоон"-ы орчуулга тайлбар Д. Цэрэнсодном. Үндэстэний хэвлэлийн хороо. Бээжин. 1993. 548. тал.
6. Монголын нууц товчоо. Эрдэм шинжилгээний орчуулга. тайлбар. УБ. 2000. (5-28 оршил, удиртгал, 29-189 нь Монголын нууц товчоо (орчин цагийн монгол хэлний орчуулга) 190-366 нь уг хэллэгийн тайлбар (707 уг, хэллэг), 367-376 нь тайлбарласан уг хэллэгийн хэлхээс, 377-386 нь ном зүй.

II. Монголын болон гадаадын түүхэн сурвалж, орчин үеийн номын жагсаалт

1. Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл. Г. Асралт, Хөх-Өндөр харгуулан орчуулав. *Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо*. 1985.
- 1-59-р тал нь "Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл." 60-94-р тал нь орчуулгын тайлбар, 95-156-р тал Чжао Хуны "Монгол татарын тухай бүрэн тэмдэглэл" 159-252-р тал нь Пэн-Даяагийн "Хар татарын тухай хэргийн товч", 257-380-р тал нь Сяо Да Хенгийн "Монгол зан суртахууны тэмдэглэл" бас "Монгол үе залгамж" хавсаргасан.
2. Жүвэйни. Дэлхийг байлдан дагуулагчдын түүх. Дээд. Алтанбагана нар орчуулав. *Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо*. 1989. 556 тал
3. а. Рашид ад-дин. Сборник. Льтописей. История монголовъ История Чингизхана до восшествія его на престоль. СПб. 1868.
б. Судрын чуулган. Орчуулсан Ц.Сүрэнхорлоо. УБ. 1994.
4. Дай Юан улсын түүх. Дудин, Өлзийт нар орчуулав. *Үндэстний хэвлэлийн хороо*. Бээжин. 1987. 672 тал. Монгол тулгар бичгийн цуврал.
5. Дай Юан улсын бичиг. Дудин нар орчуулав. *Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо*. 1987. 642 тал.
6. Хадын үндсэн хураангуй алтан товч. Булаг харгуулан тайлбарлав. *Өвөрモンголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо*. 1989. Монголын тулгар бичгийн цуврал. 441 тал.
7. а. Шар туджи. Монгольская летопись XVII века. Сводный текст перевод, введение и примечания Н.П. Шастиной. М.Л.1957. 168 тал.
б. Эртний монголын хаадын үндсэн их шар туж оршив. Өлзийт эмхэтгэн харгуулан тайлбар хийв. *Үндэстний хэвлэлийн хороо*. Бээжин. 137 тал.
8. а. Лувсанланзан. Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч оршвой. Оршил бичсэн Ш.Бира.УБ.1990.178.хуудас.
б. 1937 онд хоёр дэвтэр болгон анх хэвлүүлсэн. 1957, 1990 онд Ц.Шагдар гуай орчуулан кирил үсгээр хэвлүүлсэн.
9. Саган сэцэн. Эрдэний товч. У.Насанбалжир хэвлэлд бэлдэв. УБ.1961.
10. а. Бямба (Шамба). Асралг нэртийн түүх. Х.Пэрлээ хэвлэлд бэлдэв. УБ. 1960.
б. Асралг нэртийн түүх. Багана харгуулан буулгаж тайлбар хийв. *Үндэстний хэвлэлийн хороо*. Бээжин. 1984. 319 тал. Монгол тулгар бичгийн цуврал.
11. а. Гомбожав Гангийн урсгал. Чойжи тулган харьцуулж тайлбарлав. *Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо*. 1984 (Хоёр дахь хэвлэл) 180 тал.
б. Гомбожав. Чингис эзний алтан ургийн түүх. УБ. 1992 хуучин монголоос кирилл бичигт буулгасан Г. Билгүүн. УБ.103 тал. Анхны хэвлэл нь 1981 онд гарчээ.
12. Ломи. Монголын боржигид овгийн түүх. Нагуусайнхүү, Ардажав тулган харьцуулж тайлбарлав. *Өвөрモンголын ардын хэвлэлийн хороо*. 1989. 403 тал. Хоёрдахь хэвлэл 2000 он. Монгол тулгар бичгийн цуврал.
13. Дармаа. Алтан хүрдэн мянган хигээст. (Есөн зүйл бүлэгт алтан урагтны тод түүх, алтан ястны сэтгэлийн цэнгэл буюу алтан хүрдэн мянган хигээст хэмээх бичиг). Чойжи тулган харьцуулж тайлбарлав. *Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо* 1987. 504 тал. Монгол тулгар бичгийн цуврал.

14. А. Лувсандамбийжалсан. (Мэргэн гэгэн) Алтан товч *Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо*. 1998. 278 тал.
- Б. Балданжапав. Altan tobchi Монгольская летопись XVIII в Улан-Үдэ. 1970.496 тал (Их Монгол улсын үндэсний алтан товч).
15. Ната. Алтан эрих. (Монгол оронд шашин, төр тогтсон ёсыг сайтар өгүүлсэн тунгалаг ухаант залуусын хоолойн чимэг тунамал гэрэлт алтан эрих). Чойжи тулган харьцуулж тайлбарлав. *Өвөр монголын Ардын хэвлэлийн хороо*. 1991. 354 тал.
16. Хөх түүх. Булаг тулган харгуулж тайлбарлав. *Өвөрモンголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо*. 1996. 589 тал. Монголын тулгар бичгийн цуврал
17. Галдан. Эрдэнийн эрих. Э.Ардажав тайлбарлав. *Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо*.1999.660 тал.
18. Жамбадорж. Болор толь. Лю жен со тулган харьцуулж тайлбарлав. *Үндэстний хэвлэлийн хороо*. Бээжин. 1984.589 тал. Монголын тулгар бичгийн цуврал.
19. Инжиннаш. Хөх судар (Их Юан улсын мандсан төрийн Хөх судар). *Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо*. Тэргүүн дэвтэр. 1-682 тал. Дэд дэвтэр.683-1361. Гутгаар дэвтэр. 1363-2618 тал.
20. Доссоны Монголын түүх. Нэг. Асралт, Эрдэнэтэгс орчуулав. *Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо*. 1988. 398 тал.
21. Ойрад түүхэн сурвалж бичиг. *Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо* 1985.
22. Г.Е.Грум-гружимайло. Западная монголия и урянхайский край. Том II 1926.Л.
23. А.Амар Монголын товч түүх. УБ. 1935.
24. БНМАУ-ын түүх. 1954. 1984. (турав дахь хэвлэл.)
25. Ц.Дамдинсүрэн. Монголын уран зохиолын тойм. УХГ.УБ. 1957. 160 тал.
26. БНМАУ-ын түүх I боть. УБ. 1966. 499 тал.
27. Ш.Бира. БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд.ШУАХ.УБ. 1977
28. Монгол татарууд Ази-Европод. УБ. 1984. 574 тал.
29. Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд дэвтэр. *Өвөрモンголын ардын хэвлэлийн хороо*. Хоёр дахь хэвлэл. 1991.II. 668 тал (Анхны хэвлэл 1987 он).
30. Чингис хаан. Хубилай хаан. Кацуфуки Такайси, Дэлгэрцогт нар орчуулав. *Өвөрモンголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо*. 1987. 448 тал. Монголын тулгар бичгийн цуврал.
31. Ч.Хишигтогтох. Монголын эртний утга зохиолын судлал. *Өвөрモンголын соёлын хэвлэлийн хороо*.1988.
32. Д.Цэрэнпил, Б.Сэргээ. Монголын нууц товчооны ном зүй, судлалын тойм. УБ.1990.128 тал.
33. Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг. УБ. 1991. 334 тал.
34. Л.Хурцбаатар. Ч.Үзэм. Монголын бөө мөргөлийн тайлга, тахилгын соёл. *Өвөрモンголын Соёлын хэвлэлийн хороо*. 1991. 430 тал.
35. "Монголын нууц товчооны" судлал. *Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо*. 1991. 740 тал.
36. Mongolica. К 750 летию "Сокровенного сказания" Наука. М. 1993. 344 тал.
37. Ч.Далай. Монгол улсын түүх. Их монгол улс. 1206-1260. Дэд дэвтэр. УБ.

- 1994.258 тал.
38. Ж.Болдбаатар. Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэсэн паян. УБ. 1994.
 39. "Монголын нууц товчоо"ны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал. I.УБ. 1995. 307 тал.
 40. Большая советская энциклопедия. М. Том 29. 1978.
 41. Советский энциклопедический словарь. М.1985.
 42. Оксфордская иллюстрированная энциклопедия. Том 3. "Весь мир".1999.
 43. Я познаю мир. Иллюстрированная история с древнейших времени до XVIII века. Энциклопедия. АСТ. 1999.

III. Монгол хэл, толь бичиг

1. Б.Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Дэд дэвтэр. Авиан зүй. ШУАХ. УБ. 1966. 407 тал.
2. Хорин нэгтийн тайлбар толь. (1716 он) Өвөрモンголын Ардын хэвлэлийн хороо. 1979.855 тал.
3. Монгол угний тайлбар толь. Шагж найруулан зохиов. Үндэстний хэвлэлийн хороо. Бээжин. 1994.934 тал .
4. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.1966.912 тал.
5. Б. Ванжил. Хөх тулхүүр. Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1987. 698 тал .
6. Хорин наймтын тайлбар толь. Намжилмаа эмхлэв. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 1994. 2014 тал .

Эхийг “ТЕКТОНИК” ХХК-д бэлдэв.



* 0 2 0 6 5 6 9 4 *

83,3/5мо/П-915

1. 880 жил, Чингис хааны мэндэлсний
849 жилийн ойд

Оюут Овогтой Д.Пүрэвдорж

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ ТАЙЛБАР

- * Барт чоно, Гоо марал хоёр түүхэн хүн болох нь
- * Чингис хааны тэрсэн он, сар, өдрийг батлан
өгүүлэх нь буюу Чингис хааны гурван чухал он
- * Чингис хааны тэрсэн жил зэрэг чухал он, үйл
явлын товчоон
- * Есухай баатар хан болох нь
- * Тэмүжин Хамаг Монгол ба Их Монгол улсын хан болсон нь
- * Чингис хааны угийн мод
- * Монголын нууц товчоог бичиж дууссан оны тухай